# ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТЕХНОЛОГИЙН ДЭЭД СУРГУУЛИЙН ХАРЬЯА ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

**2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**ӨМНӨГОВЬ АЙМАГ**

**ДАЛАНЗАДГАД ХОТ 2025**

**Хянасан:**

**Захирал Ч.Эрдэнэтуяа**

**Тайлан боловсруулсан :**

**Сургалтын алба**

**Захиргаа аж ахуйн алба**

# ӨМНӨХ ҮГ

Мэргэжлийн боловсролын сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад чанарын менежментийг баримтлан чанарын бодлогыг тодорхойлон жендерийн мэдрэмжтэй бодлогыг хэрэгжүүлэх, сургалтын үйл ажиллагааг тасралтгүй сайжруулахад Олон улсын чанарын менежментийн нэгдмэл тогтолцоог нэврүүлж, сургалтын орчин нөхцөлийг сайжруулах, хүний нөөцийн бодлогыг боловсруулан тогтвортой хадгалах, гадаад, дотоодын хамтын ажиллагаа түншлэлийг нэмэгдүүлж түүний үр дүнг тооцож ажиллалаа.

Бидний өмнөө тавьсан бодлогоо хэрэгжүүлэх, хууль дүрэм журмын хүрээнд Бодлогын баримт бичгүүдийг шинэчлэн боловсруулж, холбогдох дүрэм, журам, чанарын гарын авлага зэргийг багш ажилчид, суралцагчдын хэрэгцээ шаардлага болон орон нутгийн хөдөлмөрийн зах зээл, нийгмийн эрэлтэд тулгуурлан Монгол улсын Алсын хараа 2050, Боловсролын дунд хугацааны хөтөлбөр 2030, Өмнөговь аймгийн “Өсөлттэй Өмнөговь” хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгийг үндэслэн шинэчлэн боловсрууллаа.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан чанартай сургалтын үйл ажиллагаа удирдан зохион байгуулж  шинээр Сэргээгдэх эрчим хүчний мэргэжлийг нээж, ажил олгогчидтой хамтран Хосмог сургалтын тогтолцоог нэвтрүүлэн 3 мэргэжлээр сургалтын үйл ажиллагааг зохион байгууллаа.  Энэ хичээлийн жилд элсэлтийн тоо өмнөх онуудынхаас эрс нэмэгдэж түүхэндээ анх удаа 1028 суралцагчдтай болсон сайхан амжилттай байна. Сургалтын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах сургалтын төлөвлөгөө, сургалтын хөтөлбөрийг ажил олгогч байгууллагуудтай хамтран боловсруулж эхлээд байна. Ахисан түвшний сургалтад кредит дүйцүүлж Дипломын боловсролоос бакалаврын боловсролд дэвшин суралцуулах боломжийг бүрдүүлэхээр ажиллаж байна.

Дотоодын түншлэгч байгууллагуудтай хамтран ажиллаж сурагчдын үйлдвэрлэлийн дадлага, захиалгат сургалтуудыг хамтран зохион байгуулж төр, хувийн хэвшлүүдийн хамтын ажиллагааг эрчимтэй нэмэгдүүлсэн байна.

Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагуудаа манлайлан Говийн болон зүүн бүсийн уулзалт зөвөлгөөнийг амжилттай зохион байгууллаа.

Бид хамтаараа дэвшүүлсэн зорилго, зорилтоо биелүүлэхийн тулд хүн бүр хүчин зүтгэн ажилласан ажлаа та бүхэндээ толилуулж байна. Хамтран ажиллаж буй бүх багш ажилчид, төр хувийн хэвшил, ажил олгогч, суралцагч нартаа баярлалаа.

*Мэргэжлийн ур чадвараар*                *Хөгжлийг цогцлооно*

ЗАХИРАЛ          Ч.ЭРДЭНЭТУЯА

# НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

# УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

## АЛСЫН ХАРАА (VISION)

Олон улсын түвшинд хүрсэн сургалтын үйлчилгээ бүхий мэргэжлийн боловсрол сургалтын загвар сургууль болно.

## УРИА (APPEAL)

Мэргэжлийн ур чадвараар хөгжлийг цогцлооно.

## ЭРХЭМ ЗОРИЛГО (MISSION)

Сургалтын үйлчилгээний чанар хүртээмжийг тасралтгүй сайжруулж, ажил олгогчдын хэрэгцээ шаардлгад нийцсэн, аюулгүй ажиллагааг эрхэмлэсэн, салбартаа манлайлагч мэргэжилтэй ажилтныг бэлтгэнэ.

ЧАНАРЫН БОДЛОГО

Чанарын бодлого нь ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн политехник коллежийн болон түүний үйл ажиллагаанд оролцогч, сонирхогч талуудад хамаарна.

Чанарын бодлогын тодорхойлолт

Чадварлаг мэргэшсэн ёс зүйг эрхэмлэсэн бүтээлч хамт олны хүчээр олон улсын стандарт хөтөлбөр, сургалтын арга зүйд түшиглэсэн боловсролын үйлчилгээг үзүүлж үнэ цэн бүхий мэргэжилтэнг бэлтгэдэг сургууль болно.

Чанарын зорилт

1. Өмнөговь Полиехник коллежийн удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх;
2. Сургалтын чанар хүртээмжийг нэмэгдүүлэх;
3. Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшинг нэмэгдүүлэх;
4. Эрх тэгш байдлыг хангасан хүний нөөцийн хөгжлийг дэмжих;
5. Түншлэл хамтын ажиллагааг өргөжүүлэх;

## ҮНЭТ ЗҮЙЛС (OUR CORE VALUES)

### 1. ЧАНАРТАЙ СУРГАЛТ

Чадварлаг, эвсэг хамт олон бүрдүүлнэ. /Амжилтын төлөө хамтдаа/

### 2. ЁС ЗҮЙ

Хүндэтгэл - ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч хүндэтгэлтэй хандана

### 3. АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

Нэн тэргүүнд хүний амь нас, эрүүл мэндэд анхаарна. Аюулгүй ажиллагааны соёлыг хүн бүр өөртөө шингээн ажилдаа шингээж, хэрэгжүүлж ажиллана.

### 4. ХАМТЫН ЗҮТГЭЛ

Өрсөлдөх чадвартай МБС-н тогтвортой үйл ажиллагааг дэмжинэ. Байгууллагын хөгжилд үзүүлж буй хүн бүрийн хувь нэмрийг ойлгон хүлээн авч, хамтран ажиллахад анхаарна.

### 5. ТАСРАЛТГҮЙ САЙЖРУУЛАЛТ, ӨСӨЛТ

Хөдөлмөр эрхлэх шударга, нээлттэй орчныг бэхжүүлнэ. Хийсэн ажил бүрийн гүйцэтгэлийг хянах, үр дүнг үнэлэх, сайжруулах арга хэмжээг авч хэвшинэ.

## ТҮҮХЭН ЗАМНАЛ




ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллеж нь Захиргаа аж ахуйн алба, Сургалтын алба бүрэлдэхүүнтэй ажиллалаа.

*2025 оны бүтэц*




Нийт 74 багш ажилтны хүйсийн харьцаа 59,4% эмэгтэй, 40,5% эрэгтэй байна.

Багш ажилтанд ногдох мэргэжлийн багш 2,1%, үүнээс эрэгтэй 1,4, эмэгтэй 3,3 хувь

- Нийт багш, ажилтанд ногдох ерөнхий эрдмийн багш 6,7 хувь (хүйсээр эрэгтэй 10, эмэгтэй 5,5 хувь)
- Нийт багш, ажилтанд ногдох удирдлага болон захиргааны ажилтан 2,5 хувь (хүйсээр эрэгтэй 4,4 эмэгтэй 2 хувь)
- Багш ажилтны хүйсийн харьцааг 60:40-тэй байх бодлого барьж ажиллаж байна.
- Нийт багш ажилтны 58% нь эмэгтэй, 41% нь эрэгтэй байна.
- 2025-2026 оны хичээлийн жилд 46 багш 998 суралцагч 1:22 харьцаатай нэг багшид ноогдох суралцагчийн тооны харьцаа нь сургалтын чанар болоод багшийн сургахуйн үйлд төдийлөн  суралцагчидтай ажиллах ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэхгүй хэмжээнд байна.

БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН БОЛОН ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Зорилт 1.1. Сургалтын байгууллагын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж, байгууллагын менежментийг сайжруулах;

Зорилт 1.2. Иргэний мэргэжил, ур чадвар эзэмших хэрэгцээ, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн чанартай боловсрол, сургалтын үйлчилгээ үзүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, тэгш хамруулах тухайн орон нутаг, бүс нутгийн бүх насны иргэд, нийгмийн салбар бүрийг хамарсан насан туршийн боловсролын нээлттэй, уян хатан тогтолцоог бэхжүүлэх;

Зорилт 1.3. Түншлэлийг хэрэгжүүлэх, гадаад, дотоодын мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагатай эрх хэмжээний хүрээнд хууль тогтоомжид заасны дагуу хамтран ажиллах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн байгаль орчинд ээлтэй, жендэрийн мэдрэмжтэй, хүртээмжтэй сургалтын орчин бүрдүүлэх;

Зорилт 1.4. Байгууллагын хүний нөөцийн удирдлага, багшийн хөгжлийг тасралтгүй хангах, чадавхыг бэхжүүлэх;

Зорилт 1.5. Суралцагч, төгсөгчдийн хандлага, төлөвшил, зан үйлийн харилцаанд эерэг өөрчлөлтийг бий болгоход чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах;

Зорилт 1.6. Батлагдсан төсөв, өөрийн болон туслах үйл ажиллагааны орлогыг үр ашигтай зарцуулах, багш, ажилтан, суралцагчийн эрүүл аюулгүй таатай орчинд сурч хөгжих, ажиллах, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх;

## 1.1 СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛ:

Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг Боловсрол, Шинжлэх Ухааны Сайд Б.Энх-Амгалангийн 2024 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн А/189 тоот тушаалаар баталсан энэхүү шийдвэр нь сургуулийн удирдлага, үйл ажиллагааны зохион байгуулалтыг шинэ түвшинд хүргэж, бодлого, төлөвлөлтийг илүү уялдаа холбоотой болгоход чиглэгдсэн бөгөөд шийдвэр гаргах үйл явцыг ил тод, хариуцлагатай болгох чухал алхам болсон юм.

Удирдах зөвлөлийн хурлын давтамж, шийдвэрийн тэмдэглэлийг харуулбал:

*Хүснэгт 1.2 Удирдах зөвлөлийн хуралдсан байдал*

| № | Хэлэлцэж шийдвэрлэсэн асуудлууд | Хуралдсан огноо | Хурлын давтамж | Оролцоо хувиар |
|---|---|---|---|---|
| **1** | • 2025-2026 оны хичээлийн жилийн элсэлтийн квот батлах | 2024-06-13 | 1 | 100% |
| **2** | • Удирдах зөвлөлийн дарга сонгох<br>• Гүйцэтгэлд суурилсан үнэлгээний тайланг танилцуулах, урамшуулах, урамшуулал хуваарилах<br>• Бүтэц орон тоо хэлэлцэж, батлах | 2025.12.17 | 1 | 80% |

## 1.2 ЗАХИРГААНЫ ЗӨВЛӨЛ

Политехник коллежийн удирдлагын зохион байгуулалтад чухал үүрэг гүйцэтгэдэг нэгэн чухал хэлбэр бол Захиргааны дэргэдэх зөвлөл юм. Энэ зөвлөл нь сургуулийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, үйл ажиллагааг зохион байгуулах, шийдвэр гаргах үйл явцад чухал оролцоотой байдаг.

Тус сургуулийн Захирлын зөвлөл 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/52 тоот тушаалаар байгуулагдсан бөгөөд, цаашид удирдлагын хэрэгцээ, шаардлагын дагуу хэд хэдэн удаа шинэчлэгдэн батлагдсан байна. Үүнд:

1. 2025 оны 09 дүгээр сарын 08-ний өдрийн А/105 тоот тушаал: Захирлын дэргэдэх зөвлөлийг Захиргааны зөвлөл болгон нэршлийг өөрчлын дахин шинэчлэн баталсан.

Захиргааны зөвлөл нь сургуулийн удирдлага, хүний нөөц, сургалтын чанарыг сайжруулах, хамтын ажиллагааг өргөжүүлэх, шийдвэр гаргалтыг ил тод, хариуцлагатай байлгах зэрэг чухал үүргийг гүйцэтгэдэг.

*Хүснэгт 1.3 Захиргааны зөвлөлийн бүрэлдэхүүн*

| № | Нэр | Албан тушаал | Алба |
|---|---|---|---|
| 1 | Ч.Эрдэнэтуяа | Захирал | |
| 2 | Л.Чингэрэл | Сургалтын менежер | Сургалтын алба |
| 3 | Ш.Оюун-Ухаан | Захиргаа, аж ахуйн менежер | Захиргаа, аж ахуйн алба |
| 4 | Ш.Баттогтох | Ерөнхий нягтлан бодогч | Захиргаа, аж ахуйн алба |
| 5 | Э.Шинэжаргал | Дотоод чанар статистик хариуцсан ахлах ажилтан | Захиргаа, аж ахуйн алба |
| 6 | Б.Сугирзав | ХАБЭА ахлах ажилтан | Захиргаа, аж ахуйн алба |
| 7 | Б.Буянжаргал | Хүний нөөц гадаад харилцаа хариуцсан ажилтан | Захиргаа, аж ахуйн алба |

Захиргааны дэргэдэх зөвлөл нь 7 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд сургуулийн үйл ажиллагааг удирдан, зохион байгуулах, шийдвэр гаргах үйл явцад оролцох чухал үүрэгтэй. Зөвлөл нь 7 хоногт 1 удаа ээлжит хурлыг зохион байгуулдаг бөгөөд шаардлагатай тохиолдолд гишүүдийн саналаар ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж, хурлаар шийдвэрлэх асуудлыг хэлэлцдэг.

Зөвлөлийн хурлаар анхан шатнаас дэвшүүлсэн болон сургуулийн үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг хэлэлцэж, хууль эрх зүйн талаас нь судалж, шийдвэрлэдэг. Энэ нь

сургуулийн үйл ажиллагааны хууль ёсны дагуу явж байгаа эсэхийг шалгах, үйл ажиллагаа болон удирдлагын зохион байгуулалтад сайжруулалт оруулах зорилготой юм.

Захиргааны дэргэдэх зөвлөл хурлын шийдвэрийг тодорхой шийдвэр гаргах, хурлын тэмдэглэлд тусгах, судлах, эргэж хэлэлцүүлэх гэсэн 4 үндсэн хэлбэрээр авч үздэг. Энэ нь хурлын шийдвэрийг баталгаажуулах, хэрэгжилтийг хянах, шаардлагатай тохиолдолд дахин хэлэлцэх боломжийг бий болгодог.

Эдгээр үйл явц нь сургуулийн удирдлагын хариуцлага, ил тод байдал, үр дүнтэй зохион байгуулалтыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

## 1.3 СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАЛТ

Сургуулийн стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах

Байгууллагын алсын хараа ба засаглал

Политехник коллеж нь Олон улсын магадлан итгэмжлэл авах, Чанарын удирдлагын нэгдсэн тогтолцоог (ISO 9001, 21001, 14001, болон 45001) нэвтрүүлэх замаар байгууллагын томоохон шинэчлэлийн үе шатанд шилжиж байна. Энэхүү тулгуур чиглэлийн хүрээнд Удирдах зөвлөлийн бие даасан байдлыг бэхжүүлж, Мэргэжлийн болон Техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн хүрээнд өгөгдөлд суурилсан шийдвэр гаргах засаглалыг төлөвшүүлнэ.

Сургалтын чанар ба хөдөлмөрийн зах зээлийн уялдаа

Манай сургалтын стратеги нь Хосмог сургалтын боловсрол болон Ажлын байранд суурилсан сургалтын (WBL) тогтолцоонд шилжихэд чиглэж байна. Бүс нутгийн хөгжлийн бодлого болон хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй сургалтын хөтөлбөрийг уялдуулснаар төгсөгчдийн ажил эрхлэлтийг 80-85%-д хүргэхийг зорьж байна. Гол санаачилгууд:

- Цахим шилжилт: Сургалтын агуулгын 35–45%-ийг Сургалтын удирдлагын нэгдсэн системд (LMS) шилжүүлнэ.
- Олон улсын хамтын ажиллагаа: Олон улсын дээд боловсролын байгууллагуудтай кредит харилцан хүлээн зөвшөөрөх, “2+2” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.
- Чадамжид суурилсан сургалт (CBT): Нийт хөтөлбөрүүдийг олон улсын мэргэжлийн стандартад 100% нийцүүлнэ.

Хүний нөөц ба багшийн хөгжил

Багшлах бүрэлдэхүүн нь чанарын гол хөдөлгөгч хүч тул магистр, докторын зэрэгтэй багш нарын эзлэх хувийг 50%-иар нэмэгдүүлнэ. Багшийн хөгжлийн төвөөр дамжуулан багш нарыг үйлдвэрлэлийн дадлагад тогтмол хамруулснаар тэдний заах арга зүй болон техникийн ур чадварыг орчин үеийн үйлдвэрлэлийн түвшинд хадгална.

Дэд бүтэц ба тогтвортой хөгжил

Техник, технологийн ахисан түвшний сургалтыг дэмжихийн тулд төрөлжсөн дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийж, “Уул уурхайн машин механизмын угсралт, засвар үйлчилгээний чадамжийн төв”-ийг шинээр байгуулна. Объектуудын шинэчлэлд Түгээмэл загвар (Universal Design) буюу хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байх зарчмыг баримтлах ба Тогтвортой хөгжлийн зорилтуудад (SDG) нийцсэн “Эко-кампус” соёлыг төлөвшүүлнэ.

Стратегийн түншлэлийн экосистем

Боловсрол болон үйлдвэрлэлийн хоорондын зааг ялгааг арилгахын тулд Төр-хувийн хэвшлийн түншлэлийг (PPP) өргөжүүлнэ. Бүс нутгийн 180 гаруй түншлэгч байгууллагатай хамтын ажиллагааг бэхжүүлж, Бизнес инкубатороор дамжуулан оюутны гарааны бизнесийг дэмжсэнээр төгсөгчид маань зөвхөн ажлын байр хайгч биш, бүс нутгийн эдийн засгийн инновацийг хөтлөгчид байна.




Стратегийн зураглалын гол бүрэлдэхүүн хэсгүүд:

1. Засаглалын цөм (Бодлогын оролт):

- Боловсролын яам болон Боловсролын ерөнхий газартай байгууллагын бодлогыг дээрээс доош чиглэлд уялдуулахыг илэрхийлнэ.
- Стратегийн чиг үүрэг: Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, чанарын баталгаажуулалт (ISO, Магадлан итгэмжлэл), улсын төсвийн тогтвортой байдлыг хангах.

2. Үйлдвэрлэлийн тэнхлэг (Зах зээлийн эрэлт):

- Коллеж болон Ажил олгогчдын байгууллага, Мэргэжлийн холбоодын хоорондох хоёр талт холбоо хамаарал.
- Стратегийн чиг үүрэг: Төгсөгчдийн ажил эрхлэлтийг хангах зорилгоор "Дуаль боловсрол", "Ажлын байранд суурилсан сургалт (WBL)" болон сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг удирдан чиглүүлэх.

3. Инноваци ба Орлогын төв (Байгууллагын бие даасан байдал):

- Чадамжийн төвүүд: Гарааны компаниуд болон Бизнес инкубаторын дотоод уялдаа холбоог харуулна.
- Стратегийн чиг үүрэг: Орлогын эх үүсвэрийг төрөлжүүлэх, хавсарга судалгааг дэмжих замаар төсвийн хараат байдлыг бууруулах.

4. Бүс нутаг ба Нийгмийн тулгуур (Нөлөөлөл):

- Аймаг, орон нутгийн Засаг даргын Тамгын газар, иргэд болон цэргийн албан хаагчидтай хамтран ажиллахыг илэрхийлнэ.
- Стратегийн чиг үүрэг: Бүх нийтийг хамарсан ур чадварт суурилсан сургалт болон олон нийтийн үйлчилгээгээр дамжуулан коллежийг бүс нутгийн хөгжлийн хөдөлгүүр болгон байршуулах.

5. Олон улсын сүлжээ (Дэлхийн жишиг):

- Олон улсын төсөл, хөтөлбөрүүд (жишээ нь: GIZ, Erasmus+) болон "2+2" хөтөлбөр хэрэгжүүлэгч гадаадын түнш сургуулиудын хамтын ажиллагаа.
- Стратегийн чиг үүрэг: Сургалтын чанарыг дэлхийн жишигт нийцүүлэх (benchmarking) болон технологи дамжуулалтыг (technology transfer) хөнгөвчлөх.

## 1.4 БАЙГУУЛЛАГЫН БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн (БМИҮЗ) гадаад үнэлгээний багийн дүгнэлт, зөвлөмжүүдийн дагуу сургалтын байгууллагынхаа үйл ажиллагааг сайжруулах зорилгоор сайжруулалтын төлөвлөгөөг боловсруулан шат дараатайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна.

Сайжруулалтын төлөвлөгөөг дараах үндсэн чиглэлүүдэд төвлөрүүлэн боловсруулж байна. Үүнд:

1. **Байгууллагын бодлого, стратегийн менежмент**

   1.1.Стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, хэрэгжилтийг хяналттай болгох;

   1.2.Чанарын баталгааны тогтолцоог сайжруулах, дотоод үнэлгээний тогтолцоог тогтвортой хэрэгжүүлэх;

2. **Сургалтын чанар, хөтөлбөрийн хэрэгжилт**

   2.1.Хөтөлбөрийн үнэлгээ, сайжруулалтын эргэх холбоог бүрдүүлэх;

   2.2.Ажлын байрны эрэлт хэрэгцээнд нийцсэн сургалтын агуулга, арга зүйг шинэчлэх;

3. **Багш, хүний нөөцийн хөгжил**

   3.1.Багш нарын мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалт, арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх;

   3.2.Шинээр багш хөгжлийн төлөвлөгөө болон үнэлгээний тогтолцоог нэвтрүүлэх;

4. **Суралцагчийн дэмжлэг, оролцоо**

   4.1.Суралцагчийн оролцоог нэмэгдүүлэх, клуб, зөвлөлүүдийн үйл ажиллагааг тогтворжуулах;

   4.2.Сургалтын дэмжлэг үйлчилгээ (сэтгэл зүй, зөвлөгөө, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр) сайжруулах;

5. **Хамтын ажиллагаа, орчны хөгжил**

   5.1.Салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлж, мэргэжлийн байгууллагуудтай хамтран хөтөлбөр хөгжүүлэх;

   5.2.Сургалтын орчны тохижилт, техник тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх Магадлан итгэмжлэл:

2024–2025 оны хичээлийн жилд Политехник коллежийн сургалтын чанар, үйл ажиллагааны бодлого, бүтэц зохион байгуулалт, сургалтын орчин, хүний нөөц, менежмент, санхүүгийн ил тод байдал зэрэг бүхий л үзүүлэлтээр үнэлэгдэн, Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл (БМИҮЗ)-өөс магадлан итгэмжлэгдэх шаардлагыг хангаж, албан ёсоор магадлан итгэмжлэгдсэн сургууль боллоо.

Магадлан итгэмжлэлийн үйл явцыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд байгууллагын удирдлага, хамт олон, оролцогч талуудын уялдаа холбоог хангаж ажилласан бөгөөд магадлан итгэмжлэлийн ажлын хэсгийг ахалж, бүх шатны төлөвлөлт, бэлтгэл, хэрэгжилтийг шууд зохион байгуулсан.

Үндсэн ажлууд:

1. Магадлан итгэмжлэлийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд:

1.1.Боловсролын чанарын баталгаажуулалтын холбогдох хууль, дүрэм журмыг судалж, хэрэгжилтийг үнэлэв;

1.2.Өмнөх магадлан итгэмжлэлийн зөвлөмжүүдийг хэрэгжүүлсэн байдалд үнэлгээ хийж, дүн шинжилгээ гаргав;

1.3.Ажлын хэсэг байгуулж, үүрэг хуваарилалт хийсэн бөгөөд нийт 6 чиглэлээр баг бүрдүүлэн хариуцлагажуулсан;

2. Өөрийн үнэлгээний тайлан боловсруулах:

2.1.Сургалтын бодлого, стратеги, төлөвлөлт;

2.2.Чанарын баталгаажуулалтын дотоод механизм;

2.3.Сургалтын орчин, тоног төхөөрөмж;

2.4.Багшлах боловсон хүчний чадавх, хөгжлийн бодлого;

2.5.Оюутны амжилт, дэмжлэгийн тогтолцоо;

2.6.Нийгмийн түншлэл, ажлын байрны холбоо; дээр тулгуурлан магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний иж бүрэн тайланг боловсруулан ажиллаа.

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн хурлын шийдвэрээр Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллеж нь бүрэн магадлан итгэмжлэгдсэн байгууллага болсон.

Энэ нь сургуулийн чанартай боловсролын үйлчилгээг баталгаажуулсан чухал амжилт бөгөөд цаашдын үйл ажиллагаанд итгэлцэл, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх суурь болсон.

Цаашид төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, БМИҮЗ-ийн зөвлөмжийн хэрэгжилтийн явцыг улирал тутам дүгнэж, тайлагнах арга хэмжээ авч ажиллаж байна.

Энэ үйл явц нь тасралтгүй сайжруулалтын цикл үүсгэж, сургуулийн үйл ажиллагаа тасралтгүй чанаржиж, ил тод байдал, үр дүн сайжирч байна.

Байгууллагын магадлан итгэмжлэлийн Шинжээчдийн баг ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллеж дээр 2024 оны 12 дугаар сарын 25-26 ны өдрүүдэд ажилласан.

Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлийн 2025 оны 4 дүгээр сарын 09 ны өдрийн 202501 тоот тогтоолоор 5 жилийн хугацаатайгаар магадлан итгэмжлэгдэв.











Стратеги төлөвлөгөө нь байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, сургалтын орчин, стандартын хэрэгжилтийг хангах, нийгмийн түншлэлийг хөгжүүлэх хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчдын шаардлагад нийцсэн, ур чадвартай мэргэжилтэй ажилтан бэлтгэн гаргахад оршино. Тус сургууль нь стратеги төлөвлөгөөндөө нийгмийн түншлэлийг хөгжүүлэх өргөн хүрээтэй зорилтыг дэвшүүлж, нийгмийн түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулан Төр, олон нийтийн байгууллага, мэргэжлийн холбоод, ажил олгогчидтой бүх талаар хамтран ажиллаж, Мэргэжлийн боловсролын салбарт хэрэгжүүлж буй бодлого, чиглэл, сургуулийн зорилго, зорилтууд, төлөвлөлт, үйл ажиллагааг түншлэгчид, иргэд, олон нийтэд сурталчилан таниулах ажлыг олон чиглэлээр зохион байгуулсан.

Байгууллагын үйл ажиллагааны чанарын баталгаажилтыг сайжруулах ажлын хүрээнд:



**Нэгдмэл удирдлагын тогтолцоо (ISO 9001, ISO45001, ISO14001) нэвтрүүлэх**

Байгууллагын үйл ажиллагааны чанар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон байгаль орчны менежментийг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулах зорилгоор 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр Захирлын А/22 тоот тушаалаар “Нэгдмэл удирдлагын тогтолцоо” нэвтрүүлэх ажлын хэсэг байгуулж, хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан шат дараатайгаар ажиллаж байна.

Нэгдмэл удирдлагын тогтолцоо (Integrated Management System, IMS) нь дараах олон улсын стандартыг хамарч байгаа юм:

- ISO9001 – Чанарын удирдлагын тогтолцоо;
- ISO45001 – Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо;
- ISO14001 – Байгаль орчны удирдлагын тогтолцоо;

Энэхүү ажлыг хэрэгжүүлэх хүрээнд мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч “ОШМИ” ХХК-тай харилцан ойлголцолд хүрч, хамтын ажиллагааны гэрээ байгуулсан. Гэрээний дагуу стандартуудыг үе шаттайгаар нэвтрүүлэх, байгууллагын дотоод үйл ажиллагаанд нийцлийн үнэлгээ хийх, ажилтнуудад сургалт зохион байгуулах, баримт бичгийн тогтолцоог шинэчлэх болон боловсронгуй болгох зэрэг ажлуудыг хэрэгжүүлж байна.

2025 онд “Нийцлийн үнэлгээ” хийгдэж, түүний үр дүнд тулгуурлан сайжруулалтын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн. Мөн 2025 оны 10 дугаар сарын 11-ний өдөр стандартын дотоод аудитын сургалтад багш, ажилтны төлөөллөөс 6 хүнийг хамруулж, дотоод аудиторын чадавхыг бэхжүүлсэн. Үүний үр дүнд стандартын бүлгүүдийн хэрэгжилтийг төлөвлөгөөний дагуу үнэлэн сайжруулж, нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх ажлаа тогтмол ахиулан ажиллаж байна.

Нэгдмэл удирдлагын тогтолцооны ажлын хүрээнд хийгдсэн ажил:

4. Байгууллагын нөхцөл байдал:

Бүлэг 4-ийн хүрээнд байгууллагын стратеги, үйл ажиллагаанд нөлөөлж буй дотоод болон гадаад хүчин зүйлсийг тодорхойлох, сонирхогч талуудын хэрэгцээ, хүлээлтийг тодорхойлон Нэгдсэн менежментийн тогтолцооны (НМТ) суурийг бүрдүүлэх ажлуудыг системтэйгээр хэрэгжүүлсэн.

4.1 Байгууллагын нөхцөл байдлын шинжилгээ

- Байгууллагын дотоод, гадаад орчны нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор QMS-ийн хүрээнд SWOT, 8M EMS-ийн хүрээнд PESTLE шинжилгээг тус тус хийсэн.
- SWOT шинжилгээгээр байгууллагын давуу тал (мэргэжлийн боловсон хүчин, салбарын түншлэл), сул тал (дэд бүтэц, зарим процессын баримтжуулалтын түвшин), боломж (төсөл хөтөлбөр, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт), эрсдэл (санхүүжилт, хүний нөөцийн тогтвортой байдал)-ийг тодорхойлсон.
- PESTLE шинжилгээгээр улс төр, эдийн засаг, нийгэм, технологи, хууль эрх зүй, байгаль орчны хүчин зүйлсийг тодорхойлж, сургалтын үйл ажиллагаа болон байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлсэн.
- Шинжилгээний үр дүнг бодлого, зорилт, эрсдэлийн үнэлгээ, төлөвлөлтөд тусган хэрэгжилтийг хангаж байна.
- QMS болон EMS-ийн хүрээнд байгууллагын дотоод, гадаад орчны шинжилгээг SWOT болон PESTLE аргуудаар хийсэн.

- Байгаль орчны талаас PESTLE шинжилгээг гүйцэтгэж, бодлого, төлөвлөлтөд тусгасан.

4.2 Сонирхогч талуудын шинжилгээ

- Байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх сонирхогч талуудыг дотоод, гадаад гэж ангилан тодорхойлсон;
- Дотоод сонирхогч талууд: суралцагч, багш, ажилтан.
- Гадаад сонирхогч талууд: төгсөгчид, ажил олгогчид, эцэг эх, төрийн болон удирдлагын байгууллагууд, хамтрагч байгууллагууд.
- Сонирхогч тал тус бүрийн хэрэгцээ, хүлээлт, эрсдэл, нөлөөллийн түвшинг тодорхойлж, QMS болон EMS-ийн төлөвлөлтөд тусгасан.
- EMS-ийн хүрээнд сонирхогч талуудын дулааны матриц, эрсдэлийн зэрэглэл боловсруулж, байгаль орчны асуудалд үзүүлэх нөлөөллийг үнэлсэн.
- Дотоод сонирхогч талууд: суралцагч, багш, ажилтан.
- Гадаад сонирхогч талууд: төгсөгч, ажил олгогч, төрийн болон удирдлагын байгууллагууд.
- EMS-ийн хүрээнд сонирхогч талуудын дулааны матриц, эрсдэлийн зэрэглэлийг тодорхойлсон.

4.3 НМТ-ны хамрах хүрээ

- Нэгдсэн менежментийн тогтолцооны хамрах хүрээг объект, техник тоног төхөөрөмж, программ хангамжийн ангиллаар тодорхойлж баримтжуулсан.

4.4 Процессийн загварчлал

- Байгууллагын бүх үйл ажиллагааг хамруулсан процессийн загварчлалыг хийж, НМТ-ны цөмийг бүрдүүлсэн.
- Нийт 24 процесс (удирдах 3, үндсэн 10, дэмжих 11) тодорхойлсон
- Процесс бүрийн зорилго, оролт, гаралт, хариуцагч, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлсон.
- Нэгдсэн процессийн уялдаа холбооны зураглал боловсруулж, QMS, EMS шаардлагыг нэгтгэн харуулсан.
- SIPOC матриц, процессийн матриц боловсруулж, хэвлэн баталгаажуулах шатанд байна.
- Шинээр болон шинэчлэн боловсруулах шаардлагатай журам, зааврын жагсаалтыг гаргаж, хэрэгжилтийн төлөвлөгөөнд тусгасан.
- Нийт 24 процесс (удирдах 3, үндсэн 10, дэмжих 11) тодорхойлж, нэгдсэн процессийн зураглал боловсруулсан.
- SIPOC болон процессын матрицууд боловсруулагдаж батлагдсан.
- Шинээр болон шинэчлэн боловсруулах шаардлагатай журам, зааврын жагсаалтыг гаргасан.

6. Эрсдэл ба боломж

Бүлэг 6-ийн хүрээнд байгууллагын стратеги, үйл ажиллагаа, байгаль орчинд нөлөөлөх эрсдэл, боломжийг системтэй тодорхойлж, удирдах тогтолцоог бүрдүүлсэн.

6.1 Эрсдэл, боломжийн тодорхойлолт ба үнэлгээ

- ISO9001:2015, ISO14001:2015 стандартын шаардлагад нийцүүлэн процесс бүрээр эрсдэлийн үнэлгээ хийсэн.

• Эрсдэлийг магадлал, нөлөөллийн түвшингээр үнэлж, бага, дунд, өндөр зэрэглэлд ангилсан.
• Илэрсэн эрсдэл тус бүрт авах хариу арга хэмжээ, хариуцагч, хэрэгжүүлэх хугацааг тодорхойлсон.
• Эрсдэлийг бууруулах, боломжийг ашиглах төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг тогтмол хянаж байна.
• Эрсдэлийн удирдлагын журам боловсруулж, батлуулан мөрдөж эхэлсэн.



Сургалтын алба зөвлөгөө авч байгаа нь




Дотоод аудиын сургалт

## 1.4 БАЙГУУЛЛАГЫН ДҮРЭМ ДОТООД ЖУРАМ БОЛОН ХОЛБОГДОХ БИЧИГ БАРИМТУУДЫГ ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛАЛТ

Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд “Монгол хэлний тухай хууль”, “Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль”, “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам”, “Цахим баримт бичгийн стандарт”, “Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ыг тус тус баримтлан стандартын дагуу байгууллагын баримт бичгийн хяналтын журам болон баримт бичгийг дугаарлах журмыг тус тус боловсруулан баталгаажуулж, журмын маягтын дагуу мастер жагсаалтад бүртгэн, баримт бичгийн түгээлтийг хийж ISO стандартыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа билээ.

Байгууллагын шинэчлэн боловсруулсан бодлого

- Чанарын бодлого
- Хүний нөөцийн бодлого
- Сургалтын бодлого
- Хүүхэд хамгааллын бодлого

Байгууллагын шинэчилсэн хөтөлбөрүүд

- Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр
- Багш ажилчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр
- Суралцагч хөгжлийн хөтөлбөр

Шинэчлэн боловсруулсан дүрэм журмууд

1. Сургалтын үйл ажиллагааны нэгдсэн журам
2. Суралцагчийн мэдлэг ур чадварыг үнэлэх журам
3. Кабинет, лаборатори, дадлагын газар байгуулах, ашиглах нийтлэг журам
4. Сургалт арга зүйн зөвлөлийн журам
5. Спорт заалanд мөрдлөг болох журам
6. Үйлдвэрийн дадлагын журам
7. Мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам

8. Дотуур байрны журам
9. Багш нарын цахим сургалтад мөрдөх журам
10. Багшид мэргэжлийн зэрэг олгох,хасах журам
11. Баримт бичгийн хяналтын журам
12. Баримт бичгийг дугаарлах журам
13. Сургалт хөгжлийн журам
14. Суралцагчийн ёс зүйн дүрэм
15. Чанарын удирдлага, чанарын үнэлгээ хариуцсан багийн ажиллах журам
16. Хяналт шинжилгээний журам
17. Ахмадын сан байгуулан ажиллах ажиллах журам
18. Оюутны хариуцлагыг өндөржүүлэх журам
19. Ажил үйлчилгээ гэрээгээр хийлгэх журам
20. Тоног төхөөрөмж хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийх журам
21. ХЭМАБ-н дотоод аудитын журам
22. Мониторинг, хэмжилтийн журам
23. Хууль тогтоомж болон бусад шаардлагуудыг тодорхойлох, нийцлийг знэлэх журам
24. Бараа нийлүүлэх худалдан авах журам
25. ХАБЭА-н сургалт зохион байгуулах, зааварчилгаа өгөх шалгалт авах журам
26. Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэлийг олгох ашиглалтын журам
27. Онцгой байдалд бэлэн байх, хариу арга хэмжээ авах журам
28. ХАБЭА-н сайшаал, урамшууллын журам
29. ХЭМАБ-н Бодлогын журам
30. Эрсдэлийн үнэлгээний журам
31. Мэдээлэл солилцоо, оролцоо зөвөлгөөний журам
32. Дүрс бичлэгийн техник, хэрэгсэл( хяналтын камер)-г ашиглах хянах

## 1.5 ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

**Төрийн аудит, дээд шатны байгууллага, бусад хяналт шалгалтын байгууллагаас хийсэн хяналт шалгалтын зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллах**

Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний комиссоос 2025 оны 2 дугаар сарын 12-ний өдөр ирүүлсэн 06/12 тоот зөвлөмжийн хүрээнд нийт 5 чиглэлээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор тусгайлсан хэрэгжилтийн төлөвлөгөөг боловсруулан баталж, төлөвлөгөөнд туссан бүх арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж 2025 оны 04 дүгээр сарын 07-нд хэрэгжилтийн тайланг комисс-д хүргүүлсэн.

Хүний эрхийн Үндэсний комиссоос өгсөн 5 зөвлөмжийн хүрээнд төлөвлөгөөний бүх арга хэмжээ амжилттай хэрэгжиж, холбогдох баримт бичиг, дотоод зохицуулалт, үйл ажиллагааны бодлого, зохион байгуулалтын түвшинд шаардлагатай сайжруулалтуудыг хийж дуусгасан бөгөөд энэ нь хүний эрхийг хамгаалах, хүндэтгэх, хэрэгжүүлэх тогтолцоог бэхжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж, байгууллагын үйл ажиллагааг илүү үр дүнтэй болгосон.

Төрийн байгууллагын архив албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын үйл ажиллагаанд Улсын үзлэг зохион байгуулах удирдамж аргачлалын дагуу шалгалт явагдаж үүний дагуу төлөвлөгөө гарган ажиллаж, Улсын үзлэгт амжилттай шалгуулж, сайжруулалтын зөвлөмж ирсэний дагуу ажлын төлөвлөгөө боловсруулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн газрын

2025 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 03/645 тоот зөвлөмжийн дагуу холбогдох ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг хангуулан ажилласан.

2025 оны 08 дугаар сарын 22-ны өдөр Боловсролын Ерөнхий газрын Даргын А/196 тоот “Ажлын хэсэг байгуулах, удирдамж батлах тухай” тушаалын дагуу байгууллагын үйл ажиллагаа дээд байгууллагын төлөвлөгөөт хяналт, шалгалтад хамрагдсан.

Дотоод чанарын баталгаажуулалтын ажлын хүрээнд 2025 онд нийт 15 ажил төлөвлөгдсөнөөс 13 ажилд төлөвлөгөөт хяналт шалгалтыг амжилттай зохион байгуулан хэрэгжүүлээд байна. Хяналтын явцад сургалтын төлөвлөлт, хэрэгжилт, багшийн хичээл заах арга зүй, суралцагчийн оролцоо, дүгнэх үнэлгээний зарчим зэрэгт анхааран, чанарын үзүүлэлтүүдийн дагуу үнэлгээ хийж, тайланг боловсруулсан. Үлдсэн ажил нь батлагдсан төлөвлөгөөний дагуу үе шаттайгаар хэрэгжихээр бэлтгэл хангаж, хяналт шалгалтын аргачлал, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлон ажиллаж байна. Чанарын баг нь батлагдсан жилийн төлөвлөгөө, хуваарийн дагуу хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, үйл ажиллагааг сайжруулах зорилгоор сайжруулалтын төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжилтэд нь хяналт тавьж байна. Мөн сургалтын чанарын тасралтгүй сайжруулалтыг хангах зорилгоор багш, албан хаагчдыг зөвлөгөө, чиглэлээр хангаан, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллаж байна.

**Байгууллагын жилийн үйл ажиллагааны гүйцэтгэл, чанар үр дүнгийн үнэлгээ**

Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын байгууллагын жилийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн үнэлгээг:

- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт
- Багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаа
- Сургалтын орчин бүрдүүлэлт
- Байгууллагын менежмент
- Удирдлагын манлайлал

Түншлэл хамтын ажиллагааны чанар, үр дүнг тодорхойлох зорилгоор Боловсролын ерөнхий газар, Боловсролын үнэлгээний төв хамтран төр болон орон нутгийн өмчит сургуулиудын хүрээнд зохион байгуулагдаж байгаа.

1. УУММАЗҮ

2. Цахилгаан

3. Гагнуур

4. Барилгын хана, тааз угсралт

5. Барилгын модон эдлэлийн бүтээц угсралт мэргэжлийн 2 дугаар ангийн суралцагчдын онолын болон ур чадварыг үнэлэх мэргэшсэн түвшний үнэлээч нартай хамтарсан шалгалтаар эхэллээ.





**Мэргэжлийн болон Техникийн Боловсролын Сургалтын Байгууллагын Гүйцэтгэлийн Үнэлгээний Үр Дүн – 2025**

**Байгууллагын мэдээлэл**

**Аймаг/дүүргийн нэр:** Өмнөговь аймаг

**Сургалтын байгууллагын нэр:** ШУТИС-ийн харьяа Өмнөговь аймаг дахь политехник коллеж

**Гүйцэтгэлийн үнэлгээний ерөнхий үр дүн**

**УЛСЫН ДУНДАЖ** 82.51%

**СУРГУУЛИЙН ДУНДАЖ** 82.83%

**ЭРЭМБИЙН ОНОО** 70.32%

**ИНДЕКС** 3

**Гүйцэтгэлийн үнэлгээний шалгуурын үр дүн**

| № | ШАЛГУУР | |
|---|---|---|
| 1 | СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН | 77.60% |
| 2 | БАГШ, АЖИЛТНЫ МЭРГЭЖЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН | 81.80% |
| 3 | СУРГАЛТЫН ОРЧНЫ БҮРДЭЛТИЙН | 96.60% |
| 4 | БАЙГУУЛЛАГЫН МЕНЕЖМЕНТ, УДИРДЛАГА | 82.70% |
| 5 | ТУСЛАМЖ, ХАМТЫН АЖИЛЛАГАА | 83.40% |

Захирлын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/63 тоот тушаал “Багш ажилтны ажлын гүйцэтгэлийн үнэлгээ зохион байгуулах үнэлгээний багийг томилох тухай” тушаалаар 11 хүний бүрэлдэхүүнтэй баг томилогдсон. Ажлын хэсэг хуралдаж багш ажилтныг үнэлэх шалгуур үзүүлэлтийг Монгол Улсын Боловсролын Сайдын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/246 тоот тушаалын хавсралтад заасан шалгуур үзүүлэлтийн дагуу дэлгэрэнгүй шалгуурыг боловсруулсан. 5 дугаар сарын 12-ноос 14-ний хооронд гардан хариуцах материалыг шалгах хуваарь гаргаж, хуваарийн дагуу үнэлгээ хийж ажиллалаа.




Захиргаа үйлчилгээний 27 албан хаагчийн үнэлгээг харахад 90-ээс дээш үнэлгээ авсан 20 албан хаагч, 80-аас дээш үнэлгээтэй 5, 70-аас дээш үнэлгээтэй 2 албан хаагч байна.



39 багшийн үнэлгээг харахад 90-ээс дээш үнэлгээтэй 12, 80-аас дээш үнэлгээтэй 13, 70-аас дээш үнэлгээтэй 8, 60-аас дээш үнэлгээтэй 6 багш байна.




Захирлын ажлын гүйцэтгэлийг 3 үндсэн шалгуурын хүрээнд 12 үр дүнгийн шалгуур үзүүлэлтээр 100 оноогоор тооцож үнэлсэн. Үнэлгээний 1.1 дэх шалгуур үзүүлэлтийг байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний сургуулийн дундаж үнэлгээ 82.83%-ийг оноонд шилжүүлж, 1.3 дахь шалгуур үзүүлэлтийг 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ 98%-ийг оноонд шилжүүлж дүнг шууд тавьсан.








### Жендерийн аудит хийж, үр дүнг сайжруулах төлөвлөлт боловсруулан хэрэгжүүлэх

GIZ төслийн хүрээнд 20 сургуулийн хэмжээнд зохион байгуулсан Жендэрийн мэдрэмжтэй орчин бүрдүүлсэн “Сайн туршлага”-ын мэдээллийг төслийн багт 9 дүгээр сарын 15-наас 17-ны өдрүүдэд боловсруулан өгсөн.

“Уурхайн машин механизмын ашиглалт” мэргэжлээр хосмог сургалтыг 9 дүгээр сарын 15-наас эхлэн хичээллүүлж байгаа бөгөөд жендерийн талаар ойлголт багш, оюутан, ажилтанд хэр байгаа талаарх судалгааг 9 дүгээр сарын 04-ний өдөр төслийн багаас хүмүүс ирж “Фокус” ярилцлага хийсэн.

Төслийн багаас жендэрийн аудит хийгдэж. зөвлөмж зөвлөгөөг 11 дүгээр сард ирүүлснийг үйл ажиллагаандаа  хэрэгжүүлэн ажиллаж байна.

Жендэрийн мэдрэмжтэй суралцах орчин бүрдүүлэх, чиглэлээр бүтээлч олон ажлуудыг санаачлан хийсэн.

Жендэрийн мэдрэмжтэй сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүй сургалтад 2 арга зүйчийг хамруулж, ЧСС-ын хөтөлбөр, шинэчлэлд тусгахаар ажлыг эхлүүлээд байна.

ДОТООД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

Дотоод хяналт, шинжилгээ хийх ерөнхий чиглэл, удирдамжийн дагуу үндсэн 13 чиглэлээр хийж байна.

1. Хичээлийн жилийн зорилго, зорилт болон үйл ажиллагааны төлөвлөгөөнд дүн шинжилгээ хийх
2. Багшлах бүрэлдэхүүний нөөц хүрэлцээ хангамж, багшийн ажлын ачаалал, багшийн мэргэжил дээшлүүлэлт
3. Элсэлтийн бодлого, элсэлтийн хяналтын тоо, бичиг баримт бүрдүүлэлт
4. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжилт үр дүн
5. Сургалтын орчин , ХАБЭА
6. Сурах ба сургах үйл ажиллагаа
7. Багшийн хөгжил, багшийн үйл ажиллагаа
8. Нийгмийн түншлэл - нийгмийн харилцаа
9. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ
10. Төгсөгчдийн судалгаа, ажил эрхлэлт
11. Сургалтын үйл ажиллагааны судалгаа
12. Номын сангийн үйл ажиллагаа
13. Оюутны дотуур байрны үйлчилгээ

*Дотоод хяналт шалгалт*

| **Хяналт шалгалтын чиглэл** | **2025 он** |
|---|---|
| Санхүүгийн үйл ажиллагаа | *0* |
| Сургалтын үйл ажиллагаа | 1 |
| ЗАА, дотуур байрны үйл ажиллагаа | 1 |
| Нийт | 2 |
| Дээрх хяналт шалгалтаар дараах нийтлэг зөрчлүүд илэрсэн байна. | |

**Үүнд: Санхүүгийн үйл ажиллагаанд:**

- Анхан шатны баримтын бүрдэл дутуу

**Сургалтын үйл ажиллагаанд:**

- Ээлжит хичээлийн төлөвлөгөөгүй, төлөвлөгөөг баталгаажуулаагүй
- Дадлагын хичээлд суралцагчид хувийн хамгаалах хэрэгсэл хувцас бүрэн өмсөөгүй
- Багш нарын журнал хөтлөлт дутуу, буруу, ирцийн мэдээлэл зөрсөн
- Tvets системд оруулсан цагийн бүртгэл журналын ирцтэй зөрсөн

**Захиргаа аж ахуй, дотуур байрны үйл ажиллагаанд:**

- Нийт 18 үл тохирол илэрсэн, зөрчлүүдийг илрүүлэн үйл ажиллагаагаа сайжруулах, зөрчил дутагдлыг арилган ажиллах зөвлөмжийг хүргүүлэн ажиллаж зөвлөмжийн дагуу хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

Холбогдох хууль эрх зүйн актууд, бодлогын баримт бичиг, тушаал, шийдвэр, дүрэм журмын хэрэгжилт, сургалтын үйл явц, сахилга дэг журам, санхүү аж ахуйн үйл ажиллагаа, өмч хөрөнгө, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа зэрэг сургуулийн бүхий л үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, зөрчил дутагдал, эрсдэлээс урьдчилан сэргийлж, ажил үйлчилгээний чанарыг сайжруулан ажиллаж байгаа бөгөөд дотоод чанарын алба байгуулан ажиллахаар төлөвлөж байна.

**Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулсан үйл ажиллагаанаас гарсан үр дүн:**

- Багш, ажилчдын хувийн хэргийн баяжилт нэмэгдсэн.
- Архив, албан хэрэг хөтлөлтийг стандарт, дүрэм журмын хүрээнд мөрдсөн.
- Дадлагын газрууд болон анги танхимын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан орчин бүрдүүлэх ажлыг төлөвлөн хийж гүйцэтгэсэн.
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт сайжирсан.
- Багш ажилтны цаг ашиглалт болон цагийн бүртгэл сайжирсан.
- Багш нарын цагийн ачааллыг тэнцвэржүүлж, ажлын байран дээрээ хөгжих боломжийг бүрдүүлсэн.
- Захирлын гаргасан тушаал шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт хийснээр хариуцлагын тогтолцоо сайжирч ирсэн байна.
- Дүн шинжилгээг улирал тутамд хийж, байгууллагын үр ашгийг хянан, гарсан зөрчил дутагдлыг арилгаж ажилласны үр дүнд байгууллагын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ үр дүн системтэйгээр сайжирч байгууллагын үйл ажиллагаанд дотоод, хөндлөнгийн үнэлгээ хийгдсэнээр байгууллагын эрсдэл буурч төлөвлөлт чанаржин, үйл ажиллагааны уялдаа холбоо үр дүн нэмэгдэж байна.

**Дотуур байр, гал тогооны үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийж, гарсан зөрчил дутагдлыг арилгах сайжруулах төлөвлөгөө гарган ажиллаа. Үүнд:**

2025 оны 10 дугаар сарын 20-ны өдөр байгууллагын дотуур байр болон гал тогооны үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулж, уг шалгалтын хүрээнд дотуур байр, гал тогооны орчны ерөнхий цэвэрлэгээ, ариун цэврийн байдал, халдвар хамгааллын дэглэмийн хэрэгжилт, галын болон цахилгааны аюулгүй ажиллагаа, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ, ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, ашиглалтын горим, техникийн үзлэгийн байдал, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хадгалалт, хадгалалтын температур, хугацаа, ангилал, хүнс боловсруулах, бэлтгэх үйл явц, эрүүл ахуйн зааварчилгааны мөрдөлт, үйлчлүүлэгчдэд хоол хүнс хүргэх үеийн эрүүл ахуйн шаардлага хангалт, мөн холбогдох хууль тогтоомж, журам, стандарт, дотоод зааврын хэрэгжилтийг иж бүрэн шалгасан.

Шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг тодорхойлон тэмдэглэж, эрсдэлийн түвшинг үнэлэн, тэдгээрийг арилгах, цаашид давтан гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөмж боловсруулан холбогдох албан тушаалтнуудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавих нөхцөлийг бүрдүүлсэн.

**<u>Сургалтын үйл ажиллагааны хяналт, шинжилгээ</u>**

Сургах ба сурах үйл ажиллагааны явцын хяналт, үнэлгээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө мөрдөлт
- Сургалтын баримт бичгийн хөтлөлт
- Сургалтын ажлын чанар, стандарт хангалт
- Суралцагчдыг хөгжүүлэх, төлөвшүүлэх ажлын явц, үр дүн
- Ажлын байрны аюулгүй ажиллагаа
- Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн орлогын байдал
- Багшийн заах арга барил болон мэргэжлийн ур чадварын түвшин
- Сургалцагчдын мэргэжлийн ур чадварын түвшин
- Төгсөгчдийн ажлын байрны хангалт
- Оюутнуудын хичээлд оролцох оролцоо, идэвхи ирцийн байдал
- Багшийн идэвхи санаачлага, бүтээлч ажил

2021 оноос Хяналт шинжилгээ, мониторинг хариуцсан ахлах мэргэжилтэн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, энэхүү төлөвлөгөөнд сургалтын үйл ажиллагааны 5 үндсэн чиглэлээр хяналт, үнэлгээ хийх ажлуудыг тусгасан. Үүнд:

1. 44 үндсэн багш, 8 цагийн багшийн үйл ажиллагаа тэнхим болон сургуулийн үйл ажиллагаанд нийцсэн эсэхэд үнэлгээ, дүгнэлт өгөх.
2. Багш нарын заасан хичээлээр хөндлөнгийн шалгалт авч үнэлгээ дүгнэлт гаргах
3. Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлгээ дүгнэлт гаргах.
4. Ерөнхий эрдмийн хичээлүүдийн хөтөлбөр, төлөвлөгөөг хянаж, үнэлгээ дүгнэлт гаргах.
5. Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын суралцагчдын үйлдвэрлэлийн дадлагын явцыг хянах зэрэг ажлуудыг тусгасан.

**Хяналт үнэлгээний үр дүн хэрэгжилт**

1. Сурах ба сургах үйл ажиллагааны хяналт, үнэлгээний үр дүнг сайжруулах чиглэлээр дараах ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлж, үнэлгээ дүгнэлт хийж ажилласан. Жил бүрийн сургуулийн Захирлын болон алба, нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн ажлуудыг дурьдвал. Үүнд:

- 0хөндлөнгийн шалгалтын дүнг тайлагнаж, багшийн ажлын үнэлгээ, цалин урамшуулалтай холбох механизмыг бүрдүүлэн ажиллаж байна.

**Суралцагчийн ахиц, дэвшлийг үнэлэх**

Суралцагчийн мэдлэг, ур чадвар, чадамжийн үнэлгээг дараах төрлүүдээр үнэлж, сурлагын амжилтын үнэлгээг тооцож ажиллаж байна. Үүнд:

**Оношлох үнэлгээ**: Сургалтад хамрагдахын өмнө суралцагчийн мэдлэг, ур чадварын суурь түвшинг тодорхойлох үнэлгээ

Хичээлийн жилийн эхэнд МБ-ын 3 жилийн ангийн (2.5 жил өмнө жил) суралцагчдаас ерөнхий эрдмийн хичээлүүдээр гарааны оношилгоог хийж, үр дүнг тооцон ахиулж ажилладаг.

2024-2025 оны хичээлийн жилийн эхэнд МБ-ын 3 жилийн ангийн суралцагчдаас ерөнхий эрдмийн 10 хичээлээр оношлох үнэлгээ хийгдсэн, үр дүнг тооцон сургалтын хөтөлбөр боловсруулан ажиллаж байна. Оношилгоонд давхардсан тоогоор 2627 суралцагч хамрагдсан. Хичээл бүрийн үнэлгээний гүйцэтгэлийг харуулбал:

| № | Хичээлийн нэр | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|
| 1 | Монгол хэл | 37% |
| 2 | Үндэсний бичиг | 27.9% |
| 3 | Математик | 22.2% |
| 4 | Нийгмийн ухаан | 39.9% |
| 5 | Монголын түүх | 41.5% |
| 6 | Физик | 28.1% |
| 7 | Хими | 25% |
| 8 | Англи хэл | 16.3% |
| 9 | Мэдээллийн технологи | 37.3% |
| 10 | Эрүүл мэнд | 30.9% |
| **Дундаж ГХ** | | **28.5%** |

**Явцын үнэлгээ**: Сургалтын явцад суралцагчийн сурах үйл ажиллагаа, эзэмшсэн чадамжид гарсан ахиц өөрчлөлтийг тодорхойлох үнэлгээ:

✓ Ерөнхий эрдмийн болон мэргэжлийн багш нар нэгж хичээл болон бүлэг сэдвийн төгсгөлд шалгалт авч, шалгалтын үнэлгээнүүдийн дунджаар улирлын явцын дүнг гаргаж тооцдог;

✓ Суралцагчийн олж авах мэдлэг, чадвар нь тухайн хичээлд оролцсон оролцоо ба ирцтэй салшгүй холбоотой гэж үзэн ирцийн оноог тооцон мөрдөж улирлын дүнд хамруулдаг;

✓Суралцагчдын насны хувьд 15-16 насныхан байдаг учраас хичээлийн тэмдэглэгээг сурлагын амжилтыг дүгнэх оноонд оруулдаг;

✓ Хичээл тус бүрийн онцлогоос шалтгаалан зарим хичээл дээр бие даалт хийлгэж дүгнэх аргачлал гардаг;

✓ Улирал тус бүрээр суралцагчдын мэдлэг чадварын үнэлгээг хувиар гаргаж, тэдгээрийн дунджаар жилийн эцсийн үнэлгээг гаргадаг;

**Чадамжийн нэгжийн үнэлгээ** суралцагч сургалтын хөтөлбөрийн нэгж чадамжийг судалсны дараа хийгдэх, тухайн чадамжийн нэгж дэх мэдлэг, ур чадварын түвшинг тогтоох үнэлгээ:

"Трансвест Монголиа, Сэндвик Монголиа", "MSM" групп компаниуд, "GIZ" төсөлтэй хамтран хэрэгжүүлж буй Хүнд машин механизмын салбарт эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих, тогтвортой ажлын байр бий болгох зорилготой уг төсөлд 43 оюутан дараах тоогоор хуваарилагдан компаниудыг дадлагажигч ажилтан болон суралцаж байна. Сургалтын явцад 1 эмэгтэй оюутан гарсан бөгөөд одоогийн байдлаар 42 оюутан суралцаж байна.



**УММА-ын мэргэжлийн багш нарыг төслийн баг болон компаниудтай хамтран сургалтанд хамруулах**

- "GIZ" төслийн хүрээнд 2025 оны 11 дүгээр сарын 06,07-ны өдрүүдэд арга зүйч Б.Аззаяа, Г.Өлзиймөнх нарыг УБ хотод сургалтад хамруулав.
- 12 дугаар сарын 01-нээс 12-ны хооронд нийт 11 багш, ажилтныг "Трансвест Монголиа" компаний зохион байгуулсан ХАБЭА сургалтад хамруулав.

2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр төслийн нээлтийг зохион байгуулах ажлыг хариуцаж ажилласан.










Хосмог-УММА хэлэлцүүлэг

ХАБЭА сургалт

**Багшийн дижитал ур чадвар, техник технологийн болон заах арга зүйн ур чадварыг хөгжүүлэх**

- Залуу багш нарт "Удирдагч гэж хэн бэ?" сэдэвт сургалтыг ахмад багш, МУ-ын зөвлөх багш Л. Отгончимэг сургалт хийж, сургалтад 46 багш хамрагдсан.
- 2025 оны 10 дугаар сарын 07-ноос 08-ны өдрүүдэд МУЗөвлөх багш Л.Долгорсүрэн багш нарт "Хөтөлбөр боловсруулах арга зүй" сэдэвт сургалтад 46 багш хамрагдсан.
- 2025 оны 10 дугаар сарын 22-нд Дижитал AI-сургалт нийт багш нарын дунд зохион байгуулж 29 багш хамрагдсан.
- 2025 оны 11 дүгээр сарын 12-ны Монголын багш нарт зориулсан, mozaBook, mozaWeb-ийн тусламжтайгаар сургалтын үйл явцыг шинэ түвшинд хүргэхэд чиглэсэн цуврал вебинарын эхний сургалтад Ерөнхий эрдмийн тэнхмийн 7 багш хамргдсан.

Мэргэжлийн боловсролын арга зүйч Б.Аззаяа  анги даасан багш нарт “Журнал хөтлөх арга зүй” сургалтСургалтын чанар, эрэлтийн нийцлийг сайжруулах

Сургалтын чанарыг сайжруулахын тулд багш нарын хичээлд сууж арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Үүний тулд дараах ажлуудыг хийв.

- 2025 оны 10 дугаар сард арга зүйч нараар хичээлд суух төлөвлөгөө гаргуулж, түүнд хяналт тавьж ажилласан.
- Ерөнхий эрдэм, МБОС, ТБОС хариуцсан арга зүйч нар нийт 31 багшийн хичээлд сууж зөвлөн тусласан байна.
- Хичээл үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэхийн тулд сургалтад явсан багш нарын хичээлийг хөдөлгөөнт хуваариар нягтруулж орсон.

**Мэргэжлийн багш нарын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, харилцан туршлага судлуулна**

- 2025 оны 6 дугаар сар болон 8 дугаар сард Сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэлийн багш бэлтгэх
- “Хяналт удирдлагын систем SCADA”, “Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн нөөц, нарны эрчим хүч” сэдэвт  2 удаагийн  сургалтад давтагдсан тоогоор 8 багш хамрагдаж, мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн.
- ХАБЭА-н багш 2025 оны 8 дугаар сард “ХАБЭА-н сургалтын журмын Эрүүл мэндийн чиг үүргийн шинэчлэл”  сургалтад хамрагдаж мэдлэг, ур чадвараа нэмэгдүүлсэн.
- Пийрсон хөтөлбөрийн 5 багш  2 хоногийн хөтөлбөр боловсруулах сургалтад хамрагдаж хөтөлбөр боловсруулах арга зүйгээ нэмэгдүүлсэн. “Өсөлттэй Өмнөговь” Эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 16 цагийн танхимын сургалтад Эрүүл мэндийн багш хамрагдаж заах арга зүйн ур чадвараа нэмэгдүүлсэн. Монгол Улсын Их Сургууль дээр байрлах Англи хэлний Мэргэшлийн Төв (COEE)-тэй хамтран зохион байгуулах Англи хэлний багш нарын танхимын сургалтад Англи хэлний багш нар хамрагдсан.

| № | Гараг | Албан хаагчдын нэрс | Албан тушаал |
|---|---|---|---|
| 1 | Даваа | Л. Чингэрэл | Сургалтын менежер |
| | | Д. Нарангарав | НТҮДСХАЗ |
| 2 | Мягмар | И. Одгэрэл | Арга зүйч |
| | | Б. Мөнхдэлгэр | Нийгмийн ажилтан |
| 3 | Лхагва | Г. Өлзиймөнх | Арга зүйч |
| | | | |
| 4 | Пүрэв | Э. Амарбаясах | Номын санч |
| | | Т. Ганбаяр | ҮМ хариуцсан ажилтан |
| 5 | Баасан | Б. Аззаяа | Арга зүйч |
| | | Б. Бямбасайхан | НТҮДСХАЗ |



## “ШИЛДЭГ ЗААХ АРГА ЗҮЙТЭЙ БАГШ” УРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛСАН ТАЙЛАН

2024-2025 оны хичээлийн жилийн “Шилдэг заах арга зүйтэй багш” шалгаруулах үйл ажиллагааг дараах шат дараалллаар зохион байгууллаа.

### НЭГ: БЭЛТГЭЛ ҮЕ

Сургуулийн “Шилдэг заах арга зүйтэй багш шалгаруулах” удирдамжийг 2 дугаар сарын 18-наас 25-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөж, уралдаанд үндсэн багш нарыг оруулсан. Арга зүйн уралдааныг сургалтын менежер, арга зүйч нар шүүхээр бэлтгэл ажлыг хангаж хүснэгтийг бэлтгэсэн. Нийт 22 асуултаар 110 оноогоор үнэлсэн.



БАТЛАВ
ЗАХИРАЛ Ч.ЭРДЭНЭТУЯА
2025 оны 02 дугаар сарын 17

ШУТИС-ИЙН ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТЕХНОЛОГИЙН ДЭЭД СУРГУУЛИЙН ХАРЬЯА ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ "ШИЛДЭГ ЗААХ АРГА ЗҮЙТЭЙ БАГШИЙГ ШАЛГАРУУЛАХ УРАЛДААН"-НЫ УДИРДАМЖ

**НЭГ. Зорилго**

Багшийн багшлахуй болон суралцагчдын суралцахуйн хөгжилд дэмжлэг болох сургуулийн сургалтын үйл ажиллагааг сайжруулж, багшийн заах арга зүйг дэмжиж, урамшуулах, түгээн дэлгэрүүлэхэд оршино.

**ХОЁР. Хамрах хүрээ**

Өмнөговь Политехник коллежийн мэргэжлийн болон ерөнхий эрдмийн тэнхимийн багш нар

**ГУРАВ. Хугацаа**

2025 оны 02.18-02.25

**ДӨРӨВ. Зохион байгуулагч**

- Сургалтын алба

**ТАВ. Үйл ажиллагаа**

**5.1 Шилдэг заах арга заах арга зүйтэй багш шалгаруулах үйл ажиллагааны зохион байгуулалт**

5.1.1 Хичээл заах багш нарын хуваарийг хичээлийн хуваарийн дагуу тэнхим хариуцсан арга зүйч нар гаргана.

5.1.2 Арга зүйч нар багш нарт зөвлөгөө, зөвлөмж өгч арга зүйгээр хангаж ажиллана.

5.1.3 Хичээлийг тухайн 7 хоногт заах сургалтын хөтөлбөр төлөвлөгөөний дагуу зохион байгуулна.

5.1.4 Хичээлд үнэлгээ хийх ажлын хэсэг томилогдоно.

5.1.5 Хичээлд үнэлгээ хийх багийн гишүүд хоркон үнэлгээ хийх дотоод зохион байгуулалтаа урьдчилан зохион байгуулсан байна.

**5.2 Шилдэг заах арга зүйтэй багш шалгаруулалтын үнэлгээний хуудас**

5.2.1 Ажиглагчийн үнэлгээ өгөх хуудас

5.2.2 Хичээлийн явцын тэмдэглэл хөтлөх хуудас

**ЗУРГАА. Шагнал урамшуулал**

Шилдэг заах арга зүйтэй багшийн уралдаанд амжилттай оролцсон багш ажилтныг шагнаж урамшуулна.

1-р байр Өргөмжлөл

2-р байр Өргөмжлөл

3-р байр Өргөмжлөл

Сургалтын алба



**А. Хичээл заах багшийн өөрийн хичээлд үнэлгээ өгөх хуудас**

| | | | |
|---|---|---|---|
| Хичээлийн сэдэв | | | |
| Хичээл заасан багшийн нэр | | | |
| Ажиглагчийн нэр | | Огноо | |
| Албан тушаал Мэргэжил | | Анги, бүлэг | |

**Онооны утга:** (Хамаарах тоог дугуйлаарай)
5 Сэтгэл хангануун, 4 Ерөнхийдөө хангалттай, 3 Дунд зэрэг, 2 Сайжруулах шаардлагатай, 1 Хангалтгүй

| Багц | | Үзүүлэлт | Үнэлгээ | | | | | Өгсөн зөвлөгөө, сайжруулах арга зам |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Эхлэл удирдлага | 1 | Сэдэл төрүүлж, сурагчдын сонирхлыг татсан байдал | 5 | 4 | 3 | 2 | 1 | |
| | 2 | Хичээлийн зорилго,зорилтоо оновчтой дэвшүүлсэн байдал | 5 | 4 | 3 | 2 | 1 | |
| Агуулга | 3 | Хичээл болон сэдэв хоорондын залгамж холбоог сонгосон байдал | 5 | 4 | 3 | 2 | 1 | |
| | 4 | Агуулга зорилго зорилтод нийцэж буй байдал | 5 | 4 | 3 | 2 | 1 | |
| | 5 | Амьдралтай холбосон байдал (Практик алхам) | 5 | 4 | 3 | 2 | 1 | |
| Арга зүй | 6 | Сургалтын аргыг сонгосон байдал | 5 | 4 | 3 | 2 | 1 | |
| | 7 | Хичээлийн үе шатыг / дидактик алхамуудын уялдаа холбоо/ оновчтой төлөвлөж, хэрэгжүүлсэн байдал | 5 | 4 | 3 | 2 | 1 | |
| Хэрэглэгдэхүүн | 8 | Сургалтын хэрэглэгдэхүүнийг сонгосон байдал (мэдлэг бүтээхэд дэмжлэг болж буй эсэх, агуулгад нийцсэн эсэх, суралцагчдад ойлгомжтой, хүртээмжтэй эсэх) | 5 | 4 | 3 | 2 | 1 | |
| | 9 | Самбарыг хичээлийн агуулга, сурагчдын мэдлэг бүтээх үйл ажиллагааг дэмжихүйцээ хөтөлсөн байдал | 5 | 4 | 3 | 2 | 1 | |
| Хугацаа | 10 | Цаг хуваарилалт (дидактик алхамуудтай нийцэж байгаа эсэх, даалгавар гүйцэтгэх хугацааны тохирц, цагтаа багтсан эсэх) | 5 | 4 | 3 | 2 | 1 | |
| Харилцаа | 11 | Багш, сурагчдын суралцах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж буй байдал (нийт сурагчдад хүртээмжтэй эсэх, сурагчийн санал бодол, хариулт сонголтод хүндэтгэлтэй хандсан эсэх ) | 5 | 4 | 3 | 2 | 1 | |

### ХОЁР: УРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

“Шилдэг заах арга зүйтэй багш” уралдаанд 2 дугаар сарын 20,21,24,25-ны өдрүүдэд зохион байгуулагдсан. Заах арга зүйн уралдаанд 45 багшаас 27 багш оролцож, 18 багш тодорхой шалтгааны улмаас оролцоогүй. Оролцоо 60%-тай оролцлоо.



**Хичээл заагаагүй багш нар:**

| № | Шалтгаан | Тоо | Багшийн нэрс |
|---|---|---|---|
| 1 | Хичээлд оролцох боломжгүй | 4 | С.Баасанхүү, Д.Шинэсар, Ц.Энхтөр, Г.Энхтуяа, |
| 2 | Шалтгаантай | 9 | С.Баатарсүрэн, Н.Булган, Ө.Ганхүлэг, Г.Мөнхбаяр, Ж. Отгонпүрэв, С.Сайнхүү, Ё.Энхбаяр, Э.Бөхтулга |
| 3 | Оролцохгүй | 3 | Д.Гантөмөр, Я.Мөнх-Оргил, Б.Эрдэнэчулуун |
| 4 | Өвчтэй | 2 | А.Ганцэцэг, Х.Ариунзаяа |

**Багш бүрийн давуу ба сайжруулах тал**:

| № | Багшийн нэр | Сайн тал | Сайжруулах санал |
|---|---|---|---|
| 1 | Б. Энхжин | Арга зүй, хүүхдийн сонирхлыг татахуйц үнэлгээний аргыг ашигласан. | Сэдэв хоорондын залгамж холбоог сайжруулах |
| 2 | С. Саруулбуян | Хичээлийн агуулга тохирсон | Хичээл зохион байгуулах төлөвлөгөө, хүүхэдтэй тулж ажиллах, ширээнээс гарах |
| 3 | Ө. Отгонбат | Практик мэдлэг, схем унших чадвар, хүүхэд өөрийн болгосон чадвар маш сайн | Цагийн төлөвлөлт, олон хувилбарт даалгавар бэлтгэх |
| 4 | Л. Дэмбэрэл | Хичээл хоорондын залгамж холбоо болон хичээл дүгнэх хэсэг маш сайн | Цаг баримтлах |
| 5 | Б. Ганболд | Техникийг өөрийн биеэр үзүүлэх, арга зүй сайн | Цаг баримтлах, төлөвлөгөөний дагуу зохион байгуулах |
| 6 | Б. Ганбаатар | PPT-хос бичигтэй, багшийн харилцаа хандлага яриа сайн | Багшийн яриа давамгай, хүүхэд бүртэй ажиллах |
| 7 | Ө. Мэндсайхан | Сэргээн санах түвшнийг боломжийн сайн олгосон | Багшийн яриа давамгай |
| 8 | Г. Баянмонголсйхан | Арга зүй, сэдэлжүүлэлт маш сайн, хичээлийг бүтцийн дагуу төлөвлөгөөгөөр явуулсан | Хүүхдийн суурийг сайн оношлох |
| 9 | Б. Лхамсүрэн | Хичээлийн бэлтгэл, PPT өнгө үзэмж тохироц сайн. Багаар зохион байгуулсан. | Онолын мэдлэгийг багаар хамтарч гаргахад анхаарах |
| 10 | З. Цогт | Хичээлийг агуулгын хүрээнд оновчтой явуулсан. | Хичээлийн алхамчлалын цагийг зөв тооцох |
| 11 | М. Надмидхорлоо | Хүүхэд бүр хийх боломжтой | Цаг тооцоолох. 23 мин хичээл орсон |
| 12 | М. Уранбаяр | | Төлөвлөлт, цагийн менежемент, арга зүй гэх мэт /арга зүйч нартай ажиллах/ |
| 13 | Ж. Нямаа | Онол туршилт хосолсон давуу талтай. Хичээлийн бэлтгэл сайн. | Цагийн менежемент 20 минут хоцорч эхэлсэн. Үнэлгээ хэсгийг сайжруулах |
| 14 | Ч. Хандсүрэн | Багаар ажиллах арга сонгосон Хэрэглэгдэхүүн маш сайн | |

| | | | |
|---|---|---|---|
| | | Мэдлэг бүтээлгэсэн | |
| 15 | Н. Мөнхцэцэг | Багаар ажиллах арга сонгосон Хүүхэд бүрийн оролцоог хангахыг зорьсон | Багаар хуваахдаа ширээ сандлаа цэгцлэх |
| 16 | А. Мянганбаяр | Сэдэлжүүлэлт сайн, Онол дадлага хосолсон | Цагийг тооцох, 23 минутад хичээл явуулсан |
| 17 | Б. Чухал | Онолын мэдлэг сайн байна. | Зорилго зорилтоо тодорхойлох, сул үг хэллэгээ засах, хүүхэдтэй тулж ажиллах |
| 18 | Ч. Зулзага | Сэргээн санах түвшин сайн | Цагийг зөв хуваарилах |
| 19 | Б. Отгонбаяр | | АРГА ЗҮЙЧ НАР БҮХЛЭЭР НЬ АЖИЛЛАХ |
| 20 | Б. Өнөр | Багш дагуулан сургах аргыг ашигласан. | Хүүхэд бүрийг оролцуулахад өргөн хараатай ажиллах |
| 21 | Ч. Галхүү | Хичээлийн бүтэц, алхамчлал цэгцтэй, төлөвлөгөөний дагуу зохион явуулсан | |
| 22 | Н. Алтанхуяг | | АРГА ЗҮЙЧ НАР БҮХЛЭЭР НЬ АЖИЛЛАХ |
| 23 | З. Цэрэндагва | PPT өөр программаар хийсэн. | Бичвэр томруулах, онолын мэдлэгийг хүүхдээр гаргуулах |
| 24 | Л. Жаргалсайхан | Хичээлийн бэлтгэл сайн | |
| 25 | Д. Нарантуяа | Багаар ажиллуулсан. Дасгал даалгавар оновчтой сайн. | Багш өөртөө итгэлтэй ярих |
| 26 | Г. Энхтөр | | |
| 27 | Б. Уранзул | Хичээлийн бэлтгэл маш сайн. Багаар ажиллуулсан. | Буруу ойлгосныг зөв болгоогүй |







## ГУРАВ: ШАЛГАРУУЛАЛТ

27 багшийн заах арга зүйн уралдааныг 22 шалгуураар арга зүйч-2, сургалтын менежер-1 нийт 3 албан хаагчийн онооны дунджаар байр хувь тооцож байр эзлүүлэв.

### Уралдааны тэргүүн байр:

**1 дүгээр байр**-88.2% Ч. Хандсүрэн

**2 дугаар байр**-87.7% Л. Дэмбэрэл

**3 дугаар байр**-85.5% Б. Лхамсүрэн

| ШУТИС-ИЙН ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТДС-ИЙН ХАРЬЯА ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| "ШИЛДЭГ ЗААХ АРГА ЗҮЙТЭЙ БАГШ" ур чадварын уралдааны удирдамж | | | | | | | | | |
| | | | | | | | | | 2025 оны 2 сар |
| № | Багшийн нэр | 1 | 2 | 3 | Авах оноо | Авсан оноо | ГХ | Байр | Тайлбар |
| 1 | Алтанхуяг.Н | 34 | | 25 | 220 | 59 | 26.8 | | |
| 2 | Баянмонголсайхан.Г | 89 | 82 | | 200 | 171 | 85.5 | 4 | |
| 3 | Галхүү.Ч | 100 | | 86 | 220 | 186 | 84.5 | 5 | |
| 4 | Ганбаатар.Б | 69 | 63 | | 220 | 132 | 60.0 | | |
| 5 | Ганболд.Б | 73 | 74 | | 200 | 147 | 73.5 | | 18 мин хэтэрч орсон |
| 6 | Дэмбэрэл.Л | 103 | 90 | | 220 | 193 | **87.7** | 2 | |
| 7 | Жаргалсайхан.Л | 76 | 70 | | 220 | 146 | 66.4 | | |
| 8 | Зулзага.Ч | 86 | | 41 | 220 | 127 | 57.7 | | |
| 9 | Лхамсүрэн.Б | 100 | 92 | | 220 | 192 | **87.3** | 3 | |
| 10 | Мөнхцэцэг.Н | 81 | 85 | | 220 | 166 | 75.5 | | |
| 11 | Мэндсайхан.Ө | 87 | 83 | | 220 | 170 | 77.3 | | |
| 12 | Мянганбаяр.А | 91 | 85 | | 220 | 176 | 80.0 | | 17 минутын өмнө дууссан |
| 13 | Надмидхорлоо.М | 86 | 87 | | 220 | 173 | 78.6 | | 17 минутын өмнө дууссан |
| 14 | Нарантуяа.Д | 77 | 68 | 67 | 330 | 212 | 64.2 | | |
| 15 | Нямаа.Ж | 82 | | | 110 | 82 | 74.5 | | 20 мин хоцорч эхэлсэн |
| 16 | Отгонбат.Ө | 80 | 78 | | 220 | 158 | 71.8 | | |
| 17 | Отгонбаяр.Б | 56 | 70 | 35 | 330 | 161 | 48.8 | | |
| 18 | Өнөр.Б | 63 | | 49 | 220 | 112 | 50.9 | | |
| 19 | Саруулбуян.С | 64 | 51 | | 220 | 115 | 52.3 | | |
| 20 | Уранбаяр.М | 64 | 68 | | 220 | 132 | 60.0 | | 10 мин хоцорч эхэлсэн |
| 21 | Уранзул.Б | | 89 | 67 | 220 | 156 | 70.9 | | |
| 22 | Хандсүрэн.Ч | 102 | 92 | | 220 | 194 | **88.2** | 1 | |
| 23 | Цогт.З | 84 | 86 | | 220 | 170 | 77.3 | | |
| 24 | Цэрэндагва.З | 77 | | 66 | 220 | 143 | 65.0 | | |
| 25 | Чухал.Б | 76 | 78 | 47 | 330 | 201 | 60.9 | | |
| 26 | Энхжин Б | 90 | 85 | | 220 | 175 | 79.5 | | |
| 27 | Энхтөр.Г | | 81 | | 110 | 81 | 73.6 | | |
| | | | | | | | 69.6 | | |



## ЯВЦЫН ЗУРГУУДААС




























ШУТИС-ИЙН ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТЕХНОЛОГИЙН ДЭЭД СУРГУУЛИЙН ХАРЬЯА ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ
"Шилдэг заах арга зүйн уралдаан"
БАГШ: М.НАДМИДХОРЛОО


ШУТИС-ИЙН ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТЕХНОЛОГИЙН ДЭЭД СУРГУУЛИЙН ХАРЬЯА ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ
"Шилдэг заах арга зүйн уралдаан"
БАГШ: Б.БАЯНМӨНГӨЛСАЙХАН


ШУТИС-ИЙН ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТЕХНОЛОГИЙН ДЭЭД СУРГУУЛИЙН ХАРЬЯА ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ
"ШИЛДЭГ ЗААХ АРГА ЗҮЙН УРАЛДААН"
БАГШ: Ч.ХАНДСҮРЭН


ШУТИС-ИЙН ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТЕХНОЛОГИЙН ДЭЭД СУРГУУЛИЙН ХАРЬЯА ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ
"ШИЛДЭГ ЗААХ АРГА ЗҮЙН УРАЛДААН"
БАГШ: Ө.ОТГОНБАТ


ШУТИС-ИЙН ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТЕХНОЛОГИЙН ДЭЭД СУРГУУЛИЙН ХАРЬЯА ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ
"ШИЛДЭГ ЗААХ АРГА ЗҮЙН УРАЛДААН"
БАГШ: Б.БАЯНМӨНГӨЛСАЙХАН


ШУТИС-ИЙН ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТЕХНОЛОГИЙН ДЭЭД СУРГУУЛИЙН ХАРЬЯА ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ
"ШИЛДЭГ ЗААХ АРГА ЗҮЙН УРАЛДААН"
БАГШ: Л.ДЭМБЭРЭЛ


ШУТИС-ИЙН ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТЕХНОЛОГИЙН ДЭЭД СУРГУУЛИЙН ХАРЬЯА ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ
"Шилдэг заах арга зүйн уралдаан"
БАГШ: Б.ГАНБОЛД



## ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛИЙН УРАЛДААН

Монгол Улсын хэмжээнд Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарын дунд жил бүр уламжлал болгон явуулдаг “Оны шилдэг илтгэл” шалгаруулдаг үндэсний хурлыг 1967 оноос тухайн үеийн Сурган Хүмүүжүүлэх Ухааны хүрээлэн “Сурган хүмүүжүүлэх уншлага” нэртэйгээр зохион байгуулж эхэлсэн бөгөөд 2009 оноос Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн “Боловсрол судлалын оны шилдэг илтгэл” шалгаруулах эрдэм шинжилгээний хурал хэлбэрээр зохион байгуулж ирсэн. Боловсрол судалгааны үндэсний хүрээлэнгээс 58 дахь удаагийн ЭШИ-ийг **“БОЛОВСРОЛЫН ШИНЭЧЛЭЛД ЭЦЭГ ЭХИЙН ҮҮРЭГ, ОРОЛЦОО”** нэртэйгээр зарласан.

Өмнөговь аймгийн Боловсролын газраас 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдөр удирдамж боловсруулан явуулсны дагуу байгууллагадаа 12 дугаар сарын 03-ны өдөр удирдамж боловсруулан, 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдөр 5 үндсэн шалгуурын дагуу дүгнэж, үйл ажиллагааг зохион байгууллаа. Уралдааны зочин шүүгчээр Боловсролын газрын мэргэжилтэн асан Л.Цэцэгмаа багшийг урьж оролцуулсан. Илтгэлд 7 илтгэл, 17 багш оролцсоноос ерөнхий эрдмийн 8 багш, мэргэжлийн 9 багш байв. Өмнөх жилээс **13%**-аар ахисан үзүүлэлттэй байв. Илтгэлийн 1 дүгээр байрыг Б.Уранзул, Х.Ариунзаяа, Б.Баянмонголсайхан багш нар “Хөгжлийн бэрхшээлтэй эцэг эхийн үүрэг, оролцоо” сэдэвт илтгэл тавьж тэргүүлсэн. 2 дугаар байрыг З.Цэрэндагва, Ч.Зулзага, Д. Энхбаяр багш нар “Политехник коллежийн суралцагчдын мэргэжлийн төлөвшил дэх эцэг эхийн оролцоо” илтгэлээр, 3 дугаар байрыг Ж.Нямаа, Ж.Баярмаа “Боловсролын шинэчлэлд эцэг эхийн оролцоо, үүрэг” сэдэвт илтгэлээр тус тус эзэлсэн.

*Илтгэлд оролцсон багш нарын тоо*




*Сүүлийн 5 жилийн тоо үзүүлэлт*




Илтгэлийн зургаас..









Магадлан итгэмжлэгдсэн Политехник коллеж

**БАГШ, АЖИЛТНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТАЙЛАН**

2025-05-27

Монгол Улсын Боловсролын Сайдын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/246 тоот тушаалаар батлагдсан “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын жилийн үйл ажиллагааны гүйцэтгэл, чанар, үр дүнг байгууллагын жилийн үйл ажиллагааны гүйцэтгэл, чанар, үр дүнг үнэлж, үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг олгоход баримтлах аргачлал”-ын 2.3 дахь заалтын дагуу шалгуур үзүүлэлтээр энэ журмын 3.3-д заасан аргаар үнэлгээг зохион байгууллаа. Үнэлгээг дараах үйл явцаар гүйцэтгэлээ.

## НЭГ: БЭЛТГЭЛ ҮЕ

Захирлын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/63 тоот тушаал “Багш ажилтны ажлын гүйцэтгэлийн үнэлгээ зохион байгуулах үнэлгээний багийг томилох тухай” тушаалаар 11 бүрэлдэхүүнтэй баг томилогдсон. Ажлын хэсэг хуралдаж багш ажилтныг үнэлэх шалгуур үзүүлэлтийг Монгол Улсын Боловсролын Сайдын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/246 тоот тушаалын хавсралтад заасан шалгуур үзүүлэлтийн дагуу дэлгэрэнгүй шалгуурыг боловсруулсан. Багш, ажилтны хуралд танилцуулж, санал солилцсон.

5 дугаар сарын 12-ноос 14-ний хооронд гардан хариуцах материалыг шалгах хуваарь гаргаж, хуваарийн дагуу үнэлгээ хийж ажиллалаа.

*Зураг 1: Ажлын хэсгийн тушаал*



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТЕХНОЛОГИЙН ДЭЭД СУРГУУЛИЙН ХАРЬЯА ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

Багш, ажилтны ажлын гүйцэтгэлийн үнэлгээ зохион байгуулах үнэлгээний багийг томилох тухай

*Зураг 2: Багш нарын шалгах хуваарь*



ШУТИС-ИЙН ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТДС-ИЙН ХАРЬЯА ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН БАГШ НАРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭНД ХАМРАГДАХ ХУВААРЬ

2025. 05. 08.

| № | Овог нэр | Групп | № | Овог нэр | Групп | № | Овог нэр | Групп |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | [illegible] Х | I групп | 1 | Лхамсүрэн Б | II групп | 1 | Сайнхүү С | III групп |
| 2 | Баасанхүү С | | 2 | Мөнхбаяр Г | | 2 | Саруулбуян С | |
| 3 | Баянмөнхсайхан Г | | 3 | Мөнх-Оргил Я | | 3 | Уранбаяр М | |
| 4 | Баярмаа Ж | | 4 | Мөнхзаяа Н | | 4 | Уранзул Б | |
| 5 | Бямбаа Э | | 5 | Мэндсайхан Ө | | 5 | Хандсүрэн Ч | |
| 6 | Булган Н | | 6 | Мянганбаяр А | | 6 | Цолмон З | |
| 7 | Ганхүү Ч | | 7 | Нарантогтох М | | 7 | Цэрэндолгор З | |
| 8 | Ганбаатар Б | | 8 | Нэргүйтуяа Д | | 8 | Чухал Б | |
| 9 | Ганболд Б | | 9 | Нямаа Ж | | 9 | Шинэсэлэр Д | |
| 10 | Гантөмөр Д | | 10 | Отгонбат Ө | | 10 | Энхбаяр Б | |
| 11 | Ганзориг Ө | | 11 | Отгонбаяр Б | | 11 | Энхжин Б | |
| 12 | Гансүх А | | 12 | Отгонтуяа Ж | | 12 | Энхтөр Г | |
| 13 | Дэмбэрэл Л | | 13 | Өнөр Б | | 13 | Энхмөр Ц | |
| 14 | Жаргалсайхан Л | | 14 | Сувдаа Ч | | 14 | Энхтуяа Г | |
| | | | | | | 15 | Эрдэнэчулуун Б | |

## ХОЁР: ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ

Багш ажилтны гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагдах 73 багш ажилтнаас 66 багш, ажилтан буюу 90.4% нь хамрагдсан байна. 2025 оны 3 болон 5 дугаар сараас ажилд орсон 3 ажилтан (Ж. Нарангарав, Э. Содбилэг, Т. Ганбаяр) үнэлгээнд хамрагдаагүй. Багш нарын хувьд 4 багш үнэлгээнд хамрагдаагүй. Үүнд: 1 багш өвчтэй урт хугацааны чөлөөтэй, 3 багш өөрийн саналаар үнэлгээнд хамрагдаагүй. (Л.Дэмбэрэл, А.Мянганбаяр, С.Баасанхүү, Б. Чухал)

Үйлчилгээний ажилтанг 3 үндсэн шалгуур, 7 үр дүнгийн шалгуурын хүрээнд 27 үзүүлэлтээр үнэлгээг хийв.

Багш нарыг 5 дугаар сарын 12-ноос 14-ний хооронд 4 үндсэн шалгуур 10 үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрээнд 70 үзүүлэлтээр үнэлгээг тус тус хийсэн.

Үнэлгээнд хамрагдсан багш ажилтныг графикаар харуулбал:

*График 1: Гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагдсан багш ажилтны үнэлгээ:*




Монгол Улсын Боловсролын Сайдын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/246 тоот тушаалаар батлагдасан “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын жилийн үйл ажиллагааны гүйцэтгэл, чанар, үр дүнг байгууллагын жилийн үйл ажиллагааны гүйцэтгэл, чанар, үр дүнг үнэлж, үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг олгоход баримтлах аргачлал”-ын 2.3 дахь шалгуур үзүүлэлтийн дагуу захирал, сургалтын менежер, арга зүйч, багш болон бусад ажилтныг ажлын хэсэг хуваарийн дагуу үнэлж, үр дүнг нэгтгэн гаргасан. Гүйцэтгэлийн үнэлгээнд төрийн байгууллагын хөндлөнгийн төлөөллөөс Боловсролын газрын мэргэжилтэн З.Мөнхзул болон удирдах зөвлөлийн төлөөллөөс Х.Байгалмаа нар оролцож үнэлгээ хийсэн.

Гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагдсан 66 албан хаагчийг захиргаа, үйлчилгээний ажилтан болон багшаар хэрхэн үнэлэгдсэнийг харуулъя.

*Зураг 3: Явцын зургаас.....*







Захиргаа үйлчилгээний 27 албан хаагчийн үнэлгээг харахад 90-ээс дээш үнэлгээ авсан 20 албан хаагч, 80-аас дээш үнэлгээтэй 5, 70-аас дээш үнэлгээтэй 2 албан хаагч байна.

*График 2: Захиргаа үйлчилгээний ажилчдын үнэлгээний хувийг тоогоор:*










39 багшийн үнэлгээг харахад 90-ээс дээш үнэлгээтэй 12, 80-аас дээш үнэлгээтэй 13, 70-аас дээш үнэлгээтэй 8, 60-аас дээш үнэлгээтэй 6 багш байна.

*График 3: Багш нарын үнэлгээний хувийг тоогоор*




*График 4: Үнэлгээг албан хаагчийн тоогоор харуулбал:*



*График 5: 90-ээс дээш үнэлгээ авсан багш нарын үнэлгээний хувь, нэрсээр*




*График 6: 80-аас дээш үнэлгээ авсан багш нарын үнэлгээний хувь, нэрсээр*




*График 7: 60 ба 70-аас дээш үнэлгээ авсан багш нарын үнэлгээний хувь, нэрсээр*




39 багшийн үнэлгээний дундаж хувь 82.5%-тай дүгнэгдсэн бол ажилтнуудын үнэлгээний дундаж хувь 91.3%-тай байлаа. Сургуулийн үнэлгээний дундаж хувь 86.1%-тай үнэлэгдлээ.

Захирлын ажлын гүйцэтгэлийг 3 үндсэн шалгуурын хүрээнд 12 үр дүнгийн шалгуур үзүүлэлтээр 100 оноогоор тооцож үнэлсэн.

Үнэлгээний 1.1 дэх шалгуур үзүүлэлтийг байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний сургуулийн дундаж үнэлгээ 82.83%-ийг оноонд шилжүүлж, 1.3 дахь шалгуур үзүүлэлтийг 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ 98%-ийг оноонд шилжүүлж дүнг шууд тавьсан. Үлдсэн 10 шалгуур үзүүлэлтээр холбогдох баримт бичиг болон багш ажилтны сэтгэл ханамжийн үнэлгээгээр гаргасан.

Захирал, сургалтын менежер, арга зүйч нар болон хүний нөөцийн ажилтан, ДЧБСХАА нарын хувьд багш, ажилчдаас сэтгэл ханамжийн судалгаа авч 3 дугаар үр дүнгийн шалгуурын 3 дахь үзүүлэлтийг дүгнэсэн.

## ГУРАВ: ДҮГНЭЛТ

Ажлын хэсгийн 11 гишүүн Монгол улсын боловсролын сайдын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/246 тоот тушаалаар батлагдасан “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын жилийн үйл ажиллагааны гүйцэтгэл, чанар, үр дүнг байгууллагын жилийн үйл ажиллагааны гүйцэтгэл, чанар, үр дүнг үнэлж, үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг олгоход баримтлах аргачлал”-ыг баримтлан албан хаагч бүрээр шалгуур үзүүлэлтийг “Сургуулийн багш, ажилтны ажлыг үнэлэх” журмын шалгуур үзүүлэлтээс дэд шалгуурыг боловсруулан үнэлэх ажлыг зохион байгуулсан. Үнэлэх явцад дараах давуу талууд ажиглагдсан. Үүнд:

- Багш, ажилтныг үнэлэх үзүүлэлтийг нарийвчилж өгснөөр үнэлгээ бодитой гарах боломж бүрдсэн.
- Нийт багш нарт нийтлэг дутагдалтай байгаа асуудлыг илрүүлж, цаашид тухайн асуудалд анхаарч сайжруулах боломжтой
- Тухайн жилийн ажлын үр дүнг тодорхойлж, дараагийн хичээлийн жилд хамгийн эхлээд хийх ажлыг төлөвлөх боломжтой болсон.
- Үнэлгээний багийн гишүүд чадваржсан.

### ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ:

#### Сургуулийн түвшинд:

- Ажлын хэсэг хуваагдаж захиргаа, үйчилгээний ажилтан болон багш нарыг үнэлсэн нь үнэлгээ харьцангүй үнэлгээ гарах эрсдэл үүсгэсэн. Тухайлбал багш нарыг ажлын хэсгийн сургалтын албаны ажилчид, үйлчилгээний ажилчдыг ажлын хэсгийн захиргаа аж ахуйн холбондо албан тушаалтан үнэлсэн нь дутмаг байлаа.
- Багш нарын шалгуур үзүүлэлтийг илүү боловсронгүй болгоход анхаарах. /Ерөнхий эрдмийн болон мэргэжлийн багш нарын шалгуур зарим тохиолдолд нийцэхгүй байв./

#### БЕГ болон БЯ-ны түвшинд:

- Сургуулийн ажлын хэсгийн гишүүдэд зөвлөн туслах
- Шалгуурыг албан хаагч бүрээр илүү тодорхой болгож үнэлэх аргачлалыг нарийн гаргаж өгөх
- Ерөнхий боловсролын сургуулийн үнэлгээ шиг багш, ажилтныг БҮТ-өөр үнэлүүлэх боломжийг бүрдүүлэхэд дэмжлгэ үзүүлэх

## НИЙГМИЙН АЖИЛТНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

**Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг хангуулах**

2025 оны 10 дугаар сард Хүүхэд хамгааллын багийн тушаал шинэчлэн гарсан бөгөөд ажлын хэсэг төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Жилийн ажлын төлөвлөгөөг 2 зорилтын хүрээнд 24 үйл ажиллагаа төлөвлөсөн. Үүнээс эхний хагас жилд 13 нь хэрэгжсэн байна. Нийгмийн ажилтны хувьд 1 кейс, 1 бүлгийн ярилцлага, 2 ганцаарчилсан уулзалт хийгдэж, зөвлөгөө хүргэн ажилласан.Үүнээс гадна нийгмийн ажилтан, номын санч, дотуур байрны багш нар жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулж, хүүхдэд чиглэсэн ажлуудыг төлөвлөн хэрэгжүүллээ.

**Сургуулийн хүүхэд хамгаалал, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2025 онд хэрэгжсэн сургалт, үйл ажиллагаа**

Хүүхэд хамгааллын хүрээнд, эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх зорилгоор эрсдэл өндөр суралцагчдын гэрээр эргэлт хийх үйл ажиллагааг Хүүхэд хамгааллын баг анги удирдсан багш нартай хамтран зохион байгуулсан. Сургуулийн 12 суралцагч, эцэг эх, асран хамгаалагчтай хамтран хүүхэд хамгааллын багийн гишүүд анги удирдсан багшийн хамт гэрээр эргэлт хийж нөхцөл байдалтай танилцан, хяналт тавьсан.





Цагдаагийн ерөнхий газар, бусад холбогдох байгууллагын ирүүлсэн мэдээ мэдээлэл, зөвлөмжийг цаг тухай бүр цахим хаягаар дамжуулан эцэг, эх, асран хамгаалагч, суралцагчдад дамжуулж байна.





Хүүхэд хамгаалал, суралцагчдын сурах үүргийг идэвхжүүлэх, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хичээлийн цагийн таслалт хамгийн өндөр 24 суралцагчдын судалгаа гаргаж эцэг эх, асран хамгаалагч нартай хамтран ажиллаж мэдэгдэх хуудсыг хүргүүлсэн. Мөн анхаарах шаардлагатай тулгамдсан асуудал бэрхшээлийг илрүүлэх зорилгоор суралцагчидтай уулзалт хийж байна.

Зорилтот бүлгийн суралцагчдыг хичээл сургалтад тасралтгүй оролцуулах, дэмжих, мэргэжлийн туслалцааг үзүүлж ажиллаж байна. Орон нутаг, сум аймгийн хамтарсан багтай ажиллаж хүүхдийн сурах хөгжих эрхийг ханган, дотуур байраар үйлчилж эрүүл аюулгүй амьдрах суралцах боломжийг бүрдүүлж байна. Орон нутгийн хамтарсан багийн 1 шилжиж ирсэн, Улаанбаатар хот “ Өнөр бүл “ төвийн 1 суралцагч суралцаж байна. 1 кэйс хамтарсан багт шилжин үйлчилгээ үзүүлэн, хяналтад явж байна.

Багш суралцагч хоорондын болон анги хамт олон цаашлаад эцэг эх, асран хамгаалагчийн хоорондын харилцаа, хамтын ажиллагааг сайжруулан анги удирдсан багш нар “Ангийн ажлын төлөвлөгөө”-г батлуулан хэрэгжүүлдэг. Тус төлөвлөгөөнд хөгжил, хамгаалал, төлөвшлийн хүрээнд тодорхой үйл ажиллагааг тусган хэрэгжүүлж тайлагнадаг.





Хичээлийн жил бүр нийт суралцагчдын дунд тогтмол зохион байгуулдаг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөнд соёлтой оролцох, холбогдох хууль дүрмийн талаар сургалтыг аймгийн цагдаагийн газартай хамтран хэрэгжүүлсэн. Сургалтад 2 ээлжээр нийт 10, 11 дүгээр ангийн 320 суралцагч хамрагдаж холбогдох сэдвийн хүрээнд ойлголтыг хүргэсэн.





Өмнөговь аймгийн Онцгой байдлын газартай хамтран 10, 11 дүгээр ангийн суралцагч нарт аливаа болзошгүй эрсдэл, гал түймрийн аюул, ахуйн болон, бусад осол гэмтлээс хэрхэн урьдчилан сэргийлэх зөвлөмж, мөн ямар анхан шатны тусламж арга хэмжээг авах талаар мэдээлэл хүргэн ажилласан. 320 суралцагч хамрагдсан.

 

Өмнөговь аймгийн Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын газартай хамтран “Сэтгэл зүйн дархлаагаа дэмжих нь”, Цагдаагийн газартай хамтран “ Хүүхэд хамгааллын тухай хуулийн танилцуулга” , шинэчилсэн найруулгыг суралцагч нарт танилцуулж, хүүхэд ямар эрх эдлэх, ямар үүрэг хариуцлагатай сурч хүмүүжих талаар сургалтыг зохион байгуулсан. 150 хүүхэд оролцсон.

 

Хүүхэд хамгаалал; гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Цагдаагийн газартай хамтран суралцагч нарт сургалт зохион байгуулсан. Сургалтын хүрээнд Өмнөговь аймгийн Засаг Даргын санаачлан баталсан "Электрон тамхинаас татгалзаж, ирээдүйгээ хамгаалцгаая " аянд нэгдэж сэдвийн хүрээнд мэдээллийг хүргэсэн. Мөн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг болон зөрчил гэх ойлголтын ялгаа, замын хөдөлгөөнд оролцох бусад холбогдох хуулийн тухай ойлголтыг хүргэж ажилласан. Сургалтад нийт 95 суралцагч хамрагдсан. Суралцагч хүүхдүүдээс санал хүсэлт, сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлэх зэрэг нээлттэй ярилцаж сургалтыг хамтран зохион байгуулсан.

  

Өмнөговь аймгийн “Шим билэг” өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран суралцагч нарт халдварт, халдварт бус өвчний тухай сургалтыг зохион байгуулав. Сургалтад нийт 50 суралцагч оролцсон байна.

“Хүүхдээ сонсох өдөр”–ийг зохион байгуулж жил бүр хичээл сургалтын орчин нөхцөл, дотуур байрын чанар үйлчилгээ зэрэг суралцагчдаас ирүүлсэн санал хүсэлтийг хүлээн авч шаардлагатай үйл ажиллагааг зохион байгуулж сайжруулалтыг тогтмол хийж ажиллаж байна.






2025-2026 оны хичээлийн жилийн 2, 3 дугаар курсийн нийт суралцагч нарт аймгийн Онцгой байдлын газартай хамтран “ Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх” сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулсан. Сургалтын хүрээнд галын хорыг хэрхэн ашиглах үзүүлэн, анхан шатны тусламж үйлчилгээг хэрхэн авах талаар ойлголт мэдээллийг хүргэсэн.






Сургуулийн шинээр элсэн орсон 10 дугаар ангийн суралцагч нарт “Хууль дүрэм” сэдвийн хүрээнд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бусад холбогдох хуулийн тухай мэдээллийг өгөх сургалтыг улсын Өмгөөлөгч Б.Дугармаатай хамтран зохион байгуулсан бөгөөд сургалтад 10 дугаар ангийн нийт 192 суралцагч хамрагдсан.





Сургуулийн 2, 3 дугаар курсийн суралцагч нарт аймгийн Цагдаагийн газартай хамтран гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, холбогдох хууль дүрэм, бусад мэдээ мэдээллийг хүргэлээ. Мөн цахим гэмт хэрэг, түүнээс урьдчилан сэргийлэх, дэлгэцийн хэрэглээ түүний хор нөлөө тухай сургалтыг зохион байгуулсан.






Аймгийн эрүүл мэндийн газартай хамтран сургуулийн суралцагч нарт “ Бэлгийн замын халдварт өвчин, түүнээс урьдчилан сэргийлэх тухай”, өсвөр үеийн эрүүл мэнд, хэрхэн эрүүл мэндээ хамгаалах, анхаарах талаар бусад мэдээллийг хүргэж сургалт зохион байгуулав.





Хамтарсан багийн хүрээнд аймгийн Дундсайхан 4 дүгээр багтай хамтран сургуулийн дотуур байрын суралцагч нарт сургалт зохион байгуулсан. Өрхийн эрүүл мэндийн төвөөс “Бэлгийн замаар дамжих халдвар”, “Гэр бүл төлөвлөлт”, “ Өсвөр үеийн эрүүл мэнд” сэдвээр суралцагч нэрт сургалт мэдээлэл хүргэсэн. Сургалтад нийт 105 суралцагч хамрагдсан.





Суралцагчдын дунд үе тэнгийн дээрэлхэлтийг бууруулах, урьдчилан сэргийлэх, сөрөг үр дагаврыг таниулах зорилгоор аймгийн Гэр бүл, хүүхэд хөгжил хамгааллын

газартай хамтран  "Үе тэнгийн дээрэлхэлт түүнийг таслан зогсоох нь" сэдэвт сургалтыг дотуур байрын нийт 50 суралцагчид зохион байгуулсан.





Хүүхдээ сонсох өдрийн хүрээнд 2 удаагийн уулзалт зөвлөгөөнийг анги бүрийн төлөөлөл суралцагчидтай хамтран зохион байгуулж санал хүсэлтээ илэрхийлж чөлөөт ярилцлага хийв. Мөн багаар ажиллаж суралцагчид ярих, сэтгэн бодох зэрэг ур чадварт суралцдаг. Сургуулийн удирдлагууд хамтран оролцож суралцагчдын зөвлөгөөнийг тулгамдсан асуудлыг зөвлөгөө зөвлөмж хүргэн, тайлбар мэдээллийг өгч, шаардлагатай сайжруулах, зохион байгуулах ажлуудыг шийдвэрлэн дэмжин ажилладаг. Нийт дотуур байрын 15 суралцагч, бусад төлөөлөл 55 суралцагч нийт 70 суралцагч оролцсон.









10 дугаар ангийн нийт 255 суралцагчийн эрсдэлийн судалгааг нэгтгэн гаргасан. Цагдаагийн газар, ГБХХХГазартай хамтран 3 удаагийн сургалт зохион байгуулсан. МУ-д хүүхдийн байгууллага, хөдөлгөөн үүсэж хөгжсөний 100 жилийн ойн арга хэмжээнд оролцож "MAGIC DREAM" аяны хүрээнд сургуулийн Механик 1 дүгээр ангийн суралцагч Б.Жамбалсанжид шилдэг 20 захидлын 1-ээр шалгарсан.





Хичээлийн жилийн эхний улиралд 8 үйл ажиллагаа хэрэгжсэн байна. Үүнд:

- ✓ Дугуйлан клуб
- ✓ "Төв музей"-н үйл ажиллагаанд суралцагчдыг оролцуулах
- ✓ Сургуулийн аварга шалгаруулах волейболын тэмцээн
- ✓ ХГҮА-ны нээлт "Танилцах үдэшлэг"

Цаг үеийн байдал, ханиад томууны тархалт ихтэй холбоотойгоор 2026 оны 01 дүгээр сар хүртэл ХГҮА олон нийтийн үйл ажиллагааг хориглосон байна.

5 төрлийн секц дугуйланд 85 суралцагч хамрагдсан байна. Цаашид оролцоо болон дугуйлангийн нэр төрлийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.




Өнөөдрийн ирээдүй-Маргаашийн оролцоо хүүхдийн чуулганд Улаан загалмай, СӨУЗ-ийн 15 суралцагчтай оролцсон.




Дотуур байрны суралцагч нарт 4 дүгээр багийн хамтарсан баг, ӨЭМТ-тэй хамтран “Өсвөр үеийн эрүүл мэнд”, “Гэр бүл төлөвлөлт” сэдвээр сургалт зохион байгуулагдсан бөгөөд 115 суралцагч хамрагдсан.

## СУРАЛЦАГЧДЫН ХИЧЭЭЛЭЭС ГАДУУРХ СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

**Сургуулийн аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээн**

2024 оны 02 дугаар сарын 14-ны өдрөөс 17-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдаж тэмцээнд нийт 21 багийн 150 сурагч оролцов.

**Эрэгтэй:**

- ✓ 1 дүгээр байр: Ч.Хандсүрэн багштай Гагнуурын мэргэжлийн 1 дүгээр анги
- ✓ 2 дугаар байр: Б.Лхамсүрэн багштай ХАБЭА-н техникчийн анги
- ✓ 3 дугаар байр: Б.Ариунзаяа багштай УУММАЗҮ мэргэжлийн 1 дүгээр анги

**Эмэгтэй:**

- ✓ 1 дүгээр байранд: Э.Бөхтулга багштай Барилгын засал чимэглэлчин мэргэжлийн 2 дугаар анги
- ✓ 2 дугаар байранд: Ж.Баярмаа багштай ХАБЭА-н техникчийн анги
- ✓ 3 дугаар байранд Ө.Отгонбат багштай Цахилгаан техникчийн анги
- ✓ Эрэгтэй шилдэг тоглогчоор 10г ангийн Мөнхтүвшин
- ✓ Эмэгтэй шилдэг тоглогчоор
- ✓ 10л ангийн Нандинцэцэг
- ✓ Холын зайн шидэлтийг тэмцжээнд Ганбатыг Цэрэнжамц нар шалгарлаа.




**Дотуур байрын суралцагчдын дунд зохион байгуулсан “Шагайн наадгай” уламжлалт тэмцээн**

**Зорилго:**

Суралцагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, сэтгэхүйг хөгжүүлэх, өв уламжлалаа дээдлэх, танин мэдэх, эв найрамдал, багаар ажиллах чадварыг хөгжүүлэх зорилготой. 8 багийн 40 суралцагч оролцсон.

**Тэмцээний төрөл:**

- ➢ Морь уралдах
- ➢ Алаг мэлхий
- ➢ Оньсон тоглоом

Дотуур байрын багш, Оюутны зөвлөлийн хамт олон хамтран ажилласан.





**Өмнөговь аймгийн сургуулийн сурагчдад эх оронч хүмүүжил олгох үйл ажиллагаа**

Сурагчдад эх оронч хүмүүжил олгох үйл ажиллагааны хүрээнд Өмнөговь аймгийн зэвсэгт хүчний 167 дугаар ангийн хамт олонтой хамтран сургуулийн суралцагч нарт үйл ажиллагаа, сургалтыг зохион байгуулав. Тус үйл ажиллагаанд нийт 145 суралцагч оролцсон.

Үй ажиллагаа:

- Бүх төрлийн буудлагын зэвсэг, дагалдах хэрэгслийн үзэсгэлэн
- Ашиглагддаг багаж хэрэгслийн үзэсгэлэн
- Хувцас хэрэгслийг өмсөж, тайлбарлах
- Байгууллагын тухай танилцуулга





**“Жендэрийн ойлголтыг жүжигчилсэн хэлбэрээр олгох сургалт”**

**Зорилт:** Жендэрийн ойлголтыг жүжигчилсэн хэлбэрээр олгох аргачлалыг ойлгох; Жендэрийн тэгш байдал, оролцооны талаар мэдлэгийг сайжруулах: Аугусто Боал-ын Жүжигчилсэн тоглолтын аргачлалын талаарх мэдлэгийг сайжруулах; Жендэрийн ялгавартай байдлыг илэрхийлэх жүжигчилсэн хувилбаруудыг багаар ажиллан боловсруулах.

Жендэрийн ойлголтыг жүжигчилсэн хэлбэрээр олгох аргачлал, жендэрийн ерөнхий ойлголт, тэгш байдлын талаар ойлголт мэдлэгийг сайжруулах, Гатт буюу жүжигчилсэн тоглолт хэлбэрээр жендэрийн тухай ойлголтыг түгээн дэлгэрүүлэх сургалтыг дотуур байрын суралцагч нарт зохион байгуллаа. Нийт 123 суралцагчид хамрагдсан.




Улс, орон нутгийн хэмжээнд зарласан аянд нэгдэж, сургалт үйл ажиллагаанд хамрагдан суралцаж, сургуулийн суралцагчид болон олон нийтэд зерэг, зөв зан үйл, хандлага төлөвшлийг бий болгох байдалд уриалж байна.

**"Электрон тамхинаас татгалзаж, ирээдүйгээ хамгаалцгаая" аян**

Өмнөговь аймгийн Засаг Даргын санаачлан баталсан "Электрон тамхинаас татгалзаж, ирээдүйгээ хамгаалцгаая" аянд нэгдэж аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газартай хамтран сургуулийн суралцагч нарт сургалт зохион байгуулав. 2 ангийн 40 суралцагч оролцсон. Сургалтыг Өмнөговь аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын мэргэжилтнүүд мэдээлэл хүргэн ажилласан.







Суралцагчдын дунд соёл, ёс заншил түүх соёлыг таниулах зорилгоор Өмнөговь Говийн байгаль, түүхийн музейтэй хамтран “Хавцгайтын амны хадны зургийн гайхамшиг” сургалтыг зохион байгуулсан. Мөн суралцагчид илтгэгч нартай хамтран танин мэдэхүйн ажил, дасгал, асуулт хэлэлцүүлэгт оролцсон. Тус сургалт үйл ажиллагаанд 40 суралцагч хамрагдсан.









Өмнөговь аймгийн Засаг Даргын санаачлан баталсан "Электрон тамхинаас татгалзаж, ирээдүйгээ хамгаалцгаая" аянд сургуулийн дотуур байрын зөвлөлийн 15

суралцагчид цахим орчинд нэгдэж бусад суралцагч, үе тэнгийн найзууддаа уриалгыг дэвшүүлэв.







Сургуулийн хичээлээс гадуурх үйл ажиллагааны нээлт “Танилцах үдэшлэг”-ийг зохион байгуулав. Нийт шинээр элссэн 10 дугаар ангийн суралцагчид оролцсон.

Үйл ажиллагаанд:

- Хөгжөөнт тэмцээн уралдаан
- Ангиудын мэндчилгээ
- Бүжгийн уралдааныг суралцагчдын дунд зохион байгуулж суралцагчдыг идэвхтэй хамруууллаа.






**Сургуулийн аварга шалгаруулах волейболын тэмцээн**

2025 оны 11 дүгээр 08-ний өдрөөс 10-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа тэмцээнд 42 багийн 336 сурагч оролцлоо.

**Эрэгтэй:**
1 дүгээр байр: Хосмог 3 жил
2 дугаар байр: Цахилгааны техникчийн 3
3 дугаар байр: ХММЗҮ 3
**Эмэгтэй:**
1 дүгээр байранд: Цахилагааны техникчийн 2
2 дугаар байранд:Барилгын засал чимэглэлийн 2
3 дугаар байранд ХАБЭА-н техникчийн 3
**Эрэгтэй шилдэг:**
Шилдэг довтлогч Энгүүн
Шилдэг холбогч Алтан-Очир
Шилдэг хамгаалагч Батмагнай

**Эмэгтэй шилдэг:**
Шилдэг довтлогч Болор
Шилдэг холбогч Хулан
Шилдэг хамгаалагч Нарангарав нар шалгарлаа.

Тус тэмцээнийг хамтран зохион байгуулсан биеийн тамирын багш нар болон анги даасан багш нар, Ө.Отгонбат багштай цахилгааны техникч мэргэжлийн ангийн хамт олон.





Сургуулийн аварга шалгаруулах анхны суралцагчдын дундах дартсын тэмцээн эрэгтэй, эмэгтэй ганцаарчилсан төрөл дээр зохион байгуулагдаж нийт 40 суралцагч оролцож өрсөлдлөө.

**Амжилт гаргаж шагналт байранд шалгарсан суралцагчид:**

**Эрэгтэй ганцаарчилсан төрөлд:**

1 дүгээр байр Б.Ховор-эрдэнэ

2 дугаар байр Г.Ганбямба

3 дугаар байр С.Хатансайхан

4 дүгээр байр Б.Баяржавхлан

**Эмэгтэй төрөлд:**

1 дүгээр байр Э.Сайнчимэг

2 дугаар байр Н.Сувд-эрдэнэ

3 дугаар байр Б.Энхжин

4 дүгээр байр Э.Нандинцэцэг

Өндөр гарааны шагнал:

Эр: Б.Намсрай 92-с гарсан

Эм: Э.Сайнчимэг 76-с гарсан амжилт үзүүлсэн.





**Сургуулийн хүүхдийн зөвлөлийн хэрэгжиж буй болон зохион байгуулсан, оролцооны үйл ажиллагаа**

“Оюутны зөвлөл”-өөс “Бидний ертөнц” сэдвийн хүрээнд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгууллаа. Тус хэлэлцүүлгээр суралцагчид өөрт болон сургуулийн орчинд тулгамдаж буй асуудал, үе тэнгийн дээрэлхэл, сургуулийн орчны электрон тамхины хэрэглээ зэрэг асуудлыг хэрхэн анхаарах, бууруулах талаар санал, зөвлөмж хэлэлцэв.





Хөвгүүдийн уулзалт сургалт, багийн үйл ажиллагаа зохион байгууллаа. Суралцагчид өөрт тулгамдсан асуудлуудаа ярилцлаа. Мөн удахгүй болох Оюутнуудын эрдэм шинжилгээ, урлаг спорт, соёлын олон төрөлт арга хэмжээ зохион явуулах, чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, шинэ төрлийн ажлыг санаачлан хөгжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх, тэдний нийтлэг эрх ашгийг төлөөлөн хамгаалах тал дээр хамтарч ажиллах талаар ярилцлаа.





Жил бүр тэмдэглэдэг "Хүмүүнлэгийн өдөр"-ийг тохиолдуулан аймгийн Улаан загалмай хорооноос зохион байгуулсан үйл ажиллагаанд манай сургуулийн Удирдах зөвлөлийн 9 гишүүн суралцагч идэвхтэй оролцсон.






Сургуулийн орчинд сургууль болон суралцагчтай холбоотой дүрэм журмыг мөрдүүлэх, оюутны хариуцлагыг өндөржүүлэх, сахилга батыг төлөвшүүлэх хүрээнд дотуур байр, сургуулийн хүүхдийн зөвлөлийн суралцагчид жижүүр суралцагчийн үүрэг гүйцэтгэсэн.






Хүүхдийн зөвлөл, сурагчдын өөрөө удирдах байгууллагын төлөөлөл суралцагчид “Top teens” өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, нөлөөллийн төсөлд цахим тэнхим хосолсон сургалтад хамрагдаж мэдлэг ур чадвараа дээшлүүлж байна.






Хүүхдийн зөвлөлийн суралцагчид сургалт, хүүхдийн хөгжил, ур чадвар, мэдлэгийг дээшлүүлэх олон нийтийн үйл ажиллагаанд тогмол оролцож, сургалтад хамрагдан, тэмцээн уралдаанд идэвхтэй хамрагдаж байна.







Монгол Улсад Хүүхдийн байгууллага, хөдөлгөөн үүсэж хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд Megic dream захидлын уралдаанд оролцож шилдэг 20 захидлын нэгээр шалгарсан.






Өмнөговь аймгийн оюут 7 дугаар багийн хамтарсан багийн зарласан “Цахим хэрэглээний давуу болон сул тал” илтгэлийн уралдаанд сургуулийн хүүхдийн зөвлөлийн гишүүн Б.Чинбаяр шангалт 2 дугаар байранд шалгарсан.



Сургуулийн зохион байгуулж буй сургалт, арга хэмжээнд оролцох болон өөрсдийн чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрөөх, цаашид идэвхтэй багаар ажиллах, шинэ санаа, нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд анхаарч байна.








**2025 онд сургууль дээр хичээллэсэн дугуйлан, клуб хамрагдсан суралцагчид**

| № | Дугуйлангийн нэр | Хариуцсан багш | Хүүхдийн тоо |
|---|---|---|---|
| **1** | Англи хэл ярианы клуб | Б.Энхжин | 25 |
| **2** | Бүжгийн дугуйлан | Б.Аюуш | 16 |
| **3** | Хөгжмийн дугуйлан | С.Туяахүү | 15 |
| **4** | Волейболын секц | Баянмонголсайхан, Б.Ганболд | 43 |
| **5** | U darts клуб | М.Уранбаяр | 18 |
| **6** | Математикийн дугуйлан | Б.Отгонбаяр | 10 |
| Нийт | | | 127 |

**Дугуйлан, секцийн үйл ажиллагааны зураг**













2025-2026 оны хичээлийн жилийн амжилт гаргасан суралцагчдыг 12 дугаар сард тодруулан шагнаж урамшуулсан.

- “ШИЛДЭГ ОЮУНЛАГ СУРАЛЦАГЧ” Хэвлэл график дизайн мэргэжлийн 3 дугаар анги Э.Бат-Эрдэнэ,
- “ШИЛДЭГ БҮТЭЭЛЧ СУРАЛЦАГЧ” Цахилгаан хангамж тоног төхөөрөмжийн ашиглалт мэргэжлийн 3 дугаар анги Э.Жамсран,

- “ШИЛДЭГ АВЬЯАСЛАГ СУРАЛЦАГЧ” Уул уурхайн машин механизмын ашиглалт 2 дугаар анги Г.Энх-амгалан,
- “ШИЛДЭГ ТАМИРЧИН СУРАЛЦАГЧ” Хоол үйлчилгээ 3 дугаар анги Бүжинлхам,







- “ШИЛДЭГ АНГИ ХАМТ ОЛОН” Монгол улсын Мастер тогооч, хоол үйлдвэрлэлийн Д.Нарантуяа багштай Хоол үйлчилгээний 3 дугаар анги хамт олон шалгарсан.

## НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Энэ хичээлийн жилд номын санг хичээлийн 1 дүгээр байранд номын фондны хажуу өрөөнд нүүлгэн засвар хийж өргөтгөсөн бөгөөд хүүхэд багш нарт ая тухтай орчин бүрдүүлж ажилласан. 10 дугаар сарыг "Ардын аман зохиол"-ын сарын аяны дагуу дотуур байрны суралцагч бүрийг түргэн хэллэг, зүйр цэцэн үг, ертөнцийн гурав, оньсого тааврыг таалгаж цээжлүүлсэн 120 сурагчийн 67 суралцагч 55.8% цээжилж оролцсон.

11 дүгээр сарын 03-наас 07-ны хооронд сургуулийн номын сангийн үйл ажиллагааг суралцагчдад сурталчлах өдөрлөгийг нийт МБОС 3 жилийн анги, МБОС 1 жилийн анги, ТБОС ангиуд, хосмогийн 1.5 жил 3 жилийн ангиудын нийт 42 ангийн 341 буюу 33.1% ирцтэй зохион байгуулсан.

Номын санчийн хувьд “Гар утаснаас-Номын сан руу” ажлыг зохион байгуулж, дотуур байрны хүүхдүүдийг сургалтад хамруулж байна.

4 дүгээр улиралд 1 дүгээр курсын 112 суралцагч 178 ном, 2 дугаар курсын 126 суралцагч 151 ном, 1 жилийн ангийн 31 суралцагч 51 ном, техникчийн 40 суралцагч 68 ном сурах бичгийг уншиж судалсан. Нийт 309 оюутан номын сангаар үйлчлүүлсэн байна. 14 нэр төрлийн 53 ш ном сурах бичгийг 198.000 төгрөгөөр авсан




11 дүгээр сарын 03-наас 07-ны хооронд сургуулийн номын сангийн үйл ажиллагааг суралцагчдад сурталчлах өдөрлөгийг МБОС 3 жилийн анги, МБОС 1 жилийн анги ТБОС ангиуд хосмогийн 1.5 жил 3 жилийн ангиудын нийт 42 ангийн 341 буюу 33.1% суралцагч номын сантай танилцаж өөрсдийн мэргэжлийн ном сурах бичигтэй танилцсан.

2025-2026 оны хичээлийн жилд дотуур байранд 9 аймаг, 3 хотоос 13 төрөл мэргэжлээр, мэргэжлийн боловсрол эзэмшихээр 146 оюутан суралцагчид эрүүл, аюулгүй таатай нөхцөл боломжоор хангагдан суралцаж байна.

## “МОНГОЛ УР ЧАДВАР” СУРГУУЛИЙН ШАТНЫ УРАЛДААН

Боловсролын Ерөнхий газрын Даргын 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/200 дугаар тушаалаар баталсан “Мэргэжлийн болон техникийн боловсролын ур чадварын уралдаан зохион байгуулах журам”-ын хэрэгжилтийг хангаж, БЕГ-аас ирсэн зөвлөмж чиглэлийн дагуу сургуулийн шатны уралдааныг дараах үе шаттай зохион байгууллаа.

### НЭГ: БЭЛТГЭЛ ҮЕ

“Монгол ур чадвар-2025” уралдааныг сургуулийн шатанд зохион байгуулах бэлтгэл ажлын хурлыг 2025 оны 3 дугаар сарын 06-ны өдөр хуралдаж, уралдаан зохион байгуулах багийг хамт олны саналд үндэслэн эксперт багш нарыг мэргэжил бүрээр томилж 20 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Уралдаан зохион байгуулах багт орсон сургуулийн шатны эксперт багш нар болон удирдлага хуралдаж тэмцээний ур чадварын даалгавар, бусад асуудлаар хэлэлцлээ.





Уралдаан зохион байгуулах баг уралдаанд оролцох мэргэжил, оролцогчдын тоог гаргасан. Зохион байгуулах багийн нарийн бичиг уралдаан зохион байгуулах төсөв, шагналын төсөв, хуваарийг нэгтгэн гаргаж, сургуулийн захирлаар батлуулсан. Бэлтгэл ажлын төлөвлөгөөг 30 үйл ажиллагаа хийхээр төлөвлөн батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан.

Уралдаанд оролцогчдын тоог графикаар харуулбал:



Хамгийн их зардал гаргасан мэргэжлүүдийг харуулбал:




| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | "Монгол ур чадвар-2025" сургуулийн шатны уралдааны төсөв | | | | |
| | | | | | 2025.03.11 |
| **№** | **Материалын нэр** | **Хэмжих нэгж** | **Тоо хэмжээ** | **1 бүрийн үнэ** | **Нийт үнэ** |
| 1 | Өргөмжлөл | ширхэг | 2 | 15000 | 30000 |
| 2 | Мандат | ширхэг | 1 | 15000 | 15000 |
| 3 | А3 фото цаас | ширхэг | 1 | 24000 | 24000 |
| 4 | Медаль | ширхэг | 66 | 9000 | 594000 |
| 5 | Бор дугтуй | ширхэг | 22 | 2500 | 55000 |
| 6 | Заалны чимэглэл | | | | |
| 7 | | | | | |
| Нийт | | | | | 718000 |

3 дугаар сарын 12-ний өдөр сургалтын менежер Л. Чингэрэл, арга зүйч Б. Аззаяа нар мэргэжил бүрээр техникийн зөвлөгөөний хийж, эксперт багш нар тэмцээний зарчмаа танилцуулсан.

## ХОЁР: УРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Ур чадварын уралдааны нээлтийг 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдөр Багш хөгжлийн ордны урлагийн танхимд зохион байгуулсан. Нээлтийн арга хэмжээнд аймгийн БГ-ын дарга Д. Баасанхүү, Даланзадгад сумын Засаг дарга Ц.Дэнээдорж, мэргэжлийн боловсрол болон их дээд сургууль хариуцсан БГ-ын мэргэжилтэн З.Мөнхзул, ХХҮГ-ын Хөдөлмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтэн Ц.Сололго, н.Байгальсайхан нар урилгаар оролцож амжилт хүссэн. Үүнээс гадна сургуулийн нийт багш, ажилтан, суралцагч,

удирдлага оролцлоо. Монгол ур чадвар уралдааны “Эксперт багш”-ийн тангараг өргөх ёслолыг МУ-ын Эксперт Хэвлэлийн график дизайнч мэргэжлийн багш З.Цэрэндавга, МУ-ын Эксперт Гагнуурын мэргэжлийн багш Ө.Ганхүлэг болон сургуулийн эксперт багш нар оролцсон бол оролцогчийн тангарагийг Дэлхийн ур чадварын уралдааны "Дэлхийн стандарт хангасан Алтан медальт, Үндэсний ялагч Гагнуурын мэргэжлийн багш Б.Чухал удирдан өргөж, албан ёсоор эхэлсэн.



Даланзадгад сумын засаг дарга Ц. Дэнээдорж



БГ-ын дарга Д. Баасанхүү



Захирал Ч. Эрдэнэтуяа



Сургуулийн шатны эксперт багш нарын тангараг өргөх ёслол



Сургуулийн шатны нээлтэд оролцсон багш нар

03 дугаар сарын 13-ны өдөр 7 мэргэжлийн 13 ангийн ур чадварын уралдаан амжилттай зохион байгуулсан. 03 дугаар сарын 13-наас 14-ний өдрүүдэд зохион байгуулахаар төлөвлөсөн боловч Өмнөговь аймагт Улаан бурхан өвчин бүртгэгдэж, аймгийн онцгой комисс хуралдан хичээлийг цахимд шилжүүлэх захирамж гарснаар 3 дугаар сарын 14-ний ур чадварын тэмцээн тодорхойгүй хугацаагаар хойшилсон. 3 дугаар сарын 17-ны өдөр 2 дахь өдрийн тэмцээнийг 9 мэргэжлээр 11 ангийн ур чадвар, 3 дугаар сарын 18-ны өдөр 1 мэргэжлээр 2 ангийн ур чадварын уралдааныг зохион байгуулж шилдгүүдээ шалгаруулсан.

Ур чадварын уралдаан бүрийг сургуулийн Захирал, сургалтын менежер, арга зүйч нар болон бусад ажилчид нээж, шалгалтын сэдвийг задлан шалгалт явагдах дэг болон даалгаврын оноог танилцуулж явуулсан.

**Оролцогчдын тоог өдөр өдрөөр харуулбал:**

| **№** | **Өдөр** | **Оролцогчдын тоо** |
|---|---|---|
| 1 | 3 дугаар сарын 13 | 129 |
| 2 | 3 дугаар сарын 17 | 181 |
| 3 | 3 дугаар сарын 18 | 15 |
| **Бүгд** | | **325** |

## Үйл явцын зургаас...

















## ГУРАВ: ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

“Монгол ур чадвар” сургуулийн шатны уралдаанд 12 мэргэжлээр 325 оролцогч оролцож, шилдгийн шилдэг 63 оролцогчийг шалгаруулан шагналаа. Шагнал гардуулах үйл ажиллагааг орон нутгийн нөхцөл байдал, шийдвэрээс шалтгаалан 2025 оны 03 дугаар сарын 21-ны 15:00 цагаас зохион явуулсан. Шагнал гардуулах үйл ажиллагаанд аймгийн БГ-ын дарга Д. Баасанхүү, БГ-ын сургалт арга зүйн албаны дарга Б. Шинэбаяр нар оролцлоо. Уралдааны үйл ажиллагааг дэмжин орон нутгийн дараах байгууллагууд хамтран ажилласан. Үүнд:

1. “Тотель” Өмнөговь салбар
2. “Соёмбо” бичиг хэргийн дэлгүүр
3. “Говь хангай андууд” ХХК
4. “Эрдэнэ -2” авто засварын төв
5. “Ариунтуулай” ХХК
6. “Есөн-Эрдэнэ” дэлгүүр
7. “Ундрал -Илч” ХХК
8. “Ган-Оч” барилгын материалын дэлгүүр
9. “Говийн-Өргөө” жуулчны бааз
10. “Хурд авто сервис” ХХК
11. “Төгөлдөр анд” ХХК

ЬЬШагнал гардуулах явцын зургаас..








**Шилдэг эхний 3 байрт шалгарсан суралцагчдын гүйцэтгэлийг мэргэжил бүрээр харуулбал:**

1 дүгээр ангийн гүйцэтгэлийн хувь:

| № | Мэргэжлийн ангийн нэр | 1-р анги | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тэргүүн байр | | Дэд байр | | Гутгаар байр | |
| | | ГХ | Нэр | ГХ | Нэр | ГХ | Нэр |
| 1 | Гагнуур | | | | | | |
| 2 | Механикжсан тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээ | 94.5 | Б. Насмрай | 93.5 | Э. Пүрэвдорж | 89 | Ц. Бадамлхам |
| 3 | Оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 97 | Г. Номинжин | 96 | Э. Хураа | 94 | А. Нандин-Эрдэнэ |
| 4 | Барилгын бүтээц угсралт-өрөг | 95.3 | Б. Номлуун | 93.3 | М. Энхмэнд | 92 | Б. Отгонжаргал |
| 5 | Барилгын бүтээц угсралт-засал | 65 | Б. Мятав | 45.3 | А. Анужин | 36.6 | Э. НандинЭрдэнэ |
| 6 | Барилгын бүтээц угсралт-мужаан | 85 | Б. Мөнгөнбат | 80.5 | Э. Баасанцэнд | 78.5 | Б. Болд-Эрдэнэ |
| 7 | Цахилгаан хангамж, тоног төхөөрөмжийн ашиглалт | 95.53 | М. Нандин-Оргил | 94.03 | М. Тэмүүлэн | 93.14 | А. Буян-Оргил |
| 8 | Мэдээллийн технологи | 62.7 | Т. Тэмүүл | 57.7 | Б. Ховор-Эрдэнэ | 44.7 | Б. Оюундарь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | Хэвлэлийн график дизайн | 90.6 | Н. Мэндбаяр | 89.6 | Г. Хэрлэн | 77.6 | Б. Болортунгалаг |
| 10 | Механик | | | | | | |
| 11 | Уул уурхайн машин механизмын ашиглалт | 92.5 | Б. Тэмүүлэн | 89.5 | Х. ЭнхАмгалан | 88.5 | Б. Батцэнгэл |
| 12 | Хоол үйлдвэрлэл | | | | | | |

2 дугаар ангийн гүйцэтгэлийн хувь

| **№** | **Мэргэжлийн ангийн нэр** | **2 дугаар анги** | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | **Тэргүүн байр** | | **Дэд байр** | | **Гутгаар байр** | |
| | | **Гүйцэтгэл** | **Нэр** | **Гүйцэтгэл** | **Нэр** | **Гүйцэтгэл** | **Нэр** |
| 1 | Гагнуур | 56 | Г. Номин | 39 | Ч. Тэмүүгэн | 36 | Г. Сүхбаатар |
| 2 | Механикжсан тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээ | 99 | А. Алтаншагай | 97 | Б. Отгонболд | 94 | Т. Тэмүүжин |
| 3 | Оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 97 | Б. Сувдаа | 94 | С. Удвал | 89 | Г. Болорцэцэг |
| 4 | Барилгын бүтээц угсралт-өрөг | 93.6 | Э. Хосжаргал | 93.4 | Т. Бэлэгүүн | 92.6 | А. Давгадорж |
| 5 | Барилгын бүтээц угсралт-засал | 91.3 | Ш. Эрдэнэжавхлан | 91 | М. Ундрах | 90.9 | М. БатИрээдүй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | Барилгын бүтээц угсралт-мужаан | 87.5 | Г. Ганхөлөг | 86.5 | У. Золбоо | 85 | Б. Баярсайхан |
| 7 | Цахилгаан хангамж, тоног төхөөрөмжийн ашиглалт | 94.6 | Э. Жамсран | 94 | Б. Эрхэм | 88.93 | С. Эрдэнэсүх |
| 8 | Мэдээллийн технологи | 78.7 | М. Адъяахүү | 75.3 | Ц. Туул | 74 | М. Мөнгөнсаран |
| 9 | Хэвлэлийн график дизайн | 93.6 | М. Жаргалцэцэг | 93.3 | Ц. Индра | 85 | М. Цэвээнлхам |
| 10 | Механик | 96.6 | С. Эрхэмбилэг | 96.3 | О. Энхтайван | 93.6 | Х. Хүслэнзаяа |
| 11 | Уул уурхайн машин механизмын ашиглалт | 99 | Э. Азбилэг | 98.5 | Б. Содномжамц | 98 | Б. Содбаяр |
| 12 | Хоол үйлдвэрлэл | 100 | Г. Мөнх-Ирээдүй | 99.4 | Э. ХосЭрдэнэ | 99.1 | Б. Бүрэнзаяа |

1 дүгээр байрт шалгарсан мэргэжлүүдийн гүйцэтгэлийг графикаар харуулбал:

**1-р ангийн гүйцэтгэл:**




**2 дугаар ангийн гүйцэтгэл:**




Мэргэжил бүрээр ур чадварын даалгавар харилцан адилгүй боловсруулагдсан.

## ДӨРӨВ: ДҮГНЭЛТ, ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

1. Сургуулийн шатны ур чадварын тэмцээний зохион байгуулалт, аж ахуй нэгжийн дэмжлэг өмнөх жилээс ахисан түвшинтэй байлаа.

2. Үйл ажиллагаанд аймаг орон нутгийн удирдлага, салбарын удирлагууд ач холбогдол өгч оролцон улс болон дэлхийн ур чадварт оролцох суралцагчийг бүрэн дэмжихээ илэрхийлсэн нь онцлог байлаа.

Цаашид анхаарах асуудал: Сургуулийн түвшинд:

1. Сургуулийн хэмжээний эксперт багш нарыг чадваржуулах
2. Мэргэжил бүрээр ур чадварын даалгаврыг “Дэлхийн ур чадвар” тэмцээний жишигт дөхүүлж боловсруулах
3. Багш болон зохион байгуулах багийн гишүүдийг улс болон дэлхийн ур чадварын тэмцээн үзүүлэх, туршлага судлуулах
4. Үнэлгээний багийн үнэлээч ажил олгогчдыг мэргэшүүлэх

“МОНГОЛ УР ЧАДВАР 2025” улсын уралдаанд 7 мэргэжлээр оролцов.

**“**Монгол Ур Чадвар-2025” II шатанд 5 суралцагч Үндэсний ялагчийг шалгаруулах 3 дугаар шатанд оролцох эрхээ авсан том амжилтыг тус тус үзүүллээ. Үүнд:

1. Барилгын хуурай хийцийн технологи мэргэжлээр 1 дүгээр байранд Барилгын заслын 2 дугаар ангийн сурагч М.Ундрах орсон бөгөөд бэлтгэсэн Барилгын мэргэжлийн багш А.Ганцэцэг;
2. Хэвлэл график дизайны мэргэжлээр 2 дугаар байранд Хэвлэл график дизайн мэргэжлийн ангийн төгсөгч Ц.Индра орсон бөгөөд бэлтгэсэн Компьютерын мэргэжлийн багш З.Цэрэндагва;
3. Хоолны үйлчилгээ-Тогооч мэргэжлээр 2 дугаар байранд Тогоочийн ангийн суралцагч О.Амин-Эрдэнэ 2 дугаар байранд орсон бөгөөд бэлтгэсэн Хоол үйлдвэрлэлийн мэргэжлийн багш Д.Нарантуяа;
4. CNC ТОКАРЬ мэргэжлээр 3 дугаар байранд Үйлдвэрлэл тоног төхөөрөмжийн механик мэргэжлийн ангийн төгсөгч Соёл-Эрдэнийн Эрхэмбилэг орсон бөгөөд бэлтгэсэн Токарь мэргэжлийн багш Л.Жаргалсайхан;
5. ГАГНУУР мэргэжлээр 3 дугаар байранд гагнуурын мэргэжлийн ангийн төгсөгч Г.Номин орсон бөгөөд бэлтгэсэн Гагнуурын мэргэжлийн багш  Л.Дэмбэрэл;



Тогоочийн ангийн суралцагч О.АМИН-ЭРДЭНЭ



Барилгын заслын 2-р ангийн сурагч М.УНДРАХ




Үйлдвэрлэл тоног төхөөрөмжийн механик мэргэжлийн ангийн төгсөгч С.Эрхэмбилэг




Хэвлэл график дизайн мэргэжлийн ангийн төгсөгч Ц.Индра




Гагнуурын мэргэжлийн ангийн төгсөгч Г.НОМИН

# ГУРАВДУГААР БҮЛЭГ

# НИЙГМИЙН ТҮНШЛЭЛ, ГАДААД ХАРИЛЦАА

# НИЙГМИЙН ТҮНШЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

## Гадаад хамтын ажиллагаа

1.Олон Улсын ACQUIN магадлан итгэмжлэлийн үйл ажиллагаатай танилцах сургалтад 2 ажилтанг 2025 оны 06 дугаар сарын 22-ноос 07 дугаар сарын 03-ны өдрүүдэд Герман Улсын Байрут хотод хамруулсан.

2.2025 оны 02 дугаар сарын 19-ноос 27-ны өдрүүдэд Итали улсад Эразмус+ хөтөлбөрийн хүрээнд (Монголд насан туршийн боловсрол; Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал) төслийн хүрээнд сургалтын төвүүдээр дамжуулан Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын (ХАБЭА) сургалтын хөтөлбөрийг дижитал хэлбэрт шилжүүлж, турших зорилготойгоор дижитал цахим сургалтын боловсролын хэрэгслийг нэвтрүүлэх, үйл ажиллагаатай танилцах сургалтад Захирал Ч.Эрдэнэтуяа, багш С.Сайнхүү нар хамрагдсан.

3. 2025 оны 11 дүгээр сарын 01-нээс 09-ны өдрүүдэд Испианы Кадисийн Их Сургуульд зохион байгуулсан Эразмус+ хөтөлбөрийн хүрээнд 3L4MOHS (Монголд насан туршийн боловсрол; Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал) төслийн хүрээнд сургалтын төвүүдээр дамжуулан Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын (ХАБЭА) сургалтын хөтөлбөрийг дижитал хэлбэрт шилжүүлж, турших зорилготойгоор дижитал цахим сургалтын боловсролын хэрэгслийг нэвтрүүлэх, үйл ажиллагаатай танилцах сургалтад Захирал Ч.Эрдэнэтуяа, Арга зүйч И.Одгэрэл нар хамрагдсан.

Солонгос улсын Жонбук хотын Пижон их сургуультай хамтын ажиллагааны хүрээнд сэргээгдэх эрчим хүчний тэнхимийн удирдлагууд сургууль үйл ажиллагаатай танилцаж ажилласан .






Солонгос улсын Жонбук хотын Пижон их сургуультай хамтын ажиллагааны хүрээнд сэргээгдэх эрчим хүчний ангид Цахилгааны техникчийн ангийн суралцагчид элсэж суралцахаар боллоо.






БНХАУ-ын Бээжин хотын Бейфанг автомашины сургалтын төвийн гадаад харилцаа хүний нөөцийн албаны ажилчид ирж хамтран ажиллах талаар уулзалт хийлээ.




БНХАУ-ын Бээжингийн Вэйфанг Автомашины сургалт судалгааны төвийн хамтын ажиллагааны үйл ажиллагаа









**Гадаадын мэргэжлийн зөвлөх мэргэжилтэн урьж ажиллуулах**

1. Сайн дурын ажилтан авч ажиллах хүсэлтийг Койка Олон Улсын байгууллагад хүргүүлсэн.
2. Жендерийн сайн дурын мэргэжилтэн урьж ажиллуулах хүсэлтийг Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгтэй хамтран хэрэгжүүлэхээр хүсэлтийг Австралийн Элчин Сайдад албан бичиг хүргүүлсэн бөгөөд одоогоор хүлээгдэж байна.

Нийт 2 байгууллагад 2 сайн дурын ажилтны хүсэлт хүргүүлсэн.

**Дотоодын мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагатай хамтран ажиллана.**

1.Техник Технологийн Дээд сургуультай хамтран ажиллах гэрээ байгуулан Багш магистрын сургалтад 19 багш сургалтад хамрагдаад явж байна.
2.Бакалаврын мэргэжлээр 4 багш мэргэжлийнхээ эчнээ ангид суралцаж байна.
3.Техник Технологийн Политехник коллеж болон Монгол Солонгосын ПТК ийн үйл ажиллагаатай тус сургуулийн 24 багшийг туршлага судлах ажлыг зохион байгуулсан.
4.Зүүн болон Говийн бүсийн 8 аймгийн 8 Мэргэжлийн боловсролын байгууллагын 192 багш ажилтын туршлага судлах уулзалт зөвлөгөөн зохион байгуулагдлаа. Энэхүү үйл ажиллагаанд:

- Илтгэлийн уралдаан
- Заах арга зүйн уралдаан
- Туршлага солилцох уулзалт
- Спортын 4 төрлийн тэмцээн уралдааныг амжилттай зохион байгууллаа.

5.2025 оны 11 дүгээр сард Дундговь аймгийн Политехник коллежийн Цахилгаан хангамж тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ мэргэжлийн “Монгол ур чадвар - 2025” уралдааны II шатны оролцогч, багш нар тэмцээний хамтарсан бэлтгэл, туршлага судалж хамтран ажиллав.
6.Үйлдвэр урлалын Политехник коллежтой хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.





7.Ховд аймгийн Хөгжил Политехник коллеж, Говь-Алтай аймгийн Мэргэжлийн боловсролын сургууль, Баянхонгор аймгийн Политехник коллеж, Дорноговь аймгийн Политехник коллежийн үйл ажиллагаатай багш удирдах ажилтнууд нийт 45 хүн туршлага судалсан.

**Дотоодын хамтын ажиллагаа нийгмийн түншлэл**

Засгийн газраас хэрэгжүүлж буй Бүсчилсэн хөгжлийн хүрээнд төмөр замын үйл ажиллагааг өргөжүүлэх ажлын хүрээнд мэргэжилтэй ажилтан бэлтгэх ажлыг хийж ажлын байраар хангах ажлыг хамтран хийхээр болсон. Тус ажлын хүрээнд Монголын төмөр замтай хамтран ажиллах санамж бичиг байгууллаа.

Тус байгууллагын мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэхэд чиглэсэн уулзалтыг зохион байгуулан, тухайн байгууллагын үйл ажиллагаатай танилцах, мэргэжил сурталчлах зэрэг ажлыг хамтран удаа дараагийн уулзалтаар хамтран зохион байгуулж ажилласны үр дүнд хамтран ажиллах гэрээг байгуулж Төмөр замын барилга, зам, замын ашиглалт,

- ✓ Галт тэрэгний ашиглалт, засвар, үйлчилгээ
- ✓ Төмөр замын барилга, замын ашиглалт гэсэн 2 мэргэжл ээр 24 оюутан сург алтад



Хичээлийн жилийн эхний улиралд 7 аж ахуйн нэгж байгууллагатай хамтран ажиллах түншлэлийн гэрээ байгуулсан байна.

1. “Дотоодын цэргийн 810” дугаар анги УУА, Баяжуулахын оператор 2 мэргэжлээр 30 хугацаат цэргийн алба хаагч, хүүхэд суралцуулж байна.
2. “Дижитал өгөгдөл” дата төв ОНӨААТҮГ Мэдээллийн технологийн суралцагчдыг дадлагат гаргах
3. “Монголын төмөр зам” ТӨХК Төмөр замын 2 мэргэжлээр 30 хүүхэд элсүүлэн сургах
4. “ӨБЦТС” ТӨХК Т.Жаргалсайхан Цахилгааны мэргэжлийн ангийн суралцагчдыг дадлагажуулах
5. “Говийн-Анир” ХХК Мэдээллийн технологийн мэргэжлийн ангийн суралцагчдыг Үйлдвэрлэлийн дадлагат гаргах
6. “ДДЦСтанц” ТӨХК цахилгаан, дулаан, сэргээгдэх, гагнуур, механик цахилгаан, гагнуур, механик үйлдвэрлэлийн дадлагат гаргах
7. “Дэлхий дүүрэн” ХХК барилгын мужаан мэргэжлийн суралцагчдыг дадлагат гаргах





Өмнөговь аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хүрээнд Аймгийн Ойн ангитай хамтран элсэгчдийг бүрдүүлж мэдээллийг нэгтгэж, 16 оюутанг сургаж байна.

**Танилцах дадлага, үйлдвэрлэлийн болон төгсөхийн өмнөх үйлдвэрлэлийн дадлагыг удирдан зохион байгуулах**

1. **Үйлдвэрлэлийн дадлага**

2 дугаар курсын 15 мэргэжил, ХАБЭА, Барилга угсралт мэргэжлийн 287 суралцагчдад үйлдвэрлэлийн дадлагат гарахын өмнөх нэгдсэн сургалтыг аймгийн ХХҮГ,

Эрүүл мэндийн газар, ОБГ, Цагдаагийн газартай хамтран хийж, дадлагын хугацаанд ямар нэгэн зөрчилгүй, 141 аж ахуй нэгж дээр дадлагад гарч, тайлан хамгаалалтыг амжилттай зохион байгуулсан. Нийт 15 мэргэжлийн 287 суралцагч тайлан хамгаалахаас хүндэтгэх шалтгаантай 25, тасалсан 10, тайланг 252 суралцагч амжилттай хамгаалан нийт суралцагчдын дундаж үнэлгээ 87.8%-тай үнэлэгдсэн бол дадлага удирдсан багш нарын үнэлгээ 92.2%-тай байна.

Үйлдвэрлэлийн дадлагын удирдамж боловсруулан сургуулийн Захирлаар батлуулж, явцын хяналтыг дадлага удирдсан багш нартай хамтран хийж ажилласан.

1. дадлага удирдсан багшийн төлөвлөгөө
2. дадлагын дэвтэрийн орлого хураалт
3. суралцагчдыг дадлагат авсан ААНБ-ын дата судалгаа мэргэжил тус бүрээр гаргах
4. дадлага удирдсан багшийн үнэлгээ
5. ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгаа, тайлан
6. суралцагчийн сэтгэл ханамжийн судлагаа, нэгтгэл
7. дадлагын тайлан хамгаалалтыг зохион байгуулж дүн нэгтгэл, тайланг гаргасан байна.

Дадлагад гарсан оюутнуудын талаар ажил олгогчдоос сэтгэл ханамжийн судалгаа авч үзэхэд

1. Маш сайн буюу онц үнэлгээ: **30.7%**
2. Сайн үнэлгээ **53.1%**
3. Дундаж буюу дунд **8.9%**
4. Хангалтгүй буюу муу **7.3%** нь үнэлсэн байна.

Дээрх судалгаанаас харахад нийт суралцагчдын 53.1 хувь нь Үйлдвэрлэлийн дадлагаар үйлдвэрлэл дээр ажиллахад хангалттай гэж үнэлэгдсэн байна.




**Ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаа**

1. маш сайн буюу онц үнэлгээ: 30.7%
2. сайн үнэлгээ 53.1%
3. дундаж буюу дунд 8.9%
4. хангалтгүй буюу муу 7.3% нь үнэлсэн байна.

Дээрх судалгаанаас харахад нийт суралцагчдын 53.1 хувь нь Үйлдвэрлэлийн дадлагаар үйлдвэрлэл дээр ажиллахад хангалттай гэж үнэлэгдсэн байна.

АНХААРАХ АСУУДЛУУД:

Мэргэжлийн онолын сууръ мэдлэгийг эзэмшсэн байдал, түүнийгээ практикт хэрэгжүүлэх чадвар

Ажлын ачаалал даах чадвар

Ажлын байрны аюулгүй байдлыг хангах, осол гаргахгүй ажиллах, аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөх чадвар

Хувийн зохион байгуулалт: Ажлаа зөв төлөвлөж, хугацаанд нь гүйцэтгэх чадвар

Ажлын байранд болон үйлчлүүлэгчидтэй харилцах ур чадвар

Ажлын байранд бие даан ажиллах чадвар

Асуудлыг түргэн таньж, шийдвэрлэх арга зам олох чадвар

Ажлыг хариуцлагатай гүйцэтгэж, хяналт тавих чадвар

Өөрчлөлттэй орчинд дасан зохицох чадвар

3.1 Еренхий суурь чадамж Доорх ур чадвар /Тухайн сургуулийн дадлагажигч, төгсөгчийг чадамж тус бүрээр бэлтгэсэн байдлыг 1-5 хооронд үнэлнэ үү/. 1-Маш тааруу, 2-Тааруу, 3-Дунд, 4-Сайн, 5-Онц сайн




3.2 Мэргэжлийн болон техникийн ур чадвар Доорх ур чадвар /Тухайн сургуулийн дадлагажигч, төгсөгчийг чадамж тус бүрээр бэлтгэсэн байдлыг 1-5 хооронд үнэлнэ үү/




## ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн тайлангийн хүрээнд: Гагнуур, Цахилгаан, УУММУЗҮ, Хоол үйлдвэрлэл мэргэжлийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааг дахин судалж дата нэгтгэлийг гарган ажилласан болно.

| Огноо | Төгсөгч | Хөдөлмөр эрхэлж байгаа | Хувь | |
|---|---|---|---|---|
| 2020-2021 | 36 | 25 | 69% | **82.3%** |
| 2021-2022 | 27 | 23 | 85.10% | |
| 2022-2023 | 34 | 34 | 100% | |
| 2023-2024 | 23 | 19 | 82.60% | |
| 2024-2025 | 27 | 20 | 70.00% | |

**Гагнуурын мэргэжлээр**: Хөдөлмөр эрхлэлт жилээс жилд өсөхийн зэрэгцээ дэвшин суралцах цаашлаад уул уурхайн хүнд үйлдвэрлэлийн нэр хүндтэй, салбартаа тэргүүлэгч аж ахуйн нэгж байгууллагад ажиллаж байна.

| Огноо | Төгсөгч | Хөдөлмөр эрхлэж байгаа | Хувь | |
|---|---|---|---|---|
| 2020-2021 | 24 | 17 | 70,8% | **86%** |
| 2021-2022 | 20 | 15 | 75% | |
| 2022-2023 | 25 | 25 | 100% | |
| 2023-2024 | 23 | 23 | 100.00% | |
| 2024-2025 | 23 | 19 | 82.60% | |

**Цахилгааны мэргэжлээр:** Хөдөлмөр эрхлэлт жилээс жилд өссөхийн зэрэгцээ дэвшин суралцах мөн сургуулийн хэмжээнд төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтээрээ хамгийн өндөр хувьтай байна.

| Уул уурхайн машин механизмын угсралт засвар үйлчилгээ мэргэжлийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Огноо | Төгсөгч | Хөдөлмөр эрхлэж байгаа | | Дэвшин суралцсан | | Бусад |
| | | Мэргэжлээрээ | Мэргэжлээс өөр ажил хөдөлмөр эрхлэж байгаа | Их дээд сургууль | Техникчийн боловсрол | |
| 2020-2021 | 24 | 3 | 9 | | | 12 |
| 2021-2022 | 21 | 13 | | | | 8 |
| 2022-2023 | 25 | 11 | 6 | | | 8 |
| 2023-2024 | 24 | 8 | 4 | 3 | 4 | 5 |
| 2024-2025 | 23 | 15 | 3 | 4 | | 1 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Нийт** | **117** | **50** | **22** | **7** | **4** | **37** |

**70.9%** нь ажил хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд мэргэжлээрээ 42.7%, мэргэжлийн бус ажил хөдөлмөр эрхэлж байгаа 18.8% байгаа бол 5.9% нь их дээд сургуульд, 3.4% нь техникчийн мэргэжлээр дэвшин суралцаж, 31.6% нь бусад шалтгаантай ажил хөдөлмөр эрхлэхгүй байна.

| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ | ААН-ИЙН ТОО | ТӨГСӨГЧИЙГ АЖИЛД АВСАН ТОО |
|---|---|---|
| Цахилгаан | 59 | 42 |
| Гагнуур | 25 | 21 |
| Уул уурхай | 42 | 33 |
| Хоол үйлчилгээ | 23 | 15 |






| ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллежийн төгсөгчдийн мөшгих судалгаа /**Тогооч буюу хоол үйлдвэрлэл/** | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| № | МЭРГЭЖИЛ | ОГНОО | ТӨГСӨГЧИЙН ТОО | ХӨДӨЛМӨР ЭРХЭЛЖ БАЙГАА | МЭРГЭЖЛЭЭРЭЭ | МЭРГЭЖЛИЙН БУС | ДЭВШИН СУРАЛЦАЖ БУЙ | БУСАД |
| 1 | Хоол үйлдвэрлэл | 2020-2021 | 9 | 4 | 3 | 1 | 1 | 4 |
| 2 | Хоол үйлдвэрлэл | 2021-2022 | 11 | 10 | 9 | 1 | | 1 |
| 3 | Хоол үйлдвэрлэл | 2022-2023 | 12 | 12 | 12 | | | |
| 4 | Хоол үйлдвэрлэл | 2023-2024 | 14 | 8 | 6 | 2 | | 6 |
| 5 | Хоол үйлдвэрлэл | 2024-2025 | 13 | 6 | 2 | 4 | 1 | 6 |
| | **нийт** | | **59** | **40** | **32** | **8** | **2** | **17** |
| Нийт төгсөгчдийн **67.7** хувь нь ажил хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд мэргэжлээрээ **54.2%**, мэргэжлийн бус ажил хөдөлмөр эрхэлж байгаа **13.5%** байгаа бол **3.3%** нь дэвшин суралцаж, **28.8%** нь бусад шалтгаантай ажил хөдөлмөр эрхлэхгүй байна. Бусад гэдэгт: маамаалсан, хүүхдээ харж байгаа, холбоо барьж чадаагүй зэрэг багтана. | | | | | | | | |

| **АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ** | **ОРОЛЦОО** |
|---|---|
| Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл | ДДЦС, Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, МАК, М Си Эс, Эрдэнэс тавантолгой ХК-иас хөтөлбөрт санал ирүүлж хөтөлбөрт санал өгч ажиллав. |
| Мэргэжлийн зөвлөлийн хийх ажилд санал дүгнэлт | ОюутДДЦС, Гүний-Ус, Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, ХХҮГ, Өмнөговийн Инженерүүдийн холбоо, Ихэр баян говь, Даян байгаль ХХК, Эрдэнэ-2, Говь хангай андууд, Тоорой ХХК-ийн олгой, Моннис, Эрдэнэс тавантолгой, Энержи ресурс, МАК ХХК, М Си ЭС интернейшнл, |
| Үйлдвэрлэлийн дадлага, дадлагын тайлан хамгаалах | Мэргэжлийн зөвлөлийн 5 ААН-ийн ИТА үйлдвэрлэлийн дадлагын тайлан хамгаалахад үнэлээчээр оролцсон байна. |
| Үйлдвэрлэлийн дадлагат ажил олгогчоор | Мэргэжлийн зөвлөлийн 28 ААН байгууллага болон нэмэлтээр 113 ААН байгууллага үйлдвэрлэлийн дадлагат суралцагчдыг авч ажиллуулсан байна. |
| Тогооч нарын говийн бүсийн уралдаан | Говийн бүсийн тогооч нарын аварга шалгаруулах тэмцээнд “Хоол үйлчилгээ” мэргэжлийн 2.3 дугаар ангийн суралцагчдыг татан оролцуулан туршлага судлуулах ажлыг зохион байгууллаа. |
| Хосмог сургалтын нээлтийн арга хэмжээ | ДДЦС, Гүний-Ус, Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, ХХҮГ, Өмнөговийн Инженерүүдийн холбоо, Ихэр баян говь, Даян байгаль ХХК, Эрдэнэ-2, Говь хангай андууд, Тоорой ХХК-ийн төлөөлөл болон мэргэжлийн зөвлөлийн гишүүд хүрэлцэн ирж оролцов. |

| | |
|---|---|
| Удирдах зөвлөлийн хурал | Аймгийн ХХҮГ, Даян байгаль, МАК, Зам бүрд ХХК-ийн дарга, удирдлагууд зөвлөлийн хуралд гишүүнээр ажиллаж хуралд оролцон сургуулийн үйл ажиллагааг хэвийн явуулахад дэмжлэг үзүүлэн ажиллав. |
| Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт | М Си ЭС интернейшнл, МАК, ДДЦС, Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Ихэр баян говь, Хасуд бат, Интерфериаз, Говь хангай андууд, Урлан венз ХХК-д төгсөгчдийг ажлын байраар хангасан. |
| **ДҮГНЭЛТ:** | **Мэргэжлийн зөвлөл:** 28 ААН байгууллагын төлөөлөлтэй. Хүннүгийн говь, Ужим-Од ХХК-аас бусад 26 мэргэжлийн зөвлөлийн төлөөлөл сургуулиас зохион байгуулсан ажил арга хэмжээнд оролцож сургуулийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн хамтран ажилласан байна. |

**Байгууллагын захиалгат болон богино хугацааны сургалт зохион байгуулах**

- ХХҮГазартай хамтран ажиллах гэрээний дагуу ХАНХСС-ны хүрээлэнгээс санхүүжүүлсэн "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2025" үйл ажиллагааны хүрээнд ХММО-ын 1 сарын сургалтыг 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс эхлүүлсэн. Төгсөлтийн үнэлгээ 2025 оны 12 дугаар сарын 30-нд зохион байгуулахаар төлөвлөж, төгсөлтийн үнэлгээ зохион байгуулах тухай албан хүсэлтээ ХАНХСС-ны хүрээлэнд хүргүүлсэн Арга зүйч И.Одгэрэл хариуцан ажиллаж байна.
- Оюу толгой ХХК сайтад ажиллах ажилчдын ТОП 2 сургалтыг 9-12 дүгээр сарын хугацаанд 115 иргэнд явуулсан байна.
- В ангилал 51 хүн, М ангилал 29 хүн, “Оюу толгой” ХХК-ны М ангиллын 77, ВЕ ангиллын 124 хүний үнэлгээний хуудсыг баталгаажуулсан.

АЖИЛ ХӨДӨЛМӨРТ БЭЛТГЭХ СУРГАЛТ /3 САР/-ЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ




**ХЗЗ-ийн эрэлт хэрэгцээ, ажил мэргэжлийн стандартад нийцүүлэн сургалтын агуулга, хөтөлбөрийн шинэчлэлийг үе шаттайгаар зохион байгуулах**



Нийгмийн түншлэл, үйлдвэр сургалт хариуцсан арга зүйч Б.Бямбасайхан Мэргэжлийн 10 байгууллагаас хөтөлбөрийн шинэчлэлд санал хүсэлт авсан байна. Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд орж буй 3 мэргэжлийн хөтөлбөрт ажил олгогчдоос санал авч хөтөлбөрт тусгахын зэрэгцээ МБОС-13, ТБОС-2 мэргэжилд нийт 65 ажил олгогч байгууллагаас судалгаа авч нэгтгэл тайланг гаргасан.

## ЭЛСЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2025-2026 оны хичээлийн жилийн элсэлтийн хяналтын тоо Боловсролын Сайдын 2025 оны 06 дугаар сарын 12-ны А/340 тушаалаар батлагдсан. Манай Политехник коллежийн хувьд энэ хичээлийн жилд Мэргэжлийн боловсролын 3 жилийн ангид 10 мэргэжлээр 190 оюутан, Мэргэжлийн боловсролын 1 жилийн ангийн 6 мэргэжлээр 100 оюутан, Техникийн боловсролын 1.5 жилийн ангид 5 мэргэжлээр 75 оюутан, Техникийн боловсролын 3 жилийн ангид 2 мэргэжлээр 35 оюутан нийт 400 оюутан элсүүлэхээр батлуулсан. Боловсролын Сайдын 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/509 тоот тушаалаар 403, хосмог сургалтаар 96 нийт 499 оюутан элсүүлэхээр батлуулсан.

2025-2026 оны хичээлийн жилийн Элсэлт зохион байгуулах ажлын хэсэг Захирлын тушаалаар байгуулагдан, төлөвлөгөө боловсруулан, бүс орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгааг нэгтгэн, мэргэжил сурталчлах ажлыг зохион байгуулсан. 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс 29-ны өдрүүдэд зүүн болон баруун сумдын ЕБС-аар элсэлтийн сурталчилгаа хийсэн 2025-2026 оны хичээлийн жилд нийт 10 мэргэжлээр 257 суралцагч элсүүлсэн бөгөөд элсэлт 35% -иар давсан байна. ТБ-ын 1,5 жилийн 5 мэргэжлээр 105 суралцагчаас 95 элссэн байна. Хувь 90,4%-тай байна. ТБ -ын 3 жилийн 2 мэргэжил Хосмог сургалтад 35 суралцагч элсүүлэхээс 32 элссэн байна. Хувь 91,4%. Тус ангид бусад орон нутгаас 5 суралцагч ирж амжилттай суралцаж байна. 2025-2026 оны хичээлийн жилд МБС нийт 936 суралцагч сурч байна.

### БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД

| Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл | Нэгдмэл удирдлага | Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ | Олон улсын магадлан итгэмжлэл | Удирдлагын өгсөн үүрэг чиглэлийн биелэлт |
|---|---|---|---|---|
| Шалгуур: 1.1, 1.2, 1.5, 1.6, 5.1.1, 5.2.3, 5.5.2, 6.1.2, 6.2.2 заалтуудын тайланг бичсэн байна. | Стандартын хүрээнд албан тушаалын тодорхойлолтын хүрээнд журмуудаа шинэчлэв. | Улирлын гүйцэтгэлийн шалгуур тус бүрийг хувиар тооцон, нотолгооны хамт хүргүүлж ажилласан. | Ажлын хэсэгт орж, онлайн сургалтад хамрагдан, шалгуурт албан тушаалын тодорхойлолтын хүрээнд хийгдэх ажлуудад зөвлөгөө мэдээлэл авч, төлөвлөгөөний хүрээнд ажиллах ба нууцын гэрээ байгуулсан байна. | Захирал болон сургалтын менежерийн өгсөн 41 үүрэг чиглэлийг 100% гүйцэтгэж ажилласан. |

### ЭЛСЭЛТИЙГ ҮР ДҮНТЭЙ ЗОХИОН БАЙГУУЛАХ

| Мэргэжил | Мэргэжлийн боловсрол /3 жил/ | Мэргэжлийн боловсрол /1 жил/ | Техникч | Богино хугацааны сургалт |
|---|---|---|---|---|
| Хяналтын тоо | 190 | 122 | 110 | **140** |
| Элсэлтийн тоо | 256 | 105 | 57 | **30** |
| Хувь | **139.4%** | **86%** | **19.2%** | **21.4%** |

Нийт элсэлтйн хяналтын тоо **422** –оос **418** суралцагч элсүүлэн **99%**-ийн гүйцэтгэлтэй байна. Жич: Дээрх хяналтын тоонд Богино хугацааны сургалтын элсэгчдийн тоо ороогүй. Мөн нийт элсэгчдийг хувь хангалттай байгаа ч чанарын хувьд учир дутагдалтай бөгөөд техникчийн мэргэжлээр элсүүлэх суралцагч хангалтгүй үзүүлэлттэй байгаа нь цаашид бид элсэлт зохион байгуулах үйл ажиллагаанд: Техникчийн мэргэжлээ түлхүү сурталчлах шаардлагатай болж байна.

**Онцлог:** Түншлэгч ААН байгууллагын хүний нөөцийг мэргэшүүлэх чиглэлээр олон удаагийн уулзалт, сургалт зохион байгуулснаар МБОС-ын 1 жилийн ангийн элсэлт хангалттай үзүүлттэй байж **АНХ УДААГАА 1028 ОЮУТАН СУРАЛЦАГЧ-тай** хичээлийн жилийн үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлж байна.

Германы ОУХАНийгэмлэгийн “GIZ” төслийн “Уурхайн машин механизмын ашиглалт” техникчийн 1.5 болон 3 жилийн ангийн хосмог сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж байна. Уг хөтөлбөрийн хүрээнд 2025 оны 04 дүгээр сард “GIZ” төслийн Зөвлөх багш, “Трансвест” ХХК, “МСМ групп” ХХК, “Сэндвик” ХХК-ны ИТА, багш нарын төлөөлөл, хамтран “Уурхайн машин механизмын ашиглалт” техникчийн Мэргэжлийн стандартыг боловсруулсан. Мөн 2025 оны 05 дугаар сар, 08 дугаар сард төслийн баг, ИТА, багш нараас бүрдсэн баг Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулан, сургуулийн Захирлаар баталгаажуулж сургалтад ашиглаж байна.

2025 оны 09 дүгээр сарын 15-наас УММА мэргэжлээр 43 оюутан элсэн суралцаж эхэлсэн. Нийт оюутнуудын 17 эмэгтэй, 26 эрэгтэй буюу 40:60 харьцаатай байна.




Сургалтын төлөвлөгөөний дагуу ЧН хөтөлбөрүүдийг арга зүйч болон мэргэжлийн багш нарт дамжуулан өгсөн.

12 дугаар сарын 01-12-ны хооронд нийт 11 багш, ажилтныг Трансвеаст Монголиа компанийн зохион байгуулсан ХАБЭА сургалтад хамруулав.

2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр төслийн нээлтийг зохион байгуулах ажлыг хариуцаж ажилласан.




ЭШИ-д оролцож буй 5 багшид зөвлөмж, зөвлөгөө өгсөн. Оролцогчдын 29.4%

2025 оны 11 дүгээр сарын 17-нд “Уул уурхайн салбарт жендэрийн мэдрэмжтэй хосмог сургалтыг нэвтрүүлсэнээр “Эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх нь” төсөл, Уурхайн машин механизмын ашиглалтын техникч мэгэжлийн хосмог сургалтын нээлтийн арга хэмжээг зохион байгуулсан.

Энэ хичээлийн жилд:

-Орон нутгийн “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд “Ойн аж ахуй” МБОС-ын 1 жилийн хосмог сургалттай ангийн элсэлт авч, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг 2025 оны

10 дугаар сард Ойн ангийн ИТА, сургуулийн биологийн багш хамтран боловсруулж сургалтад ашиглаж байна.

-Ажил олгогчын захиалгат “Төмөр замын барилга, зам замын ашиглалт”, “Галт тэрэгний засвар үйлчилгээ” төмөр замын хосмог сургалттай мэргэжлийн ангийг шинээр нээв. Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг “Монголын төмөр зам” ХХК-ны ИТА, сургагч багш нартай хамтран боловсруулж сургалтад ашиглаж байна.

**Иргэнд мэргэшил болон ур чадвараа дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлж, мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг нэмэгдүүлнэ**.

Аймгийн ХХҮГазартай хамтран ажиллах гэрээний дагуу ХАБЭА-н ажилтан мэргэжлээр 27, ХММОператорч мэргэжлээр 26, нийт 53 иргэнийг хамруулж төгсгөсөн.

“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр-2025” үйл ажиллагааны хүрээнд иргэдийн хөдөлмөр эрхлэх ур чадварыг дэмжих чадамжид суурилсан мэргэжлийн сургалтыг үндэсний түвшинд чанартай зохион байгуулах зорилготой Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яамны харьяа “Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэн”, орон нутгийн ХХҮГ-тай хамтран “Хүнд машин механизмын операторч” бэлтгэх богино хугацааны үнэ төлбөргүй сургалтад ажил хөдөлмөр эрхэлдэггүй 30 иргэнийг бүртгэж, сургалтын үйл ажиллагаагаа эхлүүлээд явж байна.

**Захиалгат сургалт**

Богино хугацааны 1 сарын сургалтад Хилийн Цэргийн 131 дүгээр ангийн 26 цэргийн албан хаагчийг ХММ-ын засварчин, Цахилгаанчин мэргэжлээр, 46 ажилгүй иргэдийг Механик, Цахилгаанчин, Гагнуурчин мэргэжлээр, Зэвсэгт Хүчний 167 дугаар ангийн 89 цэргийн албан хаагчийг Бетон арматурч, Шат угсрагч, Оосорлогч дохиочин, ХММЗасварчин, Цахилгаанчин мэргэжлүүдээр 3 сарын сургалтад, ХАБЭА-н ажилтан мэргэжлээр 27, ХММОператорч мэргэжлээр 26, нийт 53 иргэнийг хамруулан төгсгөж, 10 мэргэжлийн нийт 214 төгсөгчдөд ХНХСҮСИ-ээс Чадамжийн гэрчилгээ, “Даланзадгадын Дулаан Хангамж”, ОНӨААТҮГ-ын 8 удирдах ажилтанд "Ажил олгогч, удирдах ажилтны” сургалт, 19 ажилчдад “Нийт ажилтны” захиалгат сургалт зохион байгуулж, нийт 27 иргэдэд сертификат тус тус олгосон.

Тус онд захиалгат болон богино хугацааны сургалтад 11 мэргэжлээр 241 иргэдийг хамруулж төгсгөсөн байна. 2025-2026 оны хичээлийн жилээс Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яамны харьяа “Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэн”, орон нутгийн ХХҮГ-тай хамтран “Хүнд машин механизмын операторч” бэлтгэх богино хугацааны үнэ төлбөргүй сургалтад ажил хөдөлмөр эрхэлдэггүй 30 иргэнийг бүртгэж, сургалтын үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

**Авто сургуулийн үйл ажиллагааг өргөжүүлэх, үйл ажиллагааны чанарыг сайжруулах**

2025 онд “В” ангиллын 5 удаагийн сургалтаар 95 иргэн, “М” ангиллын 6 удаагийн сургалтаар 122 иргэн, “ВЕ” ангилалд 83 иргэн, нийт 300 иргэнийг жолооны сургалтад сургаж төгсгөсөн. 2025-2026 оны хичээлийн жилээс эхлэн “В” ангиллын сургалтад 18 иргэн, “М” ангиллаар 14 иргэнийг тус тус элсүүлэн суралцуулж, нийт 32 иргэн төгсгөсөн.

“В” ангиллын сургалтад 18 иргэнийг бүртгэж, 2 дахь сургалтаа эхлүүлэн ажиллаж байна.

## Нийгмийн түншлэлийн оролцоотойгоор төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, чанар үр дүнг тооцох

Нийгмийн түншлэлийн хүрээнд 10 ажил зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд дараах ажлууд биелэсэн байна.

Бүс орон нутгийн уул уурхайн компанитай танилцах аялал зохион байгуулах

“Өсөлттөй Өмнөговь” хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хот болон бусад аймгаас ирж суралцаж буй 40 оюутны төлөөллийг "Миний мэдэх уурхай" танилцах аялалд хамруулллаа.
Танилцах аяллаар “Тавантолгой” ХК болон Дотоодын 810 дугаар цэргийн ангийн үйл ажиллагаатай танилцлаа.





**Сургуулийн үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчлан таниулах**

Уул_уурхайн_машин_механизмын_угсралт_засвар_үйлчилгээ мэргэжлээр богино хугацааны сургалтад хамрагдаж буй суралцагчдад зориулсан ӨГЛӨӨТЭЙ_ИРЭЭДҮЙ уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулж, оролцогчдын санал бодол, богино хугацааны сургалтаар суралцагчид ямар ур чадвар эзэмшээд шууд ажлын байранд гарах боломж нөхцөл хэр байгаа талаар ярилцлаа.

Уулзалтаар насанд хүрэгчдийн сургалтын эрэлт хэрэгцээ, цаашид энэ чиглэлээр яаж ажиллах талаар ярилцсан давуу талтай байв.

Цаашид хэрэглэгчдийн хэрэгцээнд нийцсэн сургалтын хөтөлбөрүүдийг хөгжүүлэхэд энэхүү уулзалт чухал хувь нэмэр оруулсан.





# ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

# БАГШИЙН ХӨГЖИЛ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

# Хүний нөөцийн мэдээлэл

**Бүтэц орон тоо**

## Нийт 74

ПТК-ийн захирал
- Захиргаа аж ахуйн алба / 20/
- Сургалтын алба /54 /

Ажилтнуудын ажилласан жил
- 1-5 жил 27
- 6-10 жил 20
- 11-15 жил 10
- 16-20 жил 9
- 20- дээш 8















Багш ажилчдын шилжилт хөдөлгөөн



**4** ТЭТГЭВЭР

Захиргаа аж ахуй -1
Жолооны багш -1
Оёмол бүтээгдэхүүний мэргэжлийн багш-1
Цахилгааны мэргэжлийн багш -1

**4** ШИНЭЭР АЖИЛД ОРСОН

ЦТТМСХА-1
ҮГБХМХА-1
СЭХҮМБ-1
Монгол хэлний багш-1

**8** АЖЛААС ЧӨЛӨӨЛСӨН

Бусад сургууль руу шилжсэн-2
Тэтгэвэрт-4
ХАЧ эхийн орон тоонд-2

**5** ХҮҮХЭД АСРАХ ЧӨЛӨӨТЭЙ

## БАГШИЙН ЗЭРЭГ

Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Сайдын 2020 оны 05 дугаар сарын 26-ны А/127 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багшид мэргэжлийн зэрэг, олгох, хасах журам”-ын дагуу ажлын хэсэг зохион байгууллаа.

Мэргэжлийн зэргийн хувьд:

- “Заах аргач” мэргэжлийн зэргийг сунгах Б.Ганболд, шинээр авах Д.Шинэсар
- “Тэргүүлэх багш” мэргэжлийн зэргийг Л.Дэмбэрэл
- “Зөвлөх багш” мэргэжлийн зэргийг багш Б.Лхамсүрэн, Ч.Зулзага нар авсан байна.




Гадаад харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлэх ажлын хүрээнд багш ажилчдын

Европын холбооны Ерасмусын "3L4MOHS Монгол улсын насан туршийн боловсрол, хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдал сургалт"ын төслийн хүрээнд ХАБЭА сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулах сургалтад Политехник коллежийн мэдээлэл технологийн багш С.Сайнхүү, Захирал Ч.Эрдэнэтуяа нар хамрагдсан.





БМИҮЗ Ази, Номхон Далайн Бүсийн Магадлан Итгэмжлэл, Гэрчилгээжүүлэлтийн Комисс (APACC)-той хамтын ажиллагааны хүрээнд 2025 оны 03 дугаар сарын 24-нөөс 28-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Филиппин улсын Манила хотод “Чанарын баталгаажуулалтыг магадлан итгэмжлэлээр хангах нь” сэдэвт сургалтыг амжилттай зохион байгууллаа.






БМИҮЗөвлөл, Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагуудын төлөөлөл ХБНГУ-ын ACQUIN (Accreditation, Certification and Quality Assurance Institute) байгууллагатай магадлан итгэмжлэл, чанарын баталгаажуулалтын чиглэлээр хамтарсан сургалтад Сургалтын менежер Л.Чингэрэл, Чанарын менежер Э.Шинэжаргал нар хамрагдлаа.






Austausch zwischen Pegnitz, Bayreuth und Asien

Auch optisch ein echter Hingucker – Frühstück in allen möglichen Varianten an der Berufsschule in Pegnitz. Bewirtet wurde eine nicht alltägliche Gästeschar: Rund 20 Besucher aus der Mongolei.

Von Stefan Brand

## БНХАУлсын Өвөрмонголын өөртөө засах оронд “Цахилгаан хангамж”-ийн сургалтад хамрагдсан

БНХАУлсын Өвөр Монголын өөртөө засах орны Шилийн гол аймгийн Шилин хотын Ажил мэргэжлийн сургуульд зохион байгуулагдсан Цахилгаан хангамжийн сургалтад ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллежийн цахилгааны багш Ө.Отгонбат, Ч.Галхүү, сэргээгдэх эрчим хүчний багш И.Ууганбилэг нар нь сургалт сименарт хамрагдсан.

Цахилгаан хангамжийн сургалтад мэргэжлийн боловсрол сургалтын мэргэжлийн боловсролын сургууль, Политехник коллежийн цахилгааны мэргэжлийн 70 багшийн хамтаар 2025 оны 10 дугаар сарын 13-ний өдрөөс 10 дугаар сарын 17-ны хооронд 5 хоногийн хугацаанд Шилийн гол аймгийн Ажил мэргэжлийн сургуулийн цахилгаан хангамжийн сургалтын төвд хамрагдсан.

Сургалтын энхний өдөр 10 дугаар сарын 13-нд сургалтын эхний өдөр тухайн сургуулийн сургалтын орчин материаллаг бааз, түүхийн музейтэй танилцсан.



**Цахилгааны дадлагын стенз**



**Сургуулийн музей**

Сургалтын 2 дах өдөр 10 дугаар сарын 14-нд 35/10кВ-ийн дэд станцын таслалт залгалт хийх дадлагын суурин стенз дээр баг болон хийж гүйцэтгэсэн. Сургалтаар дадлага сургалтад ашиглах схем, сургалтын аргыг эзэмшсэн.

**Суурилуулж угсрагдсан нарны толь**




**35/10кВ-н дэд станцын дадлага ажлын стенз**



**И.Ууганбилэг багш багийн гишүүний хамтаар**

Сургалтын 3 дах өдөр 10 дугаар сарын 15-нд 3 суралцагч баг болж 35/10кВ-ийн дэд станцын зэрэгцээ ажиллагаа сэлгэн залгалт, газардуулга хийх Сургууль дээрх дадлагын сургалтаар схемийг сурагчдад зэрэгцээ ажиллагааны талаар мэдлэг эзэмшүүлнэ.




**Дадлага ажлын стенз**



**Дадлага ажлын явц**

Сургалтын 4 дах өдөр 10 дугаар сарын 16-нд баг болж цахилгаан гэрэлтүүлэг, хөдөлгүүрийн холболт хийж гүйцэтгэсэн. Сургалт явуулахад сууринд дадлагын стенз бидэнд нэн түрүүнд хэрэгтэй байна.



**Ө.Отгонбат багш хөдөлгүүрийн холболт гүйцэтгэж байгаа нь**



**И.Ууганбилэг гэрэлтүүлгийн хэмжилт хийж байгаа нь**

Сургалтын 5 дах өдөр 10 дугаар сарын 17-нд Цахилгаан хангамж мэргэжлийн 5 өдрийн сургалтад амжилттай төгсөж мэргэжлийн гэрчилгээг гардан авсан






**Ангийн сурагчдын хамтаар** **Бидний 3**

БНХАУ-ын Циндао хотод  зохион байгуулагдсан  86 дахь удаагийн Боловсролын тоног төхөөрөмжийн олон улсын үзэсгэлэнд оролцож боловсролын технологийн чиг хандлага, дижитал шийдлүүдтэй танилцлаа. Туршлага судлах энэ аялалыг Монголын Ерөнхий боловсролын сургуулиудын Захирлуудын үндэсний зөвлөлөөс санаачлан “Багш”, “eClass”, “eSchool”, “FTS”, “ECM Их нүүдэл” ХХК зэрэг ерөнхий боловсролын цахим системүүдийн нэгдэл ивээн тэтгэж, санхүүжүүлэв.

Монгол улсаас нийт ерөнхий боловсролын сургуулиудын  Захирал, сургалтын менежер, боловсролын цахм систем хөгжүүлэлтийн компаний төлөөлөл нийт 108 төлөөлөгч оролцсон бөгөөд энэхүү багыг Монголын Ерөнхий боловсролын сургуулиудын Захирлуудын үндэсний зөвлөлийн Тэргүүн МУ-ын Зөвлөх багш М.Туулсайхан ахлан явав.






Шинэлэг тал:

- Байгалийн ухааны сургалтын хэрэглэгдэхүүний дижитал шийдэл
- Эрүүл мэндийн үзлэгийн хяналтын системийн шийдэл
- Шалгалтын материал засдаг төхөөрөмж
- Биеийн тамирын судлагдахуунын AI шийдэл
- Оюутаны хотхон, сургуулийн орчин дахь стресс тайлах хэрэглэгдэхүүн
- AI-тай холбогдсон ухаалаг дэлгэц
- Эргономикийн шаардлага хангасан, дижиталчилсан ширээ

**Хүнд машин механизмын багш Ё.Энхбаяр**

GIZ төслийн хүрээнд MSM компани хамтран Хятад улсыг зорьсон тайлан: SANY GROUP – ЗАМЫН техникийн сургалтад 2026 оны 1 дүгээр сарын 22-ноос 2 дугаар сарын 01-ний өдөр БНХАУ, Sany Group-ийн үйлдвэрлэлийн цогцолбор дээр хамрагдлаа.

Зорилго: Замын техникийн бүтэц, ашиглалт, засвар үйлчилгээний орчин үеийн технологитой танилцаж, практик ур чадвар эзэмших

1. Сургалт явагдсан байгууллагын тухай

Sany Group нь хүнд машин механизмын үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлэгч, "Индустри 4.0" буюу ухаалаг үйлдвэрлэлийн жишиг болсон компани юм. Миний дадлага хийсэн замын техникийн салбар нэгж нь авто зам, гүүр, дэд бүтцийн бүтээн байгуулалтад ашиглагддаг индүү, асфальт дэвсэгч, грейдер зэрэг техникийн дэвшилтэт шийдлээрээ салбартаа түүчээлдэг.

2. Дадлагаар эзэмшсэн ур чадвар

Дадлагажих хугацаанд дараах үндсэн чиглэлүүдээр мэдлэг, туршлага хуримтлууллаа:

- Техник технологи: Замын техникийн гидравлик систем, электрон удирдлагын систем болон ухаалаг мониторингийн технологитой практик дээр танилцав.
- Засвар үйлчилгээ: Техникийн аюулгүй ажиллагаа, оношлогоо болон төлөвлөгөөт засвар үйлчилгээний олон улсын стандартыг судалсан.
- Үйлдвэрлэлийн соёл: Дэлхийн хэмжээний томоохон үйлдвэрийн зохион байгуулалт, хөдөлмөр хамгаалал, чанарын хяналтын тогтолцоотой биечлэн танилцаж туршлага судалсан.

Сургалтын төгсгөлд замын техникийн ашиглалт, оношлогооны онол болон практик шалгалтыг амжилттай өгч, Sany Group-ийн албан ёсны батламжийг гардан авлаа. Энэхүү батламж нь миний мэргэжлийн ур чадварыг олон улсын түвшинд баталгаажуулж буй хэрэг юм.






Багш нарын дотоодын туршлага судлах

- Политехник коллежийн багш ажилчид
- Улаанбаатар хотын Техник технологийн Политехник коллеж болон
- Монгол Солонгосын Политехник коллеж
- Ховд хөгжил Политехник коллеж
- Баян–Өлгий Мэргэжлийн боловсролын сургууль
- Говь-Алтай аймгийн Мэргэжлийн боловсролын сургууль
- Баянхонгор Политехник коллеж
- Дорноговь аймгийн Политехник коллеж сургалтын үйл ажиллагаатай танилцах туршлага солилцох арга хэмжээг зохион байгуулж байна.










Багш нарын мэргэшүүлэх болон боловсролын зэрэг олгох, багшлах эрхийн сургалтуудад хамруулах хүний нөөцийн бодлогын хүрээнд багш нарыг Техник технологийн дээд сургуулийн "БАГШ магистр" хөтөлбөрт хамруулж суралцах гэрээг 3 талаас байгуулсан.





Боловсролын сайдын 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн А/423 дугаар тушаалаар “**Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтанд мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журам”** журам шинэчлэгдэн гарсан. Шалгуурын дагуу арга зүйч нар гаргаж, 2026 онд мэргэжлийн зэргийг ахиулах болон шинээр авах багш нарын мэргэжлийн зэргийн судалгааг гаргаж ажилласан. 2025 оны байдлаар мэргэжлийн зэрэгтэй багш нарын тоо 27 байна. Энэ нь нийт багш нарын 60% юм.

Тушаалын гол заалтуудын нэг нь *2.4."Тэргүүлэх" мэргэшлийн зэргийг 3 удаа, "Зөвлөх" мэргэшлийн зэргийг 1 удаа бататгасан багш, удирдах ажилтны мэргэшлийн зэргийг сургалтын байгууллагад тухайн албан тушаалын үндсэн орон тоонд ажиллах хугацаанд байнгын хүчинтэйд тооцно.*




**Үндсэн сургалтад суусан багшийн мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх сургалтыг зохион байгуулах**

2025 оны 4 дүгээр улирлын байдлаар багшлах эрхийн үндсэн сургалтанд И.Уганбилэг, Ё.Энхбаяр, Ө.Мэндсайхан нар хамрагдаж онлайн даалгаврыг хийж байна.

**Цахим сургалтын чанар үр өгөөжийг дээшлүүлэх**

**Дижитал AI-сургалт**

Багш нарын цахим сургалтыг сайжруулахын тулд дараах ажлуудыг зохион байгуулж ажилласан. Үүнд

- Арга зүйч Г.Өлзиймөнх Дижитал AI-сургалтыг хариуцан багш урьж зохион байгуулсан бөгөөд 29 багш хамрагдсан.
- 2025 оны 9 дүгээр сард БЕГ-т багш нарын судалгааг явуулж, medle.mn хаягтай болгох эхлэлийг тавьсан.
- 2025-2026 оны хичээлийн жилд шинээр элсэлт авсан хосмог сургалтын Төмөр замын мэргэжлийн 2 ангийн хичээл сургалтыг цахимаар зохион байгуулж байгаа бөгөөд U-TVET цахим системд суралцагчдыг бүртгэх, багш, суралцагч нарт тус систем дээр ажиллах талаар сургалт, зааварчилгаа өгч ажиллаж байна.







9 дүгээр сарын 14-нд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан Пийрсон хөтөлбөрийн багш нарыг чадавхжуулах сургалтад багш З. Цэрэндагва, Ч.Зулзага, Ө.Мэндсайхан нар хамрагдсан.






**Tvets.esis.edu.mn системд 2025-2026 оны хичээлийн жилийн шинэ элсэгчийг бүртгэж оруулах**

Шинэ системийн **/tvets.esis.edu.mn/** цахим сургалтад арга зүйч И.Одгэрэл хамрагдаж /tvets.esis.edu.mn/ цахим системд МБОС-ын 2024-2025, 2025-2026 оны хичээлийн жилд элсэлт авсан мэргэжлүүдийн хөтөлбөр, сургалтын төлөвлөгөөг системд шивж оруулж баталгаажуулан суралцагчийг анги бүлэгтэй холбож өгсөн. 41 анги бүлэг үүсгэж бүртгэл хийсэн байна. tvets.edu.mn цахим системд хуучин индексээр элссэн буюу 3 дугаар ангийн 11 мэргэжлийн ангийн 249 суралцагчдын 9, 10, 11 дүгээр сарын ирцийг хянаж баталгаажуулсан.

БАГШ СОЛИЛЦОО ХӨТӨЛБӨР

Монгол-Солонгосын Политехник коллежид хэвлэлийн график дизайн, гагнуурын мэргэжлээр Монгол-Солонгосын Политехник коллежид тус сургуулийн багш Хэвлэл график дизайны мэргэжлийн багш З.Цэрэндагва, гагнуурын чадамжийн төвийн багш Ө.Ганхүлэг нар ажиллалаа. Мөн эксперт багшийн хувьд дэлхийн ур чадварын чиглүүлэх сургалтыг сургуулийн шатны уралдааны шилдэг суралцагчид болон багш нарын дунд 2 удаа зохион байгууллаа. Ингэснээр багшийн заах арга зүй, ноу-хау, туршлагыг залуу багш нарт түгээн дэлгэрүүлж байгаагаараа ач холбогдолтой





Өмнөговь Политехник коллеж-д

Манай сургууль Монгол-Солонгосын Политехник коллеж хамтран багш-инженер солилцоо хөтөлбөрийг зохион байгуулж байна.

Тус сургуулиас Гагнуур, Мэдээллийн технологи мэргэжлийн багш нар ирж сургалтын орчин, дадлагын газруудтай танилцан, мэргэжлийн хөтөлбөр, багш нарын заах арга зүйгээр харилцан туршлага судлахын зэрэгцээ нээлттэй хичээл зааж туршлагаасаа түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулж байна.




## БАГШ АЖИЛЧДЫН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ

“Сургалт, үнэлгээ мэдээллийн систем-г ашиглан сургалтад асран хамгаалагчийн оролцоог нэмэгдүүлэх нь” Сургуулийн түүхэн 60 жилийн ойгоор зохион байгуулсан Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлийг гаргалаа.

Дэлгэрэнгүй мэдээллийг дараах линкээр орж татаж https://upc.edu.mn/news-details/40

Мэргэжлийн сургуульд “олон талт” судлагдахууны хандлагыг бий болгох нь

Илтгэлийн эмхэтгэлийг гаргалаа. Дэлгэрэнгүй файлыг дараах линк дээр дарж хүлээн авч үзнэ үү https://upc.edu.mn/news-details/39




## БАГШ НАРЫН АМЖИЛТ

- Өрөг угсрагчийн мэргэжлийн ур чадварын улсын уралдаанд Политехник коллежийн Барилгын мэргэжлийн багш Г.Мөнхбаяр 3 дугаар байранд орсон амжилт гаргалаа.
- Зүүн болон говийн бүсийн мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын багш нарын дунд зохион байгуулсан “Шилдэг заах арга зүйн” ур чадварын уралдаанд багш Л. Дэмбэрэл 2 дугаар байранд орсон.

- Зүүн болон говийн бүсийн мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын багш нарын дунд зохион байгуулсан “Спортын тэмцээний Волейболын төрөлд эмэгтэй баг 1 дүгээр байранд орсон.








<u>БАГШ АЖИЛЧДЫН НИЙГМИЙН АСУУДАЛ</u>

Багш ажилтны нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд:

- Эрүүл мэндийн багц шинжилгээнд 8 багш, ажилтан хамрагдаж 1 багш хавдартай гарч эмчилгээнд явж одоогоор 70 кодоор ажиллаж байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй 4 багш ажилтан байгаагаас тэргэнцэртэй Автын мэргэжлийн багш Б.Уранзулд хувийн туслахыг гэрээтээр авч цалин олгож байгаа. Оёмол бүтээгдэхүүний мэргэжлийн багш С.Баасанхүүд эмчилгээний хугацаанд цалин хөлсийг бүрэн олгож дэмжлэг үзүүлж байна.
- Манай сургуулийн төгсөгч А.Эрхэмбилэгийг дагалдуулан ажиллуулж ажлын байраар хангасан.
- Хүүхэд асрах чөлөөтэй багш ажилтанд дотоод журмын дагуу 5 алба хаагчид 3,600,000 төгрөгийн тэтгэмж олгосон.
- Мэргэжил дээшлүүлж байгаа Цахилгааны багш Ө.Отгонбатын сургалтын төлбөрт 5,000,000 төгрөгийн дэмжлэг олгосон.
- Шинээр байранд орсон 2, төрийн болон салбарын шагнал 5, өндөр насны тэтгэвэрт гарсан 4 багш ажилчдад байгууллагын үйлдвэрчний эвлэлээс тусламж дэмжлэгийг тус тус олгож ажилласан байна.

Багш нарын хичээлд хяналт тавих зорилгоор Даваа-Баасан гарагт тухайн өдрийн хичээл хянах хариуцлагатай ажилтнаар сургалтын албаны ажилтнуудыг хуваарилан өдөр бүр тэмдэглэгээ хийж ажиллалаа.

Политехник коллеж нь жил бүр багш ажилчдаа нарийн мэргэжлийн шинжилгээнд хамруулж байна. Жил бүр СӨҮЛ эмнэлэгтэй гэрээ байгуулан багш ажилчдынхаа эрүүл мэндэд анхааран ажиллаж байна. Энэ жил 8 багш ажилчдыг шинжилгээнд хамруулснаар эрүүл мэндэд анхаарч аюулт өвчнөөс урьдчилан сэргийлэх боломжийг бүрдүүллээ.






2025 онд Улаанбаатар хотын СӨҮЛ эмнэлэгт нарийн мэргэжлийн шинжилгээ өгөхөөр 6 багш ажилтиныг хамруулахаар шалгаруулсан байна.

1. Биеийн тамирын багш Б.Ганболд
2. Хоол үйлдвэрлэлийн багш Д.Нарантуяа
3. Номын санч Э.Амарбаясах
4. Мэдээлэл технологийн багш С.Сайнхүү
5. Авто механикийн багш Б.Уранзул
6. Нийгмийн ухааны багш Т.Пүрэвцэцэг нар хамрагдахаар боллоо.








**Шагнал:**
Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон-1
Соёлын гавьяат-2
Алтан гадас-2
Хөдөлмөрийн хүндэт медиал-4
Боловсролын тэргүүн-5
Боловсролын жуух бичиг-1
Боловсролын газрын хүндэт тэмдэг-1
Багшийн алдар-1
Арга зүйч багш-2
Аймгийн тэргүүн-6
Аймгийн ЗДЖуух бичиг-3
Нийт бүрдүүлж явуулсан-28
Ажил албан тушаал хавсран гүйцэтгэдэг 13, мэргэшлийн зэрэг 4, мэргэжлийн зэрэг 46 багш ажилтан урамшуулал авч байна.

















Ахмадад ээлтэй буухиа" аяныг 15 сум, 60 байгууллагын дунд 2 дугаар сарын хугацаанд зохион байгуулан АХМАДАД ЭЭЛТЭЙ БАЙГУУЛЛАГЫН дүнг танилцуулж шилдэг хамт олныг шагнаж урамшуулсан. Манай сургууль ШИЛДЭГЭЭР шалгарч БАТЛАМЖАА гардаж авлаа.





Ахмадын баярын өдрийн тохиолдуулан Политехник коллежийн Ахмад захирал, Монгол Улсын Гавьяат багш Ж. Нямсангийн нэрэмжит Ахмад багш нарын "Софт Волейболын тэмцээн"-ийг зохион байгууллаа.

Ахмад багш нараа хүлээн авч сувилалд 5 ахмадын амраасан





## ГОВЬ, ЗҮҮН БҮСИЙН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛСАН ИЛТГЭЛИЙН ТАЙЛАН

2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр Өмнөговь аймгийн Хөгжимт жүжгийн театрт зохион байгуулагдсан илтгэлд 8 аймгийн 8 багийн 17 оролцогч илтгэл бичиж оролцлоо. Сүхбаатар, Өмнөговь, Говьсүмбэр, Дундговь аймгийн мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага багаар (2-7 хүний бүрэлдэхүүнтэй) илтгэл бичиж, Дорнод, Бор-Өндөр, Дорноговь, Хэнтий аймгийн мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагууд ганцаарчилсан байдлаар илтгэл бичиж оролцлоо.

*Багийн илтгэлийн сэдэв, илтгэгчийг аймаг бүрээр хүснэгтээр харуулбал:*

| № | Аймаг | Илтгэлийн нэр | Илтгэгч |
|---|---|---|---|
| 1 | Дорнод | Асуудал ба үйл ажиллагаанд чиглэсэн сургалтаар суралцагчдын зөөлөн ур чадварыг нэмэгдүүлэх нь | Б. Уянга |
| 2 | Сүхбаатар | Интеграцийн ач холбогдлыг илрүүлж, интеграцийг сургалтын үйл ажиллагаанд нэвтрүүлэх боломжийг эрэлхийлэх | Х. Гэрэлмаа |
| 3 | Өмнөговь | Хичээлийг интегралчлах арга зам, үр дүн | Ч. Зулзага |
| 4 | Бор-Өндөр | Интеграц хичээл түүнд хийсэн шинжилгээ | Б. Энхчимэг |
| 5 | Дорноговь | Суралцахуй ба суралцах чадамж | Б. Батцэцэг |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | Хэнтий | Интеграцид суурилсан багшлахуй ба суралцахуй | Б. Ичинхорол |
| 7 | Говьсүмбэр | Суралцагчдыг мэргэшлийн үндэсний шатлалын түвшинд хүргэх боломжийг интеграц хичээлээр дэмжих асуудалд | Д. Нямцогт |
| 8 | Дундговь | "Миний мэргэжил-Миний байшин" төсөлт даалгавраар дамжуулан интеграц хичээлийг хэрэгжүүлэх нь | Ө. Дэлгэрмөрөн |

Илтгэлийг Үйлдвэр Урлалын Политехник коллежийн Захирал, МУ-ын зөвлөх багш Д.Буяндэлгэр, Техникийн болон мэргэжлийн боловсролын инновац судалгаа хөгжлийн төв ТББ-ын Захирал, МУ-ын зөвлөх багш Ё.Бадамхатан, Өмнөговь аймгийн Боловсролын газрын сургалт судалгаа арга зүйн хэлтсийн дарга Б.Шинэбаяр нар шүүж, хэлэлцүүлэг зөвлөмж өгч ажилласан. Илтгэлийг 5 үндсэн шалгуурын хүрээнд 24 үзүүлэлтээр 100 оноогоор үнэлсэн. Үүнд:

1. Онол, арга зүйн үндэслэл, шинэлэг үзэл санааг тусгасан байдал-24 оноо
2. Мэдээлэл, үр дүнгийн боловсруулсан байдал-28 оноо
3. Илтгэлийг бүтэцчилсэн байдал-8 оноо
4. Хэл найруулга, техникийн шаардлага хангасан байдал-12 оноо
5. Илтгэх чадвар-28 оноо

Шилдэг илтгэгчийг мөн шалгаруулсан.

*Үр дүн хүснэгтээр харуулбал:*

| № | Аймаг | Багш, багийн нэрс | Илтгэгчийн нэр | Д. Буяндэлгэр | Ё. Бадамхатан | Б. Шинэбаяр | Дундаж | Байр |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Дорнод | **Б. Уянга** | Б. Уянга | 83.5 | 69 | 61.5 | 71.3 | IV |
| 2 | Сүхбаатар | Х. Гэрэлмаа Д. Нямсүрэн | Х. Гэрэлмаа | 84.5 | 72 | 64 | 73.5 | III |
| 3 | Өмнөговь | Ч. Зулзага З. Цэрэндагва | Ч. Зулзага | 76.5 | 65 | 52.5 | 64.7 | VII |
| 4 | Бор-Өндөр | Б. Энхчимэг | Б. Энхчимэг | 77.5 | 74 | 57.5 | 69.7 | V |
| 5 | Дорноговь | Б. Батцэцэг | Б. Батцэцэг | 74 | 76 | 53.5 | 67.8 | VI |
| 6 | Хэнтий | Б. Ичинхорол | Б. Ичинхорол | 66.5 | 60 | 50.5 | 59.0 | VIII |
| 7 | Говьсүмбэр | А. Шинэбаяр Д. Нямцогт | Д. Нямцогт | 84 | 74 | 63.5 | 73.8 | II |
| 8 | Дундговь | Эв хамт | Ө. Дэлгэрмөрөн | 87.5 | 82 | 80 | 83.2 | I |

Илтгэл тавигдсаны дараа 15:00 цагт хичээлийн 1 дүгээр байрны 310 тоот танхимд хэлэлцүүлэг зохион байгуулж, шүүгч нар зөвлөн тусалсан.

**Илтгэлийн уралдаанд:**

1 дүгээр байрт Дундговь аймгийн “Эв хамт баг”

2 дугаар байр Говьсүмбэр аймаг

3 дугаар байр Сүхбаатар аймаг

Шилдэг илтгэгчээр Дорнод аймгийн багш н.Базарвааний Уянга тодорлоо.

Зургуудаас:









## ГОВЬ БОЛОН ЗҮҮН БҮСИЙН "ШИЛДЭГ ЗААХ АРГА ЗҮЙТЭЙ БАГШ” ШАЛГАРУУЛАХ УРАЛДААН

Багшийн заах арга зүйн ур чадварыг нэмэгдүүлэх, туршлага солилцох, сургалтын бүтээлч аргуудыг түгээн дэлгэрүүлэх зорилготой уралдаанд Говийн болон зүүн бүсийн МБСБ-ын багш нарын дунд зохион явуулсан “Шилдэг заах арга зүйтэй багш” шалгаруулах уралдаанд 8 аймгийн МБСБ-ын

- Гагнуурчин
- Оёмол бүтээгдэхүүний оёдолчин
- Хэвлэлийн график дизайн
- Автомашины засварчин
- Барилгын засал чимэглэлчин
- Цахилгаанчин давхардсан тоогоор 6 мэргэжлийн 8 багш өрсөлдөв.

Заах аргын уралдааны шүүгчийн бүрэлдэхүүнд:

- Үйлдвэр Урлалын Политехник коллежийн Захирал, МУ-ын Зөвлөх багш зэрэгтэй Д. Буяндэлгэр
- Техникийн болон мэргэжлийн боловсролын инновац судалгаа хөгжлийн төв ТББ-ын Захирал, МУ-ын багш зэрэгтэй Ё.Бадамхатан
- Өмнөговь аймгийн Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн Захирал, МУ-ын Зөвлөх багш зэрэгтэй Г.Шүрцэцэг нар ажиллав.

Уралдааныг 7 дэд, 22 шалгуураар үнэлэв.

- Эхлэл, удиртгал
- Агуулга
- Арга зүй
- Хэрэглэгдэхүүн
- Хугацаа
- Харилцаа
- Үнэлгээ, дүгнэлт

Шүүгчдийн дундаж дүнгээр:

1. Дорноговь аймгийн Политехник коллежийн, Хэвлэлийн график дизайн мэргэжлийн багш Б.Санжаа "Өнгөний зүй тогтол CMYK болон RGB өнгөний ялгааг таних " ээлжит хичээлээр ТЭРГҮҮН байр
2. ШУТИС-ын Өмнөговь аймаг дахь ТДС-ын харьяа политехник коллежийн Гагнуурчин мэргэжлийн, Тэргүүлэх багш зэрэгтэй Л. Дэмбэрэл Цахилгаан гар нуман гагнуур чадамжийн нэгжийн "Цахилгаан гагнуураар PF (босоо) байрлалд 10мм хавтан гагнах" ээлжит хичээлээр ДЭД байр
3. Дундговь аймаг дахь Политехник коллеж Оёмол бүтээгдэхүүний оёдолчин мэргэжлийн Тэргүүлэх багш зэрэгтэй Б.Цэцэгноров "Наран юбканы суурь үлгэр байгуулах" ээлжит хичээлээр ГУТГААР байр эзэлсэн амжилтууд үзүүлсэн.

## ӨМНӨГОВЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН

1 Ерөнхий мэдээлэл:

Энэхүү тайлан нь Өмнөговь Политехник Коллежийн 2025–2026 оны хичээлийн жилийн 2025 оны 9 дүгээр сараас 12 дугаар сар хүртэлх хугацаанд хэрэгжүүлсэн

хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнг нэгтгэн дүгнэсэн болно.

2. Хууль, эрх зүйн үндэслэл
- хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
- коллежийн дотоод журам
- ХАБЭА-ны дүрэм, заавар

3. ХАБЭА-ны зохион байгуулалт

Коллеж нь ХАБЭА-ны зөвлөл, хариуцсан ажилтнаар дамжуулан сургалтын болон дадлагын орчинд аюулгүй ажиллагааг хангаж ажилласан.

4. Сургалт, зааварчилгаа
- багш, ажилтанд ХАБЭА-ны ерөнхий зааварчилгаа – 2 удаа
- суралцагчдад дадлага эхлэхийн өмнөх зааварчилгаа – 100 хувь
- онцгой байдлын үед авах арга хэмжээний сургалт – 1 удаа

5. Эрсдэлийн үнэлгээ, хяналт шалгалт
- дадлагын газруудад эрсдэлийн үнэлгээг шинэчлэн хийсэн
- илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг авсан
- сургуулийн хашаа, тээврийн хөдөлгөөний хяналтыг сайжруулсан

6. Ослын болон зөрчлийн мэдээлэл

Тайлант хугацаанд үйлдвэрлэлийн ноцтой осол, хөдөлмөрийн чадвар алдалт бүртгэгдээгүй.

7. Эрүүл ахуйн арга хэмжээ
- анги танхим, дадлагын газрын цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт
- хоол үйлдвэрлэлийн эрүүл ахуйн хяналт
- ус, ариун цэврийн байгууламжийн хяналт

8. Дүгнэлт

Тайлант хугацаанд коллежийн ХАБЭА-ны үйл ажиллагаа тогтвортой хэрэгжиж, осол гэмтэлгүй, аюулгүй орчныг хангаж ажилласан.

9. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ
- ХАБЭА-ны сургалтыг тогтмол зохион байгуулах
- аюулгүй ажиллагааны тэмдэг, тэмдэглэгээг нэмэгдүүлэх
- хяналт, бүртгэлийн тогтолцоог сайжруулах

## ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

**1. Нийтлэг үндэслэл**

Өмнөговь Политехник коллеж нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, холбогдох дүрэм журам, стандартуудыг мөрдөн ажиллахын зэрэгцээ суралцагч, багш ажилтан, дадлагажигчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор 2025–2026 оны хичээлийн жилийн 9–12 дугаар сарын хугацаанд дараах төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллалаа.

Тус тайлан нь дээрх хугацаанд ХАБЭА-н чиглэлээр хэрэгжүүлсэн ажлууд, гарсан үр дүн, цаашид анхаарах асуудлыг нэгтгэн дүгнэсэн болно.

2. Гэнэтийн ослын даатгалын хамрагдалт

Суралцагчдыг үйлдвэрлэлийн болон сургалтын орчинд гарч болзошгүй гэнэтийн

осол, эрсдэлээс хамгаалах зорилгоор 2025 оны 9 дүгээр сараас эхлэн нийт ангийн суралцагчдыг гэнэтийн ослын даатгалд хамруулах ажлыг зохион байгуулсан.
- нийт хамруулах зорилтот бүлэг: Коллежийн бүх ангийн суралцагчид
- хэрэгжилтийн байдал:
- 2025 оны 12 дугаар сарын байдлаар нийт суралцагчдын 70 хувь гэнэтийн ослын даатгалд хамрагдсан.
- үлдсэн хувийг хамруулах ажлыг дараагийн улиралд үе шаттай үргэлжлүүлэхээр төлөвлөсөн.

Даатгалд хамрагдсанаар суралцагчдын эрсдэлд өртөх үед санхүүгийн болон эрүүл мэндийн хамгаалалт нэмэгдэж, эцэг эх, асран хамгаалагчдын итгэл, оролцоо сайжирсан зэрэг үр дүн гарсан.

3. Үйлдвэрлэлийн дадлага болон гадна засварын үеийн аюулгүй ажиллагаа

3.1 Үйлдвэрлэлийн дадлагын үеийн зааварчилгаа

2025–2026 оны хичээлийн жилийн эхний хагас жилд үйлдвэрлэлийн дадлагад гарсан нийт суралцагчдад ХАБЭА-н дараах зааварчилгааг тогтмол өгч ажилласан.
• Анхан шатны аюулгүй ажиллагааны зааварчилгаа
• Ажлын байрны онцлогт тохирсон зааварчилгаа
• Дадлагын явцад мөрдөх хөдөлмөр хамгааллын шаардлага
• Осол, эрсдэл үүссэн тохиолдолд авах арга хэмжээ

Зааварчилгааг дадлага эхлэхээс өмнө болон дадлагын явцад давтан өгч, бүртгэлжүүлэн хяналт тавьж ажилласан.

3.2 Гадна засвар, үйлчилгээний ажлын үеийн хяналт

Сургуулийн барилга байгууламж, гадна тохижилт, засварын ажилд хамрагдсан нийт багш, ажилтан, суралцагчдад:
• Ажил эхлэхийн өмнөх ХАБЭА-н зааварчилгаа
• Өндөр болон гадна орчинд ажиллах үеийн аюулгүй ажиллагааны шаардлага
• Нэг бүрийн хамгаалах хэрэгслийн хэрэглээ зэрэг зааварчилгааг тогтмол өгч, хяналт шалгалтыг хариуцсан албан тушаалтнууд хэрэгжилтийг газар дээр нь шалган ажилласан.

4. ХАБЭА-н бичиг баримт,журам шинэчлэл 2025-2026 оны хичээлийн жилийн эхэнд ХАБЭА -н бичиг баримтын иж бүрэн үнэлгээг хийж, хүчин төгөлдөр мөрдөж буй журам, зааврууудыг дахин хянав.

- Нийт ХАБЭА-н журмуудыг шинэчлэн боловсруулж, байгууллагын онцлогт нийцүүлэн сайжруулсан
- Хэрэгжилт сул байсан заалтуудад нэмэлт өөрчлөлт оруулсан
- Шинээр шаардлагатай 3-5 журам (жишээ нь:гадна орчинд ажиллах аюулгүй ажиллагаа, сургалтын дадлагын ХАБЭА, эрсдэлийн удирдлагын журам гэх мэт)-ыг боловсруулан баталж , хэрэгжүүлж эхэлсэн

Эдгээр ажлын үр дүнд ХАБЭА-н баримит бичгийн уялдаа сайжмрч, хэрэгжилт бодитой болсон.

5.Галын аюулгүй байдлын хүрээнд хийсэн ажлууд:

Галын аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор дараах ажлуудыг хэрэгжүүлсэн.

5.1 Галын дохиолол,мэдрэгч

- Сургуулийн анги танхим, албан өрөөнүүдэд утаа мэдрэгч суурилсан
- Байршлыг галын эрсдэлийн түвшинг харгалзан тогтоосон

5.2 Гал унтраах хэрэгсэл, нөөц

- Галын хорыг хугацаанд нь цэнэглэж, ашиглалтын бэлэн байдлыг хангуулсан
- Шаардлагатай газруудад гал унтраах хэрэгслийн тоог нэмэгдүүлсэн
- Галын аюулгүй байдлын нөөц хэрэгслийг бүрдүүлж, тогтмол шалгалт хийж байна

5.3 Галын дүгнэлт, төлөвлөгөө

- Сургуулийн хэмжээнд галын дүгнэлт гаргуулсан
- Гал унтраах, нүүлгэн шилжүүлэх шуурхай төлөвлөгөөг мэргэжлийн байгуулагатай хэмтран боловсруулж байна

6. Эрсдэлийн үнэлгээ, хэрэгжилт

Сургуулын хэмжээнд сургалтын байр, дадлагын газар, албан өрөө, гадна орчны эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн.

- Илэрсэн эрсдэлийг ангилж, түвшинг тогтоосон
- Үр дүнд үндэслэн шаардлагатай засвар, зохион байгуулалтын арга хэмжээг цаг тухайд нь авч хэрэгжүүлсэн
- Эрсдэлийн үнэлгээг бодит нөхцөл байдалтай уялдуулан шинэчилж байна

7. Дүгнэлт, цаашид авах арга хэмжээ

2025-2026 оны хичээлийн жилийн 9-12 дугаар сарын хугацаанд ХАБЭА-н чиглэлээр төлөвлөсөн ажилуудыг үе шаттайгаар хэрэгжүүлж, бодит үр дүнд хүрсэн. Цаашид:

- Гэнэтийн ослын даатгалын хамрагдалтыг 100 хувь хүргэх
- Суралцагч, багш, ажилтны ХАБЭА-н мэдлэг, хандлагыг тогтмол сургалтаар нэмэгдүүлэх
- Галын болон бусад ослын үед бэлэн байдлын сургуулалтыг тогтмол зохион байгуулах
- Эрсдэлийн үнэлгээ, хяналтыг тасралтгүй сайжруулах зэрэг ажлуудыг үргэжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй, тохируулгат орчныг бүрдүүлэх

Сургуулийн гадна орчны зам талбайг засварласан. Авто засварын дадлагын байр, 00-н засвар, хичээлийн 3 дугаар  байрны гадна хаалгыг солих, ХБИ явах зам сайжруулах ажлыг “GIZ”-н төслийн 7,1 сая төгрөгийн санхүүжилтээр хийж байна







**Анги танхим, дадлагын газар**

Тус сургуулийн нийт 42 анги кабинет дадлагын газар

- Онолын 29 анги танхим,
- 13 дадлагын газар
- 4 лабораторид

Үүнээс 12 кабинетийн ширээ сандал шинэчилсэн

- ширээ сандал
- одоо 75 ширээ сандал хийж байна.
- 17 анги дэлгэцээр,
- 20 анги проектороор,
- 24 анги өнгөт, хар болон 3 үйлдэлт скайнер, канон, принтерээр, анги бүр суурин болон зөөврийн компьютерээр хангагдсан байна.

Нийт 10 Дадлагын газарт Тоног төхөөрөмж 518 , Багаж хэрэгсэл 2435 ш нөөцтэй байна.

| № | Лаборатори | Тоног төхөөрөмжийн төрөл | Багаж хэрэглийн тоо |
|---|---|---|---|
| 1 | Хийн шингэн гидравликийн лаборатори | 5 | 63 |
| 2 | Токарийн лаборатори | 61 | 58 |
| 3 | Цахилгааны лаборатори | 21 | 16 |
| 4 | Комьпютерийн лаборатори | 84 | 0 |
| | Нийт | 171 | 137 |

*Одоо анги танхимд ашиглаж байгаа тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, нөөц* нийт 20 анги танхимд тоног төхөөрөмж, 83 багаж хэрэгсэл байна.

# Засвар хийж тохижуулсан анги танхимууд









Сургалтын орчинг сайжруулахад өөрсдийн нөөцийг ашиглаж 50 ширээ сандал хийж сургалтад ашигласан.
Гагнуурын мэргэжлийн багш Л.Дэмбэрэл, багш Б.Чухал нарын удирдлага дор тус мэргэжлийн ангийн суралцагчид сургуулийнхаа онолын кабинетын ширээ сандлыг хийж 10 ангид хүлээлгэн өглөө.




Дотуур байрны орчинг сайжруулахад өөрсдийн нөөцийг ашиглаж 120 хүүхдийн 2 давхар 60 ор хийсэн. Гагнуурын мэргэжлийн багш Ө.Ганхүлэг, Л.Дэмбэрэл нар мэргэжлийн ангийн суралцагчид сургуулийнхаа дотуур байранд хүлээлгэн өглөө.






Өмнө нь


Дараа нь






Өмнө нь


Дараа нь




















“ХАСLAB” ТӨСӨЛ, хас банкны санхүүжилтээр ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллежид компьютерын лабораторийг шинээр байгууллаа.











# САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2024 оны өөрийн орлого бүрдүүлэх бизнес төлөвлөгөөг боловсруулах

Сургуулийн үндсэн үйл ажиллагаанаас бусад орлогын зарцуулалт нь байгууллагын санхүүгийн менежментийг дэмжих, хэмнэлт, үр ашигтай зардал гаргалт хийхэд чиглэсэн байдаг. Түүнчлэн, зарцуулалт нь сургалтын үйл ажиллагаа, сургуулийн чанарыг сайжруулахад мөн түүнчлэн олон нийтийн түншлэл, нийгмийн оролцоог бэхжүүлэхэд зориулагдсан байдаг.

Тус байгууллага нь үндсэн үйл ажиллагаанаас бусад ажил үйлчилгээгээр багш, ажилтнууд, суралцагчдынхаа нөөц боломжийг ашиглан мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх, захиалгат сургалтуудыг зохион байгуулах, үйлдвэр сургалтын хичээлээр захиалгат бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх замаар бусад орлогыг бүрдүүлдэг.

УИХ-ын Байнгын хорооны дарга Р.Сэддоржийн санаачлагаар хэрэгжүүлж буй Өмнөговь аймгийн Засаг даргын "Өсөлттэй Өмнөговь" хөтөлбөрийн хүрээнд "Үдийн хоол" хөтөлбөр Өмнөговь Политехник коллежид хэрэгжиж эхэллээ.

Тус сургуулийн 10,11,12 дугаар ангийн сурагчдын үдийн хоол 4500 төгрөг, Дотуур байрны сурагчдын хоолны нэг хүүхдийн хоолны зардалд 3000 төгрөг нэмэгдүүлж өгсөн.

Өмнөговь Политехник коллежийн 10-12 дугаар ангийн бүх хүүхдүүд хамрагдаж байна.

Үдийн хоол олгох зохион байгуулалт засвар үйлчилгээ тоног төхөөрөмжийн хүртээмжийг нэмэгдүүлж ажиллаж байгаа бөгөөд тус сургуулийн Хоол үйлдвэрлэлийн мэргэжлийн анги багш суралцагчид хийж гүйцэтгэж байна.







Өмнөговь аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Уг барилга нь орчин үеийн загвар шийдэлтэй, тэнхлэгээрээ (10мх18м) хэмжээтэй 1 давхар гал тогооны өргөтгөлийн барилга байна.

- Гал тогоо (халуун)
- Хүнсний агуулах, хүйтэн
- Нарийн боов, гурилан бүтээгдэхүүн бэлтгэх өрөө
- Хувцас солих өрөө
- Ариун цэврийн өрөө (2 ш)
- Багшийн суух албан өрөө
- Хоолны бэлтгэл өрөө,
- Бохир, цэвэр  угаалгын хэсэг
- Тоног төхөөрөмж бусад дагалдах өрөөнүүд төлөвлөх (нормоор)

Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газраас  220 сая төгрөгийн санхүүжилтээр хичээлийн 1 байрны дулааны сангийн ажилд их засвар хийгдсэн.







Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газраас 20,000,000 төгрөгийн 14 ширхэг гадна камер  Үүнээс: 360 градусын эргэлттэй 1 ширхэг камерийг спорт заалны дотор талд, хичээлийн 1,4 дүгээр байрны дээвэр, сангийн 424,917,000 төгрөгийн ажлуудыг энэ жилд шийдвэрлэж өгсөн.

Европын холбооны ХАБ төслийн хүрээнд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ангийг бүрэн тохижуулж, сургалтын хэрэгцээнд шаардлагатай тоног төхөөрөмж,

техник хэрэгслээр бүрэн хангаж, сургалтын орчны чанар, хүртээмжийг сайжруулахад бодитой дэмжлэг үзүүллээ. Үүнд:

- суурин компьютер 10 ширхэг,
- 65 инчийн дэлгэц 1 ширхэг, д
- уу хэмжигч багаж 10 ширхэг,
- гэрэл хэмжигч багаж 10 ширхэг,
- агаарын найрлага хэмжигч багаж 5 ширхэг,
- тоног төхөөрөмжийн хэмжигч багаж 10 ширхэг,
- камерын хөл 1 ширхэг,
- камер 1 ширхэг,
- өнгөт принтер 1 ширхэг,
- notebook 2 ширхэгийг хүлээн авч
- Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газраас 19,490,000 төгрөгийн зөөврийн 5 ширхэг компьютер
- Боловсролын Ерөнхий газраас оёдлын ангид 7,546,000 төгрөгийн 5 төрлийн оёдлын машин
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 15,0 сая төгрөгийн үнэ бүхий сонота-NF6 маркийн 3 ширхэг авто машин

Нэмэлт орлого бүрдүүлэх төлөвлөлтийг оновчтой зохион явуулахаар “Бизнес төлөвлөгөө боловсруулах төслийн баг”-ийг Захирлын 2024 оны 03 дугаар сарын 29-ний А/52 тоот тушаалаар баталж төлөвлөгөө боловсруулах ажлыг зохион явуулж байна. 2024 онд байгууллага нийт 1,145.8 сая төгрөгийн өөрийн орлого бүрдүүлж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад: 266.5 сая төгрөгөөр нэмэгдэж, 30.3%-ийн өсөлт үзүүлсэн байна.

2024 оны санхүүгийн төлөвлөгөөний дагуу байгууллага нь нийт 1,145.8 сая төгрөгийн нэмэлт орлого бүрдүүлсэн байна.

Орлогын бүтэц:

1. Жолооны сургалтын төлбөр – 173.5 сая төгрөг
2. АЗДТГ 572.0 сая төгрөг

3. “Оюу толгой” ХХК-аас орсон орлого – 180.4 сая төгрөг, гагнуурын 1 жилийн сургалт 52.8 сая төгрөг Топ-3 14.5 сая төгрөг, бүртгэлийн хураамж 5.3 сая төгрөг, бусад богино хугацааны сургалт 17.3 сая төгрөг нийт 1015.8 сая төгрөгийн нэмэлт орлого бүрдүүлсэн байна.

Нийт орлого нь байгууллагын үндсэн үйл ажиллагааны болон гадаад хамтын ажиллагааны үр дүнд төлөвлөсөн орлогоос давсан үзүүлэлттэй байна. Үүний үр дүнд:

• Сургалтын материаллаг баазыг сайжруулах;
• Суралцагчдын сургалтын чанарыг нэмэгдүүлэх;
• Байгууллагын урт хугацааны санхүүгийн тогтвортой байдлыг хангах боломж бүрдэж байна;

Цаашид байгууллагын хөрөнгө оруулалт, орлогын эх үүсвэрийг төрөлжүүлэх чиглэлээр үргэлжлүүлэн ажиллана.




БАРАА МАТЕРИАЛ, ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ГҮЙЛГЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ




Үндсэн хөрөнгө актлах, дахин үнэлэх 2025

1. 9139 нэрийн 21,031.0 сая төгрөгийн ном акталж устгалд оруулсан
2. 128 нэрийн 105,800.0 мянган төгрөгийн хөрөнгө акталав
3. 298 нэрийн 1,059,977.0 төгрөгийн хөрөнгийг үнэ шинэчлэн тогтоож дахин үнэлэв.
4. 3 нэрийн автоманыг дуудлага худалдаагаар худалдаалах баримт бичиг хуулийн заалтын бүрдүүлж, дуудлага худалдаа хийх зарыг байршуулсан


Орлого зарлагын гүйлгээ
35000
30000
25000
20000
15000
10000
5000
0
12813
26588
29720
9 сар
10 сар
11 сар


Хичээл дадлагын материалын зардал
450000
400000
350000
300000
250000
200000
150000
100000
50000
0
205982.4
308439.5
390440.2
2022
2023
2024

# Төрийн өмчийн тооллогийн цахим систем

Цахим системд 7,633,963,,271 төгрөгийн хөрөнгийн зураг оруулж бүртгэх ажлууд хийсэн

| Газар | Тавилга эд хогшил | Барилга байгууламж | Машин тоног төхөөрөмж | Тээврийн хэрэгсэл | Биет бус |
|---|---|---|---|---|---|
| 3 нэр төрлийн 397,467,500 | 2210 нэр төрлийн 366,575,928 | 1818 нэр төрлийн 4,135,973,874 | 1387 нэр төрлийн 2,138,960,598 | 11 нэр төрлийн 364,209,837 | 7 нэр төрлийн 1,692,000 |

**Худалдан авах үйл ажиллагаа**

Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсан тендерийн ажлууд:

- 2024 онд дотуур байрны хүүхдийн хоолны материал дээр 3-н багцаар 3 удаа, тоног төхөөрөмж худалдан авахад 2 багцаар 2 удаа зарлагдаж 1 удаагийн Сангийн яамнаас ирүүлсэн гомдолын дагуу ажиллаж дахин зарлаж дуусгасан. 92,408,790₮
- 2025 онд дотуур байрны хүүхдийн хоолны материал дээр 3-н багцаар 3 удаа, хичээл сургалтын тоног төхөөрөмж худалдан авах 1 багцаар, жолооны сургалтын автомашин худалдан авах 1 тендер шалгаруулалтыг хийж гүйцэтгэсэн 303,569,000

# Нийгмийн даатгалын цахим систем

Нийгмийн даатгалын тайланг сар бүр цахим системд оруулан баталгаажуулалт хийдэг

| 9 сар | 10 сар | 11 сар | 12 сар | ХЧА /нийт/ |
|---|---|---|---|---|
| 87 даатгуулагч 68,663,114 төгрөгийн шимтгэл | 89 даатгуулагч 74,250,102 төгрөгийн шимтгэл | 91 даатгуулагч 99,280,600 төгрөгийн шимтгэл | 107 даатгуулагч 149,375,056 төгрөгийн шимтгэл | 7 ажилтаны хуудасыг тооцоолж илгээсэн |

# Хэрэгжиж буй төсөл хөтөлбөр

*Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн насан туршийн боловсролын сургалт*









**Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн насан туршийн боловсролын сургалт**

Европын холбооны Ерасмаусын төсөл

Төслийн хүрээнд ХАБЭА н ойлголтын талаар мэдээлэл солилцох пэйж хуудасыг ажиллуулж байна.

Европын Грек, Итали улсад 4 багш ажилтныг сургалтад хамруулсан

## Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн насан туршийн боловсролын сургалт

**Төслөөр зохион байгуулах ажлууд**

Манай сургууль нь үйлдвэр, аж ахуйн газрын ажилтнууд болон сонирхогчдод дараах чиглэлээр сургалт явуулна.

- ХАБЭА-н ажилтны сургалт
- ХАБЭА-н нийт ажилтны сургалт
- Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний багаж ашиглах сургалт

3L4MOHS: Төслийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл
https://3l4mohs.com/
#Safety #erasmus #digitallearning #mongolia



## Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн насан туршийн боловсролын сургалт

Цахим сургалтын ангийн Компьютер, техник тоног төхөөрөмж, анги танхимыг тохижуулан сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах боломжийг бүрдүүлээд байна.









## Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн насан туршийн боловсролын сургалт

Цахим сургалтын ангийн Компьютер, техник тоног төхөөрөмж, анги танхимыг тохижуулан сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах боломжийг бүрдүүлээд байна.









## "ХММ-ын салбарт жендэрийн мэдрэмжтэй хосмог сургалтыг нэвтрүүлснээр эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх нь"төсөл

"Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг" Германы засгийн газар,

- Монгол улсын Боловсролын яам,
- Трансвест ХХК,
- MSM ХХК,
- Sandvik ХХК Хамтарсан хөрөнгө оруулалтаар Өмнөговь Политехник коллеж,
- Налайх дахь Политехник коллежуудад энэхүү төсөл хэрэгжиж байна.

Төслийн зорилго нь Хүнд машин механизмын салбарт жендэрийн мэдрэмжтэй хосмог сургалтыг амжилттай хэрэгжүүлсэн байх юм.










## Хүнд машин механизмын техникчийн ангийн сурагчидтай компаниуд гэрээ байгуулав















БОЛОВСРОЛЫН ЯАМ
БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
ХӨГЖИЛ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ
МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН
БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГУУДЫН
АЖИЛТНЫ






МАРАФОН
7КМ
ГҮЙЛТ
БАГШ, УДИРДАХ АЖИЛТНЫ
НӨХӨРСӨГ ТЭМЦЭЭН-2025






Pearson










EXPLORE
THE WORLD










БАГАЖ ХЭРЭГСЭЛ




ӨМНӨГОВЬ






ДОРНОД ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ
ДУНДГОВЬ
ГОВЬ, ЗҮҮН БҮСИЙН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН


ГОВЬ, ЗҮҮН БҮСИЙН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН




ДОРНОД
ПОЛИТЕХНИК
КОЛЛЕЖ
ДУНДГОВЬ
ГОВЬ, ЗҮҮН БҮСИЙН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН




ГОВИЙН БОЛОН ЗҮҮН БҮСИЙН
ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ
БАЙГУУЛЛАГЫН УУЛЗА






ӨМНӨГОВЬ






ӨМНӨГОВЬ
ДОРНОД ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ
ГОВЬ, ЗҮҮН БҮСИЙН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ТУРШЛАГА СОЛИЛЦОХ УУЛЗАЛТ, ОЮУНЫ БОЛОН СПОРТЫН АР
ХЭМЖЭЭ НЭЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
2025 оны 4 сарын 17
Даланзадгад хот
Зохион байгуулагч: ШУТИС-ийн
Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа
Магадлан итгэмжлэгдсэн Политехник коллеж




ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ПОЛИТЕХНИКИЙН КОЛЛЕЖИЙГ
"ХҮНД МАШИН МЕХАНИЗМ, ЦАХИЛГААНЧИН, ГАГНУУРЧИН"-НЫ
МЭРГЭЖЛЭЭР СУРАЛЦАН ТӨГСӨЖ БУЙ ТӨГСӨГЧДӨД
МЭРГЭЖЛИЙН ҮНЭМЛЭХ ГАРДУУЛАХ
ЁСЛОЛЫН АРГА ХЭМЖЭЭ












15
ГАГНУУР
ЦАХИЛГААН ГАГНУУР
БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
9
8
ЦАХИЛГААН ГАГНУУР
ЦАХИЛГААН Г


Khan Uul
HOTEL & SUITE
ШАНХАЙ АЯЛАХ
ШАНХАЙ АЯЛАХ
ШАНХАЙ АЯЛАХ






Багш өөрийгөө хөгжүүлсэн байдал


Хагас жилийн ажлын тайлан
Удирдлагын өгсөн үүрэг даалгавар, бусад


- Ул уурхайн машин механизмын угсралт засв
шалгуур 6 нотолгооны бичиг баримтын бүрдүү
- ББУ-БШХЗЧ мэргэжлийн хөтөлбөрийг Дарха
сургуулийн хөтөлбөрийг авч харьцуулалт хийн
01


ЗОРИЛТ
БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ ТӨЛ
ЭЛСЭЛТИЙГ ҮР ДҮНТЭЙ ЗОХИОН БАЙГУУЛА
ХОСМОГ СУРГАЛТЫГ ҮР
ТҮНШЛЭЛ ХАМТЫН АЖИЛЛАГААГ БЭХЖ
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН СУРГАЛТ, ДАДЛАГЫН АЖЛЫН ЧАН
ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛ
МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛ
ӨӨРИЙГӨӨ ХӨГЖҮ
ШИНЭЭР САНААЧИЛСАН АЖИЛ
НИЙГЭМД ЧИГЛЭСЭН БОЛОН БАЙГУУЛЛАГЫН НИЙТИЙГ ХАМ


2025-2026 оны хи
жилийн хагас жили
тайлан
Англи хэлний ба
ENGLISH


Сургалтын үнэл
нийцүүлэн дара
Үүнд:
• Явцын үнэлгээ
• Бие даалт
• Дадлагын ажил
• Багийн ажил
• Идэвх оролцоо
• Сэдэвчилсэн ша
• Хичээл бүрийн
• Практик гүйцэт
• Ээлжит шалгал
• Онолын мэдлэг
• Дадлагын ур ча
Шалгалт, үнэлг
• Батлагдсан ша
• Үнэлгээний ша




CERTIFICATE OF TRAINING




ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
WorldSkills
Mongolia
8


БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
8


worldskills
Mongolia






ӨМНӨГОВЬ
7


EXIT
Oyu Tolgoi










TRANSMISSION IN FIRST GEAR


UNIVERSIDAD DE CÁDIZ
FACULTAD DE CIENCIAS DE LA EDUCACIÓN






"УНИВЕРСИАД - 2024"
РГА-2025


ОРДОН
ӨМНӨГОВЬ


УТГИЙН УДИРДЛАГЫН ОРДОН
ӨМНӨГОВЬ